



ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ
АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШЛ



Эмнести Интернэшнл нь хүн бүрийн эрхийг эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа өрнүүлэн ажилладаг 7 сая гаруй гишүүн дэмжигчтэй даян дэлхийн хөдөлгөөн.

Бидний зорилго бол Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан бүхий л эрхийг хүн бүрт эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс хараат бус ба гишүүдийн татвар болон олон нийтийн хандиваар санхүүждэг.

© Эмнести Интернэшнл 2020

Энэ баримт бичгийн агуулга нь Creative Commons лицензийн дагуу лицензтэй болно. (attribution, non-commercial, no derivatives, international 4.0)

<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб сайтын зөвшөөрлийн хуудас руу орж авна уу:

www.amnesty.org

Хэрэв материалыг Эмнести Интернэшнлээс бусад зохиогчийн эрхийн эзэмшигчид хамааруулсан бол энэхүү материал нь Creative Commons лицензэд хамаарахгүй болно.

Эмнести Интернэшнлээс 2020 онд анх хэвлүүлсэн

Peter Benenson House, 1 Easton Street, London WC1X 0DW, UK

Индекс: POL 40/2572/2020

Эх хэл: Англи

amnesty.org



Хавтасны зураг: Headlines Английн хэд хэдэн хэвлэлийн нийтлэлийн гарчиг
2020 оны 5-р сарын 23 © Эмнести Интернэшнл

UIN.MN
СЭДАЛГААНЫ САН

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



ЗНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ
ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

1. ТОВЧ ХУРААНГУЙ	5
2. ТАНИЛЦУУЛГА	9
3. АРГА ЗҮЙ	11
4. АЮУЛТАЙ, ШУДАРГА БУС АЖЛЫН НӨХЦӨЛ	14
4.1 Ковид-19 халдвар ба нас баралт	14
4.2 Хувийн хамгаалах хэрэгслийн хомсдол	20
4.3 Ажлын хэт ачаалал ба сэтгэцийн эрүүл мэндийн асуудал	24
4.4 Цалин хөлс ба нөхөн олговор	25
5. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ТАЙВНААР ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХ	31
6. ДОРОМЖЛОЛ БА ХҮЧИРХИЙЛЭЛ	38
7. БҮТЦИЙН АСУУДАЛ	43
8. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ БА ХЭМ ХЭМЖЭЭ	48
8.1 Эрүүл байх эрх	50
8.2 Хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангуулах хүн бүрийн эрх	50
8.3 Доромжлол, ялгаварлал, хүчирхийллээс хамгаалах	53
8.4 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	53
8.5 Олон улсын хамтын ажиллагаа, тусламж	55
9. ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ	56

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

1. ТОВЧ ХУРААНГУЙ

2020 оны 3-р сард ДЭМБ нь КОВИД-19-ийг цар тахал хэмээн зарлав. Энэхүү тайланг бичиж байх үед дэлхий дээр 11,125,245 хүн уг өвчний халдвар авсан бөгөөд үүний улмаас 528,204 хүн нас баржээ. Вирусийн тархалтыг хянахын тулд ихэнх улс орнууд хүмүүсийн шилжилт хөдөлгөөн, хүний эрхэд зарим хязгаарлалт тогтоосон байна. Мөн зарим улс орнуудад цар тахлын хамгийн хүнд хэцүү үе хараахан эхлээгүй байна. Энэ хүнд цаг үед, эмч, эмнэлгийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахад онцгой үүрэг гүйцэтгэж байна. Тэд өөрсдийн эрүүл мэнд, аж амьдралаа эрсдэлд оруулан, хүнд нөхцөлд, маш бага дэмжлэгтэйгээр хүмүүст зайлшгүй хэрэгцээт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хоол хүнс, бусад хоол тэжээлийн хангамж хүргэхээр улс орон бүрт ажиллаж байна.

Дэлхий даяар эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад ажил үүргээ гүйцэтгэхэд нь асар их бэрхшээл тулгарч байгаа бөгөөд засгийн газрууд тэднийг зохих ёсоор хамгаалж чадахгүй байна. Эмнести Интернэшнлийн хийсэн дүн шинжилгээгээр 3000 гаруй эмч, эмнэлгийн ажилтан цар тахлын үед КОВИД-19-ийн улмаас амьтасна алдаж (энэ талаар мэдээлэл хангалтгүй байсан тул хамгийн багаар тооцсон болно), олон хүн хувийн хамгаалах хэрэгслийн хомсдолын улмаас аюултай орчинд ажиллаж байжээ. Цаашилбал, тэд аюулгүй байдлаа хангуулах асуудал хөндсөнийхөө төлөө баривчлагдах, ажлаас халагдах зэрэг эрх баригчдын болон ажил олгогчдын хэлмэгдүүлэлт, зарим тохиолдолд бүр олон нийтийн зүгээс гутаан доромжлох, хүчирхийлэх явдалтай тулгарч байна.

Энэхүү тайланд дээр дурдсан бэрхшээл нэн яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа дэлхийн эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын тогтолцооны бүтцийн тулгамдсан асуудлуудыг анхааран авч үзсэн. Ингэхдээ дараах эх сурвалжуудын мэдээлэлд тулгуурласан болно. Үүнд: (i) дэлхийн 63 улс орон, нутаг дэвсгэрт эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийн асуудлаар Эмнести Интернэшнлийн судлаачдын хийсэн хяналт шинжилгээ, ажилтнуудтай хийсэн ярилцлага; (ii) цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын өмнө тулгарч буй бэрхшээлийн талаар үйлдвэрчний эвлэлүүд болон иргэний нийгмийн бусад оролцогчдын гаргасан хэвлэлийн мэдээ тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэгт хийсэн **баримт бичгийн тойм судалгаа**; (iii) КОВИД-19 халдвараар өвчилсөн, нас барсан эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын тооны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үндэсний эрүүл мэндийн нийгэмлэгүүдийн бүрдүүлсэн жагсаалт... зэрэг олон эх сурвалжаас цуглуулсан мэдээллийн эмхэтгэл зэрэг орно. Мэдээллийн олдоц илүү байсантай холбоотойгоор дүн шинжилгээний дийлэнх нь эрүүл мэндийн ажилтнуудад хамааралтай байснаас гадна "КОВИД-19"-тэй нүүр тулан ажиллаж байгаа ажилтнуудад хамаарах дүн шинжилгээг нэлээд өргөн хүрээнд хамруулсан.

«Одоогийн нөхцөл байдлыг зүйрлэж хэлбэл, өдөр бүр гүйлтийн зам дээр хамгийн хурдан дээр нь тохируулан хурдаа хадгалахыг хичээн гүйж байгаатай адил хүн бүр ядарч туйлдсан, сандарч тэвдсэн байдалтай байна»

Сувлагч, Англи улс

КОВИД-19-тэй илүү нүүр тулан ажилладаг эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бусад олон ажилтан зохих ёсны хамгаалах хэрэгсэлгүй бол халдвар авах, хүндээр өвчлөх, тэр ч байтугай амьтасна алдах эрсдэл нийт хүн амтай харьцуулахад өндөр байна. Олон улс оронд

эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай хичнээн ажилтан одоогийн байдлаар “КОВИД-19”-ийн халдвар авсан, үүний улмаас хэдэн хүн нас барсан тухай нэгдсэн тоо, хяналт байхгүй байгаа ч зарим орнуудад байна. Олон улсын Сувилагчдын Зөвлөлийн мэдээлснээр “230,000 гаруй сувилагч асрагч уг өвчний халдвар авсан бөгөөд 600 гаруй сувилагч вирусийн улмаас нас баржээ.» Эмнести Интернэшнл өргөн хүрээнд мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн бөгөөд дэлхийн 79 оронд дор хаяж 3000 эрүүл мэндийн ажилтан КОВИД-19-ийн халдвар авч нас барсан болохыг тогтоогоод байна. Их Британид “эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэргэжилтэн зарим хүмүүсийн нас баралтын эзлэх хувийг (эрэгтэй, эмэгтэй сувилагчид, сувилахуйн эрэгтэй туслахууд, нийгмийн халамжийн эрэгтэй, эмэгтэй ажилтнууд, эрүүл мэндийн эрэгтэй ажилтан) хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүн амын нас баралттай харьцуулахад өссөн тоон үзүүлэлт гарчээ. Эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин нэмэгдсэн бусад ажил мэргэжилд жолооч, тэр дундаа такси, автобусны жолооч, үйлдвэрийн болон хамгаалалтын албаны ажилтнууд багтжээ.

Энэхүү тайланд хамрагдсан зарим улс орны мэдээлэл цар тахалд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд үлэмж хэмжээгээр нэрвэгдэж, хүндээр өвчлөх болон нас баралтын түвшин өндөр байгааг харуулж байна. Тухайлбал Английн BAME бүлэг (өөрөөр хэлбэл хар арьстан, ази, үндэстний цөөнх гэсэн тодорхойлолтод хамаардаг)-т хамаарах эрүүл мэндийн ажилтнууд, Энэтхэгийн **“далиг” гэгддэг** бүлгээс гаралтай цэвэрлэгээний ажилтнууд, Финландын сомали хэлээр ярьдаг бүлэг хүмүүс гэх мэт орно.

Эмнести Интернэшнлийн мэдээлэл цуглуулсан 63 улс орон, нутаг дэвсгэрийн бараг бүгдэд нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад шаардлагад нийцсэн хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) хүрэлцээгүй байна. **Олон улсын Нийтийн үйлчилгээний байгууллагаас** 2020 оны 5-р сард гаргасан судалгаагаар дэлхийн 62 оронд дөрөвний нэгээс бага хувь нь хангалттай тоног төхөөрөмжтэй гэж үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд мэдэгджээ. Ийм нөхцөлд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд өөрсдийгөө хамгаалахын тулд олон янзын арга хэрэгсэл ашиглах хэрэгтэй болсон нь тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна. Зарим оронд эрүүл мэндийн ажилтнуудыг зохих XXX-ээр хангахгүй байгаа тул өөрсдөө худалдан авах, эсвэл төлбөрийг өөрсдөө төлж байсан талаар мэдээлж байсан. Зарим оронд хүмүүс өөрсдийгөө хамгаалахын тулд хогны уут, борооны цув зэргийг дахин ашиглах шаардлагатай болдог байжээ. Цар тахал эхэлснээс хойш хэд хэдэн улс орон XXX зэрэг зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүний импортын болон экспортын журамд өөрчлөлт оруулсан нь олон улсын зах зээл дээр XXX худалдан авах шаардлагатай зарим орны нөхцөл байдал улам дордуулж байв.

Цаашилбал, зарим орны эрүүл мэндийн ажилтнууд ажлын ачаалал нэмэгдэж, ажил мэргэжлийн нэмэлт эрсдэлтэй тулгарч байгаа энэ нөхцөлд цалин хөлс нь шударгаар олгогдоогүй, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөр өвчилсөн, эсвэл нас барсан тохиолдолд зохих нөхөн олговор олгоогүй талаар мэдээлжээ. Ажилтнуудын ажлын ачаалал ихсэх, эрхэлж буй ажилтай нь холбоотойгоор түгшүүр, стресс нэмэгдэх нь энэхүү хүнд нөхцөл байдалд эрүүл мэндийн ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг үр дагавруудыг үүсгэж болзошгүй юм. КОВИД-19 цар тахал эхэлснээс хойш 2020 оны 4-р сард хэвлэгдсэн Португалийн эрүүл мэндийн ажилтнуудын дунд явуулсан судалгаанд оролцсон нийт эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн 75% нь өөрсдийн сэтгэлийн түгшүүрийн түвшинг «өндөр» эсвэл «маш өндөр» гэж дүгнэсэн бол 14.6% нь сэтгэлийн хямралын түвшингээ дунд эсвэл ердийн түвшинд байна гэж мэдэгджээ. Өмнөд Африкийн эрүүл мэндийн нэгэн ажилтан Эмнести Интернэшнлд тайлбарлаж хэлэхдээ: “Миний хувьд хамгийн том асуудал бол бид нэг өвчтөнөөс нөгөө рүү яаран шилжиж, яарч явахдаа санамсаргүйгээр нүүрэндээ хүрч вирусийн халдвар авах явдал гэв. Бид бас маш их хөлөрч, хөлсөндөө зууралдаж байна. Намайг **КОВИД-19** дээр ажиллахыг болиулсан ба одоо нэмэлт эмчийн (locum doctor) ажил л хийж байна, энэ нь би зөвхөн ажилласан үедээ л цалин авна гэсэн үг. Тиймээс би өмнөхөөсөө ч илүү их стресст орж байна» гэв.

Ажилтнууд энэхүү нөхцөл байдлыг удаа дараа эсэргүүцэн олон нийтэд мэдээлж, үзэл бодлоо илэрхийлснээс болж ажлаас халагдах, зарим үед бүр баривчлагдах зэрэг хэлмэгдүүлэлттэй тулгарч байсан байна. Эмнести Интернэшнл эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд өөрсдийн хөдөлмөрийн нөхцөлийг илчлэн, олон нийтийн өмнө эсэргүүцэж, ажил хаялт хийсэн, эсвэл хийхээр мэдэгдсэн талаарх 31-ээс доошгүй улс орны тайланг цохон тэмдэглэв. Зарим улс оронд засгийн газар нь эсвэл тодорхой ажил олгогчид эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг санаа зовниж буй асуудлаа нийтэд ил болгохыг хориглох зорилгоор хязгаарлалт тогтоосон, эсвэл зааварчилгаа гаргасан болохыг Эмнести Интернэшнл тогтоожээ. Бусад орны хувьд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад албан ёсны хязгаарлалт тавиагүй ч олонх нь эрх баригчдыг шүүмжилснийхээ төлөө шийтгэл хүлээх, хэлмэгдүүлэлттэй тулгарсан, эсвэл хэлмэгдэх эрсдэлт нөхцөлд байна. Жишээлбэл, дотоод шүүрлийн эмч Юлия Волковаг 3-р сарын

25-ны өдөр өөрийн Твиттер хуудсан дээрээ эмч нарыг хувийн хамгаалах хэрэгслээр (XXX) хангахыг шаардсан видео нийтэлсний дараа түүнийг ОХУ-ын эрх баригчид КОВИД-19-ийн тухай «хуурамч мэдээлэл тараасан» хэмээн буруутгаж, захиргааны хэрэг үүсгэн шалгажээ.

“Би видео бичлэгээрээ хэнийг айлгачихав аа? Энд эмнэлгийн талаар юу ч хэлээгүй, ахлах эмчийн нэрийг ч дурдаагүй. Биднийг орчин үеийн хамгаалах хэрэгслээр хангахыг л шаардсан” гэж Юлия Волкова Эмнести Интернэшнлд хэлжээ.

Малайзын цагдаа нар эмнэлгийн цэвэрлэх үйлчилгээ эрхэлдэг компаний эсрэг тайван замаар суулт хийж байсан ажилтан, идэвхтнүүдийг тараав. Ажилтнуудын хэлснээр тэд эмнэлгийн үйлчлэгчдэд XXX хангалтгүй байгаа болон энэ талаар шаардлага тавьсан үйлдвэрчний эвлэлийн гишүүдэд шударга бус хандаж байгаа тул шаардлага хүргэсэн гэж байв. «Зөвшөөрөлгүй жагсаал цуглаан хийсэн» хэмээн буруутгаж байгаа нь эвлэлдэн нэгдэх, цуглаан зохион байгуулах эрх чөлөөтэй байх эрхийг хязгаарлан, зөрчиж байна хэмээн эсэргүүцлээ илэрхийлсэн таван идэвхтэнийг цагдаа нар нэг шөнийн дотор баривчлан саатуулж, торгосон байна. Үүний нэгэн адилаар **Египетийн** эрх баригчид эрүүл мэндийн есөн ажилтныг өөрсдийн эрүүл мэндийн асуудалд санаа зовж буйгаа илэрхийлж, цар тахалтай тэмцэх талаар Засгийн газраас явуулж буй арга хэмжээг шүүмжилсний төлөө баривчилж, дур мэдэн хорьжээ.

«Би сэтгэлээр маш их унаж байна. Засгийн газар, орон нутгийн захиргааны албан тушаалтнууд эмч нарыг хамгаалахын тулд чадах бүхнээ хийхгүй байна ... Бидэнд ямарч найдвар алга, бидэнд зөвхөн эсэргүүцлээ илэрхийлэх л үлдлээ. Гэтэл биднийг эсэргүүцэж ч болохгүй гэж хэлсэн. Тэд биднийг амыг барьж байна.»

Эмнэлгийн ажилтан, Пакистан

Түүнчлэн, олон оронд эрүүл мэндийн ажилтнууд урьд өмнө байгаагүйгээр олон нийтийн дэмжлэг авч, эв санааны нэгдэлтэй байгааг харсан ч зарим орнуудад КОВИД-19 цар тахлын эсрэг тэмцэн ажиллаж байгаа эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг гутаан доромжлох, зарим тохиолдолд бүр заналхийлж байна. Хүмүүс эрүүл мэндийн ажилтнуудыг Ковид-19 зөөвөрлөж, халдвар тараана гэж үзсэнээс орон сууц руу нь нэвтрүүлэхгүй байсан гэх мэдээлэл байна. Эрүүл мэндийн ажилтныг амьдардаг газраас нь хөөж гаргасан, тэднийг нүүлгэхийг оролдсон зэргээс шалтгаалж тэдэнд амьдрах газар олоход хэцүү байсан, эсвэл оршин сууж буй газраа гутаан доромжлогдох гэх мэт асуудалтай тулгарсан талаар дор хаяж 10 улс мэдээлсэн. Мөн эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ажилдаа явах замдаа, ажлын байран дээрээ дайралт, хүчирхийлэлд өртсөн, түүнчлэн олон нийт, хөршүүд эсвэл гэр бүлийн гишүүдийнхээ халдлага, хүчирхийлэлд өртсөн тохиолдол дор хаяж 11 оронд гарсныг Эмнести Интернэшнл бүртгэсэн байна. Түүнээс гадна, 2020 оны 5-р сард эрүүл мэндийн салбарын 30 сая гаруй мэргэжилтнийг эгнээндээ нэгтгэсэн эрүүл мэндийн болон хүмүүнлэгийн 13 байгууллага КОВИД-19-тэй холбоотойгоор халдлагад өртсөн 200 гаруй тохиолдол гарсныг буруушааж гаргасан мэдэгдэлдээ: “Энэ нь өвчний эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж буй тэргүүн шугамынханд төдийгүй нийгэмд аюул, эрсдэл учруулж буй хэрэг» гэж дурдсан байна”.

Жишээлбэл, **Мексикт** 4-р сарын 28-ны байдлаар Дотоод хэргийн яам эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг дор хаяж 47 удаагийн халдлага үйлдсэнийг баримтжуулсан бөгөөд халдлагын 70% нь эмэгтэйчүүдийн эсрэг байжээ. Гудамжинд явж байсан сувилагч руу хлортой ус цацсан гэж мэдээлэв. Ялгаварлан Гадуурхалтаас Урьдчилан Сэргийлэх Үндэсний Зөвлөлөөс (ЯГУСҮЗ) 3-р сарын 19-нөөс 5-р сарын 8-ны хооронд эрүүл мэндийн ажилтнуудын дунд КОВИД-19-той холбоотой ялгаварлан гадуурхсан тухай 265 гомдол, түүний дотор эмчээс 17, сувилагчаас 8, захиргааны болон тусламжийн ажилтнуудаас 31 гомдол ирсэн байна.

Улс орнууд КОВИД-19-ийн үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрүүл байх, хөдөлмөрийн шударга таатай нөхцлөөр хангуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван цугларах, ялгаварлан гадуурхалт болон хүчирхийллээс ангид байх зэрэг эрхийг хамгаалах талаар тодорхой үүрэг хүлээж, хүний эрхийг ханган хэрэгжүүлэхэд олон улсын түвшинд хамтран ажиллах, тусламж үзүүлэх үүрэгтэй байдаг.

Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг хамгаалах нь цар тахлын эсрэг илүү хүчтэй, хүн бүрт ээлтэй чухал хариу арга хэмжээ юм. Эрүүл мэндийн ажилтнууд нь КОВИД-19 цар тахлын тархалт, цар хүрээ, засгийн газраас үзүүлэх хариу арга хэмжээний талаархи мэдээллийн чухал эх сурвалж юм. Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хамгаалснаар хүн бүр хамгаалагдана.

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

Эмнести Интернэшнл

«шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан тохиолдолд өвчний ямар шинж тэмдэг илэрч байгаагаас үл хамааран өвчтөнийг эмч, эмнэлгийн ажилтнууд эмчлэхээс айхгүй бөгөөд хүний амь нас аврагдах болно»

Эмнэлгийн ажилтан, Нигер үлс

Зарим улс оронд цар тахлын тархалт багасаж, заримд нь илүү эрчимжиж байгаа энэ үед энэхүү тайлан гарсан. Хэдий тийм ч энэ тайланд орсон сургамж, зөвлөмж нь бүх нийтэд хамаарна. Энэ цаг мөчид цар тахлын хамгийн хүнд нөхцөл байдалд байгаа улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг хамгаалах талаарх тайланд дурдагдсан зөвлөмжийг нэн даруй хэрэгжүүлэх ёстой. Цар тахалд хараахан хүндээр нэрвэгдээгүй байгаа улс орнууд цаг хугацаатай өрсөн эрүүл мэндийн тогтолцоогоо болзошгүй аюулд бэлтгэх, цар тахал дэгдсэн тохиолдолд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг бүрэн хамгаалах дэд бүтэцтэй болсон байхад анхаарах хэрэгтэй. Цар Тахал өвчний хамгийн аймшигт үзэгдлийг үзсэн улс орнууд өөрсдийгөө болзошгүй “хоёр дахь давалгаанд” бэлтгэхээс гадна эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын хөндөж гаргаж ирсэн асуудлуудын мөрөөр арга хэмжээ авч, эрх бүрэн хамгаалагдаагүй асуудалд хариуцлага тооцох хэрэгтэй.

Эмнести Интернэшнл КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтныг зохих ёсоор хамгаалах нөхцөлийг хангахын тулд дараах цогц зөвлөмжийг дэлхийн засгийн газруудад өгч байна. Үүнд:


- Улс орнууд ажил олгогчдыг төрийн эсвэл хувийн хэвшлийн гэдгээс үл хамааран КОВИД-19 халдварын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтнаа олон улсын стандартад нийцүүлэн зохих хувийн хамгаалах хэрэгслээр хангах үүрэгтэйг баталгаажуулах;
- Улс орнууд КОВИД-19 халдварт өвчнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин гэж хүлээн зөвшөөрч, эрхэлдэг ажилтайгаа холбоотойгоор тусламж үйлчилгээ үзүүлснийхээ улмаас КОВИД-19-халдвар авсан ажилтнуудад мөнгөн нөхөн олговор, эмнэлгийн болон бусад шаардлагатай тусламж үзүүлэх ёстой. Үүнд гэрээний онцлогоос үл хамааран эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтан хамрагдах;
- Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад тулгамдаж байгаа аюулгүй байдлын асуудлыг сонсож, зохих ёсоор шийдвэрлэх шаардлагатай. Эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой асуудлаар санаа зовниж, гомдол гаргасан ажилтны эсрэг ямарваа нэг шийтгэл оногдуулах ёсгүй. Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд эрүүл мэндийн болон аюулгүй байдалтай холбоотой асуудлаар санаа зовниж, гомдол гаргасныхаа төлөө ажлын байран дээрээ ямарваа нэгэн шийтгэл, сахилгын арга хэмжээгээр шийтгэгдвэл, эсвэл ажлаас халагдсан бол эрх бүхий байгууллагууд зохих ёсоор нягтлан шалгаж, шаардлагатай тохиолдолд зохих нөхөн төлбөрийг олгох, ажилд нь буцаан оруулах зэргээр эрхийг сэргээх;
- Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд руу халдсан аливаа халдлага, хүчирхийллийг төрийн эрх баригчид нэн даруй, хараат бус, шударгаар хянан шалгаж, гэмт этгээдүүдэд хариуцлага тооцох ёстой. Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг ялгаварлан гадуурхахыг ямар ч нөхцөлгүйгээр хориглох ёстой. Ингэхдээ улс орнууд, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай зарим ажилтнууд өөрсдийн олон талт байдлаасаа хамааран нэмэлт эсвэл тодорхой эрсдэлд орж болзошгүйг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд үүний эсрэг төрийн зүгээс хариу арга хэмжээ авах;
- Төрийн болон бусад этгээдүүд цар тахлын дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээнд бэлэн байгаа эсэхэд иж бүрэн, үр дүнтэй, хараат бус үнэлгээ хийх хэрэгтэй. Цар тахлын нөхцөлд төрийн байгууллагууд хүний эрхийг, түүний дотор эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг зохих ёсоор хамгаалж чадаагүй гэж үзэх үндэслэл байгаа бол Улс орнууд эдгээр гомдол нэхэмжлэлд бүхэлд нь ил тод, хараат бус, шударга мөрдөн байцаалт хийх үр дүнтэй, хүртээмжтэй арга хэрэгслийг ханган хариуцлага хүлээлгэх;
- Цаашид гарах халдвараас үр дүнтэй сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Улс орнууд КОВИД-19 халдвар авсан болон нас барсан эрүүл мэндийн болон бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудын мэдээллийг ажил мэргэжлээр нь нарийвчлан гаргаж, нийтэлж байх ёстой. Энэ мэдээллийг ялгаварлан гадуурхалтаас ангид байх үүднээс аль болох хүйс, гарал угсаа ба үндэстнээр нь ангилан гаргах;

Зөвлөмжүүдийн бүрэн жагсаалтыг тайлангийн төгсгөлөөс үзэх боломжтой.

2. ТАНИЛЦУУЛГА

«Бид бие махбод, сэтгэл санааны хувьд ядарч туйлдсан. Бидний хувийн амьдрал бүрэн уналтад орсон. Төр засгийн хандлага, өвчний талаарх хүмүүсийн мэдлэггүй байдал бидний туйлдуулж байна»

Эмнэлгийн ажилтан, Пакистан¹



Залуу Эмч нарын Нийгэмлэгийн эмч, эрүүл мэндийн ажилтнууд Пакистанд ХХХ, нөөц, ажиллах нөхцөл дутмаг байгааг эсэргүүцэв, 4 сар/5 сар 2020. © Залуу Эмч нарын Нийгэмлэг

2019 оны 12-р сард шинэ өвчний тухай мэдээллүүд гарч эхэлсэн бөгөөд үүнийг хожим нь КОВИД-19 гэж нэрлэсэн. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) 2020 оны 3-р сар гэхэд КОВИД-19-ийг цар тахал хэмээн зарлав. Энэхүү тайланг бичиж байх үед 11,125,245 хүн өвчний халдвар авч өвчилсөн бөгөөд үүний улмаас 528,204 хүн нас баржээ.² Ихэнх улс орнууд вирусийн тархалтыг хянахын тулд хүмүүсийн шилжилт хөдөлгөөн, бусад эрхийг хязгаарласан. Зарим улс орон тахлын хамгийн хүнд хэцүүг хараахан туулаагүй байж магадгүй юм. КОВИД-19 цар тахал нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа бүх хүнд урьд өмнө байгаагүй ихээр бие махбод, нийгэм, эдийн засгийн нөлөө үзүүлсэн гэдэгт эргэлзэхгүй байна. Хүмүүс өвдөж, гэр бүлийн гишүүд,

¹ Эмчтэй хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 22, Лахор, Пакистан

² ДЭМБ Коронавирус халдварт өвчин (КОВИД-19) Хяналтын самбар, <https://covid19.who.int/>

хайртай хүмүүсээ алдаж, орлого нь тасалджээ. Одоогийн нөхцөл байдал тодорхойгүй байгаа бөгөөд хүмүүс ирээдүйд юу болох талаар санаа зовниж, сэтгэлийн түгшүүртэй байна.

Энэ хүнд хэцүү үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд тахлын эсрэг хариу арга хэмжээ авахад онцгой үүрэг гүйцэтгэсэн. Улс орон даяар тэд өөрсдийн эрүүл мэнд, аж амьдрал, амь насандаа эрсдэл учруулан, ихэвчлэн маш хүнд нөхцөлд, маш бага дэмжлэгтэйгээр хүмүүст шаардлагатай байгаа зайлшгүй хэрэгцээт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хоол хүнс, бусад зайлшгүй шаардлагатай хангамж, яаралтай тусламж үзүүлэхээр ажиллаж байна. Дэлхий даяар эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд асар их саад бэрхшээлтэй тулгаран ийнхүү ажил үүргээ гүйцэтгэж байхад засгийн газрууд тэднийг хангалттай хамгаалж чадахгүй байна. Хэд хэдэн улс оронд хувийн хамгаалах хэрэгслийн (XXX) хомсдол нүүрлэсэн нь эмч, эмнэлгийн болоод бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг зохих хамгаалалтгүй, аюултай орчинд ажлаа гүйцэтгэхээс өөр аргагүйд хүргэсэн. Зарим тохиолдолд тэд шударга цалин хөлс, нөхөн олговор аваагүй, ажлын ачаалал ихтэйн улмаас сэтгэлийн түгшүүр, стресс бухимдал нэмэгдсэн байна. Энэ тулгамдсан асуудлаа олон нийтэд ярьсныхаа төлөө тэдний олонх нь төрийн болон ажил олгогчийн дарамт шахалт болон бусад төрлийн шийтгэл, хэлмэгдүүлэлттэй тулгарчээ. Хэд хэдэн оронд эмч эмнэлгийн ажилтнууд болон бусад зайлшгүй шаардлагатай ажилтнууд эрхэлж байгаа ажлынхаа улмаас халдлагад өртөх, гутаан доромжлогдох зэрэг асуудалтай нүүр тулгарч байв. Үүнийхээ улмаас тэд орон байрандаа нэвтрэх гэх мэт зайлшгүй шаардлагатай үйлчилгээнд ч хамрагдаж чадахгүй, элдэв бэрхшээлтэй тулгарч байв.

Энэхүү тайланд эмч, эмнэлгийн ажилтнууд болон бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, дарамт шахалт, бусад төрлийн шийтгэл хэлмэгдүүлэлтийн талаарх сэтгэл зовоосон асуудлууд, эрхэлдэг ажилтай нь холбоотойгоор доромжилсон, заналхийлэлд өртсөн зэрэг асуудлуудыг авч үзсэн болно. Мөн эдгээр тулгамдаж буй асуудлыг улам бүр хурцатгаж байгаа дэлхий даяарх эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн тогтолцооны яаралтай анхааралдаа авах зарим өргөн хүрээний бүтцийн асуудлыг онцлон авч үзсэн болно.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

3. АРГА ЗҮЙ

КОВИД-19 цар тахал эхэлснээс хойш эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудын өмнө тулгарч буй бэрхшээл онцгой анхаарлын төвд байна. Эмнести Интернэшнл хэд хэдэн улс орон, бүс нутгуудад эмч, эмнэлгийн ажилтан болоод бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг хамгаалах шаардлагатайг онцолж байна.³ Энэхүү тайлан дэлхийн улс орнуудад КОВИД-19 цар тахлын үед эмч, эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудад тулгарч буй бэрхшээлийн талаар илүү өргөн хүрээний дүр зургийг үзүүлэхийг оролдсон ажлын үргэлжлэл болно. Энэхүү тайланг дараах эх сурвалжуудын мэдээлэлд үндэслэн боловсруулав. Үүнд:

- Эмнести Интернэшнл дэлхийн 63 улсын нутаг дэвсгэрт эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхэд хамаарах мэдээлэл цуглуулсан,⁴ Үүнд Европт 18, Ойрхи Дорнод болон Хойд Африкийн бүс нутагт 4, Азид 10, Америкт 10, Африкт 21 улс байна.
- Ажлын байрны эрүүл мэнд, ажлын байрны аюулгүй байдал болон цар тахлын эсрэг хариу арга хэмжээний талаарх тулгамдаж байгаа асуудлуудыг хөндөж тавьсан ажилтнуудын эсрэг авч байгаа нийтлэг хариу арга хэмжээ ба шийтгэл хэлмэгдүүлэлт, мөн төрийн болон төрийн бус оролцогчдын хүчирхийлэл, харгислал зэрэг асуудлуудыг хамруулсан. Зарим тохиолдолд мэдээллийг хоёрдогч эх сурвалж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэлд үндэслэсэн ба бусад тохиолдолд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд, тэдний төлөөлөлтэй Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлагуудад тулгуурлав.
- Эмнести Интернэшнл цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад тулгарч буй бэрхшээлүүдийн талаарх хэвлэлийн мэдээ, эрдэм шинжилгээний өгүүлэл, үйлдвэрчний эвлэлүүд болоод иргэний нийгмийн бусад оролцогчдын тайлан зэрэгт баримт бичгийн тойм судалгаа хийсэн. Дээр дурдсан хяналт шинжилгээний үр дүнд олж авсан мэдээллийн зохих хэсгийг энэхүү хоёрдогч судалгаагаар баталгаажуулсан болно.
- Хяналт шинжилгээ болон баримт бичгийн тойм судалгаанаас гарч буй мэдээллийг баталгаажуулахын тулд Эмнести Интернэшнл нь ижил төстэй асуудлаар ажилладаг олон улсын байгууллага, шинжээч, иргэний нийгмийн байгууллагуудтай ярилцсан. Холбогдох хэсгүүдэд тэдний ажиглалтуудыг тайлангийн дүгнэлтэд тусгасан болно.

ОИ.МН
СУДАЛГААНЫ САН

³ Жишээ үзнэ үү: Энэтхэгийн Эмнести Интернэшнл, Фронтын шугам дээр хаягдсан нь: Энэтхэгийн халдваргүйтгэлийн ажилчид КОВИД-19-ийн үеэр засгийн газраас яаралтай тусламж эрэлхийлж байна, <https://amnesty.org.in/aban-doned-at-the-frontline-indias-sanitation-workers-see-immediate-help-from-the-government-amidst-covid-19/>; Нигерийн Эмнести Интернэшнл, Нигер улс: Эрх баригчид КОВИД-19 эсрэг хариу арга хэмжээний тэргүүн эгнээд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах ёстой, (Index: AFR 44/2264/2020); Эмнести Интернэшнл, Эмчлэх өртөг: Ковид-19 үе ба түүнээс цааши хугацаанд Америк дахь эрүүл мэндийн ажилтнуудын, (Index: AMR 01/2311/2020); Эмнести Интернэшнл, Индонези дэх КОВИД-19 ба хүний эрхэд нөлөөлөх нь, (Index: ASA21/2238/2020)

⁴ Аргентин, Австри, Беларусь, Бразил, Буркина Фасо, Бурунди, Камерун, Чили, Бүгд Найрамдах Ардчилсан Конго, Дани, Египет, Сальвадор, Эритрея, Этиоп, Финлянд, Франц, Гана, Грек, Гватемала, Гвиней, Гондурас, Хонконг, Энэтхэг, Индонез, Итали, Зааны ясан эрэг, Япон, Кувейт, Лесото, Ливи, Малайз, Мали, Мексик, Молдав, Монгол, Намиби, Непал, Никарагуа, Нигери, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Филиппин, Польш, Португал, Бүгд Найрамдах Конго Улс, ОХУ, Сьерра-Леон, Словени, Сомали, Өмнөд Африк, Өмнөд Судан, Испани, Судан, Швед, Тажикистан, Того, Тунис, Турк, Украин, Их Британи, АНУ ба Зимбабве

- Эмнести Интернэшнл олон эх сурвалжаас эмч, эмнэлгийн ажилтнуудын нас баралттай холбоотой мэдээллийг цуглуулж судлан, КОВИД-19-ийн халдварын улмаас нас барсан 79 орны 1500 эмч, эмнэлгийн ажилтны нэрсийн жагсаалт бий болгосон. Мэдээллийн эх сурвалжид КОВИД-19 болон үүнтэй холбоотой шалтгаанаар нас барсан эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан дурсгалын хуудсууд, жишээлбэл, Бразилийн Сувилахуйн Холбооны Зөвлөл, Италийн Мэс засалч Шүдний эмч нарын Үндэсний Холбоо зэрэг үндэсний эрүүл мэндийн байгууллагуудын нэгтгэсэн жагсаалт болон дэлхийн, орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлсэн нас барагсдын нэрсийн жагсаалт ба нас барагсдын талаарх товч мэдээлэл зэрэг орно. Мэдээллийг нэгтгэхдээ тухайн мэдээллийг HTML хуудас, PDF тайлан болон бусад баримт бичгүүдээс цуглуулж дата шинжээчидтэй хамтран ажилласан ба олон эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, давхардлыг арилгах замаар нэгтгэв. Дараа нь мэдээллийг улс орон бүрээр COVID-19-ийн нас баралтын нийт түвшин, улс орон дахь төстийн түвшин зэрэг нэмэлт мэдээллийг ашиглан өгөгдлийг шинжилсэн болно. Мэдээллийн эх сурвалжийн жагсаалт болон мэдээлэл цуглуулах, боловсруулах аргачлалын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг, мөн бүрэн мэдээллийг эндээс үзнэ үү: <https://public.flourish.studio/visualisation/3015800/>

КОВИД-19 цар тахал өвчний нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж байсан, мөн энэ хугацаанд хилийн хорио тогтоогдсон зэрэг мэдээлэл олж авах, баталгаажуулахад ихээхэн бэрхшээл учирсан тул тайланд тусгагдсан мэдээлэлд зарим хязгаарлалт байгааг анхааран үүнийг хэрхэн тайлбарлах талаар нухацтай хандах хэрэгтэй.

Нэгдүгээрт, энэхүү тайланд улс орон бүрийн мэдээлэл багтаагүй тул мэдээллийн тархалтын хувьд жигд биш. Хяналт шинжилгээ нь тухайн улс дахь тахал өвчний цар хүрээ, түгээсэн мэдээллийн хэмжээ, Эмнести Интернэшнл байгууллагын ажилтнууд тодорхой байршлуудад хүрэх боломжтой байсан эсэх, мөн түүнчлэн эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын болон тэдний төлөөллийн байгууллагууд чөлөөтэй ажиллаж, Эмнести Интернэшнлтэй мэдээлэл хуваалцаж чадсан эсэхээс хамаарна. Зарим улс орнуудад эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрүүл мэндийн гол үзүүлэлтүүд болох КОВИД-19-ийн халдвар авсан байдал, нас баралт гэх мэтийн талаар мэдээлэл цуглуулдаггүй, түгээдэггүй байхад бусад зарим улс оронд бэрхшээлийн талаар гомдоллох, эсэргүүцэх, үг хэлэх нь аюултай байсан. Мэдээлэл цуглуулаагүй хэд хэдэн оронд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ижил төстэй буюу бүр илүү хүнд аюул, бэрхшээлтэй тулгарсан байж болох юм. Энэхүү тайлангийн зарим баримт, судалгаанд тулгуурласан гэхээсээ илүү зөвхөн хувь хүний аман **мэдээлэл** шиг байж болох боловч эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажлаа гүйцэтгэхэд тулгарч буй нийтлэг асуудлууд, эрсдэлийн талаар тухайн цаг мөч дэх мэдээллийг багтаасны хувьд хүчирхэг мэдээлэл болж чадах юм.

Хоёрдугаарт, энэхүү тайланд 2020 оны 1-р сараас 2020 оны 6-р сар хүртэлх хугацаанд хамаарах мэдээлэл багтсан бөгөөд энэ хугацаанд цар тахлын нөлөөлөл улс орнуудад өөр өөр байсан. Зарим улс орнууд энэ оны эхээр цар тахлын хамгийн хүнд хэцүү үеийг туулсан бол бусад улс орны хувьд хамгийн муу үр нөлөөг амсч байсан үе байж болно. Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын хамгийн их сэтгэл түгшээсэн асуудал нь цар тахлын тархалтын эрчим байсан ба энэхүү тайланд хамгийн хүнд үе шат тэдний хувьд ямар байсныг баримтжуулж өгсөн. Иймээс тодорхой зарим улс орнуудад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй байж болно. Учир нь зарим улс орон цар тахлын хамгийн хүнд үеийг туулаагүй, эсвэл энэхүү илтгэлд дурдсан зарим орнуудын хувьд цар тахлын эрч буурч, нөхцөл байдал сайжирсан байж болох юм.

Гуравдугаарт, эрүүл мэндийн ажилтан эсвэл зайлшгүй шаардлагатай ажилтан гэж хэнийг ойлгох вэ гэдэг талаар дэлхийн хэмжээнд тохирсон нэгдсэн тодорхойлолт байдаггүй. Энэхүү тайланд “эрүүл мэндийн ажилтан” гэдэг нь эрүүл мэндийн салбарт ажилладаг бүх хүнд хамаарах ба үүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэхэд оролцож байгаа эмч, сувилагч, эмнэлгийн асрагч, түргэн тусламжийн жолооч, эмнэлгийн захиргааны ажилтан болон олон нийтийн дунд, бусад газарт ажиллаж буй эрүүл мэнд, нийгмийн халамжийн ямар ч ажилтан хэн ч бай үүнд хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй. “Зайлшгүй шаардлагатай ажилтан” гэдэг нь КОВИД-19 цар тахал өвчний үед ажиллаж, шаардлагатай төрийн үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүс, үүнд нийтийн үйлчилгээнд ажилладаг хүмүүс (яаралтай тусламжийн үйлчилгээ, нийтийн тээврийн ажилчид, хог ачигч нар г.м), мөн түүнчлэн КОВИД-19 цар тахлын үед үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн бизнес эрхэлж буй хүмүүс (хүнсний дэлгүүр, хүргэлтийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүс) хамаарна. Ихэнх улс орнуудад эрүүл мэндийн ажилтнуудын өмнө тулгарч буй асуудал түлхүү яригддаг бөгөөд

ерөнхийдөө зайлшгүй шаардлагатай ажилтнуудтай харьцуулахад эрүүл мэндийн ажилтнуудын талаар илүү их мэдээлэл байна. Ийм шалтгааны улмаас эрүүл мэндийн ажилтнуудыг энэ тайланд илүү дурьдсан. Гэхдээ Эмнести Интернэшнл эрсдлийн ижил түвшинд ажиллаж байгаа бүх хүн ажлын байранд болон бусад тохиолдолд адилхан хамгаалуулах эрхтэй гэдгийг онцолсон. Ялангуяа эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ижил тэгш хамгаалагдах ёстой тул энэхүү тайланд ажилтнуудын хоёр ангиллыг хамтад нь хамааруулсан болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4. АЮУЛТАЙ, ШУДАРГА БУС АЖЛЫН НӨХЦӨЛ

Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүрэг нь эрүүл байх эрх, хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангуулах эрхээс үүдэн гарна. Эрүүл байх эрхэд “ эрүүл аюулгүй орчинд ажиллах, орчний бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх ” багтах ба үүнд “үйлдвэрлэлийн осол ба өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн нөхцөл” орно”.⁵ НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны (ЭЗНСЭ-ийн хороо) Ерөнхий Зөвлөмж 14-т “Улс орнууд байгаль орчинд болон хөдөлмөрийн эрүүл мэндэд тулгарч буй аюул, түүнчлэн цар тахлын тархалтын төлөв байдлын урьдчилсан таамаг мэдээллийн дагуу бусад аюул заналын эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна... Оролцогч улсууд үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчний эрсдлийг бууруулах үндэсний цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, хянах, мөн түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээний талаар цогц бодлогоор хангах шаардлагатай байна”⁶ гэж тэмдэглэжээ. Энэ нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажлын нөхцөлд хамаарна.

Түүнээс гадна, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын (ЭЗНСЭОУП) 7-р зүйлийн дагуу “Энэхүү Пактад Оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал: ... (a) (i) цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох ... (б) Аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын нөхцөл бүрдүүлэх ... (d) Амрах, зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх” зэрэг хамаарна. Дээр дурьдсан эрхүүдийн тухай тайлангийн дараагийн бүлэгт нарийвчлан авч үзэх болно.

4.1 КОВИД-19: ХАЛДВАР БА НАС БАРАЛТ

КОВИД-19 цар тахлын эсрэг тэмцэж буй эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бусад олон ажилтан зохих ёсоор хамгаалагдаагүй тохиолдолд халдвар авах, хүндээр өвчлөх, цаашлаад эндэх өндөр эрсдэлтэй байдаг. Одоогийн байдлаар эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай хичнээн ажилтан КОВИД-19-ийн халдвар авсан, үүний улмаас хэд нь нас барсан талаар нэгдсэн судалгаа байхгүй ч хэсэгчилсэн цөөн хэдэн судалгаа байдаг. Олон улсын Сувилагчдын Зөвлөлийн мэдээлснээр “230,000 гаруй сувилагч, асрагч өвчний халдвар авсан ба одоогийн байдлаар 600 гаруй сувилагч вирусийн улмаас нас баржээ”.⁷ Эмнести Интернэшнлийн олж авсан мэдээллээс үзэхэд 2020 оны 6-р сарын 5-ны өдөр дэлхийн 73 оронд 3000 гаруй эрүүл мэндийн ажилтан КОВИД-19 халдвар болон уг халдварын хүндрэлийн улмаас нас баржээ.

⁵ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №14: Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх, E/C.12/2000/4, 2000 оны 8 сарын 11, §15

⁶ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №14: Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх, E/C.12/2000/4, §36

⁷ Сувилагчдын Олон улсын Зөвлөл, “Дэлхийн дахинд 600 гаруй сувилагч КОВИД-19-ийн улмаас нас баржээ”, 2020 оны 6 сарын 3, <https://www.icn.ch/news/more-600-nurses-die-covid-19-worldwide>



Сувилахуйн мэргэжилтнүүд коронавирусийн (КОВИД-19) хохирогч сувилагчдын дурсгалыг хүндэтгэх арга хэмжээг коронавируст халдварын цар тахлын дэгдэлтийн ид үеэр 2020 оны 5-р сарын 12-ны өдөр Бразилд Бүгд найрамдахчуудын музейн дэргэд зохион байгуулжээ. © 2020 Гетти Images

Нарийвчилсан мэдээлэл байхгүй байгаа нь тодорхой дүгнэлт гаргахад төвөгтэй ч зарим улс орны мэдээллээс харвал эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах нь засгийн газар болон ажил олгогчдын хувьд нэн тэргүүний зорилт нь байгаагүй гэсэн болгоомжлол төрүүлж байна.

КОВИД-19 халдвартай нь батлагдсан эрүүл мэндийн ажилтнуудын талаарх улс орнуудын нийтэлсэн зарим тоон мэдээллээс үзвэл эрүүл мэндийн ажилтан янз бүрийн байдлаар КОВИД-19-ийн халдвар авсан байна. Жишээлбэл:

- **Их Британид** 2020 оны 6-р сарын 26-ны байдлаар нийгмийн халамжийн ажилтнуудын дунд КОВИД-19-ийн 268 нас баралт, Англи ба Уэльст эрүүл мэндийн ажилтнуудын дунд 272 нас баралт бүртгэгдсэн байна.⁸
- **Испанийн** долоо хоног тутмын сэтгүүлд нийтэлснээр, 2020 оны 5-р сарын 29-ний байдлаар нийт КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлын 24.1 хувийг эрүүл мэндийн ажилтнууд эзэлж, дор хаяж 63 хүн энджээ.⁹
- **Украинд** 2020 оны 6-р сарын 9-ний байдлаар Эрүүл мэндийн яамны мэдэгдсэнээр нийт КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлын 18% орчим хувь нь эрүүл мэндийн ажилтнууд байжээ.¹⁰
- 2020 оны 6-р сарын 22-ны байдлаар, Эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмнэлгийн болон эмнэлгийн бус ажилтнууд тус улсад нийт халдварын батлагдсан тохиолдлын бараг 14%

УИЛМН
СЭДАЛ ААНЫ САН

⁸ Коронавирустай холбоотой нас баралт, мэргэжил бүрээр, Англи ба Уэлс: 2020 оны 3 сарын 9-нөөс 5 сарын 25-ны хооронд бүртгэгдсэн нас баралт, <https://www.ons.gov.uk/peoplepopulationandcommunity/healthandsocialcare/causesofdeath/bulletins/coronaviruscovid19relateddeathsbyoccupationenglandandwales/deathsregisteredbetween9marchand25may2020#deaths-involving-covid-19-among-men-and-women-health-and-social-care-workers>

⁹ 5-р сарын 29-ний өдөр хийсэн хэвлэлийн бага хурал дээр засгийн газар эрүүл мэндийн 63 ажилтан КОВИД-19 халдварын улмаас нас барсан гэж мэдэгдэв. Гэсэн хэдий ч тухайн өдөр гаргасан засгийн газрын тайланд уг тоог 52 гэж оруулсан байна. Тайланг эндээс үзнэ үү: <https://www.isciii.es/QueHacemos/ Servicios/VigilanciaSaludPublicaRENAVE/EnfermedadesTransmisibles/Paginas/InformesCOVID-19.aspx>

¹⁰ А.Токмахчи, “Хоёр мянган эмч коронавирусийн халдвар авсан байна. Яагаад эрүүл мэндийн тогтолцоо өөрийгөө хамгаалж чадахгүй байна вэ?” Хромадске, 2020 оны 4 сарын 30, <https://hromadske.ua/posts/dvi-tisyachi-medikiv-infikovani-koronaviru-som-chomu-medichna-sistema-ne-mozhe-zahistiti-svoyih>

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

Эмнести Интернэшнл

хувийг эзэлж байна гэж **Аргентин** улсын Эрүүл мэндийн яамнаас мэдэгджээ.¹¹

- 5-р сарын эхээр **Дани** улсад шинжилгээнд хамрагдсан эрүүл мэндийн бүх ажилтны 6%, эмнэлгийн сувилагчдын 8.4% нь КОВИД-19-ийн халдвар авсан байна. Энэ нь нийт хүн амтай харьцуулахад **3.8%-ийг** эзэлж байна гэж мэдэгджээ.¹²
- Зургадугаар сард, Бразилын Эрүүл мэндийн яамнаас КОВИД-19 халдвараар өвчилсөн эрүүл мэндийн ажилтнуудын 83,118 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 189,788 хүн шинжилгээний үр дүнг хүлээж байна гэж мэдэгджээ.¹³ 6 сарын 5-ны байдлаар КОВИД-19 холбоотойгоор 238 сувилагч нас барсан,¹⁴ 5-р сарын 21-ний байдлаар 113 эмч нас барав.¹⁵
- 5-р сарын 13-ны өдөр Мексикийн эрүүл мэндийн байгууллагын эрх баригчид тус улсад КОВИД-19-ийн 36,327 тохиолдол бүртгэгдэж, 3573 хүн нас барсныг баталгаажуулав. Үүний 8544 тохиолдол, нас баралтын 111 нь эрүүл мэндийн ажилтнууд байжээ. Эрүүл мэндийн ажилтнуудын 41% нь сувилагч, 37% эмч, 19% эмнэлгийн бусад ажилтнууд, 2% лабораторийн ажилчид, 1% нь шүдний эмч нар байжээ.¹⁶

Дахин хэлэхэд, эрх баригчдаас гаргасан тоон мэдээллийг бүрэн зураглал болгоход эргэлзээтэй. Их Британид, Үндэсний статистикийн газрын хийсэн судалгаагаар эрэгтэй, эмэгтэй сувилагч, эрэгтэй туслах сувилагч зэрэг «эмнэлгийн сувилагч, асрагч нарын дунд нас баралтын түвшин» нэмэгдсэн байна.¹⁷ Үүнтэй адилаар КОВИД-19 халдварын эндэгдэлийн түвшин нийгмийн халамжийн ажилтнууд болон эрэгтэй асрагч, сувилагчдын дунд өндөр байгааг тогтоожээ. Эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин нэмэгдсэн бусад мэргэжлүүдэд таксины жолооч, жолооч, автобусны жолооч, үйлдвэрийн ажилчид, харуул хамгаалалтын ажилчид багтаж байна.¹⁸

Түүнээс гадна, зарим улс оронд шинжилгээ оношлогоонд бүрэн хамруулаагүй, мэдээлэл дутмаг болон ил тод байдал дутмагаас хамааран эдгээр тоон үзүүлэлт дутуу гарсан байх магадлалтай. Жишээлбэл:

- **АНУ-д** Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвүүд нь КОВИД-19-ийн халдвар авсан хэдэн эрүүл мэндийн ажилтан байгаа, үүнээс хэд нь нас барсан талаар шинэчилсэн мэдээлэл гаргасан байна. Тэдний мэдээлсэнээр, 6-р сарын 5-ны өдрийн байдлаар, 92572 “эрүүл мэндийн ажилтан” КОВИД-19 халдвар авсан ба үүний 507 нь нас баржээ.¹⁹ Өвчнийг хянах, Урьдчилан Сэргийлэх төвийн судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн” зөвхөн 21.5% - “эрүүл мэндийн ажилтан байх боломжтой бөгөөд КОВИД-19 халдвараар «нас барсан» нь зөвхөн 65.6% байсан байна.²⁰ Өөрөөр хэлбэл, санал асуулгад хамрагдсан бүх хүн бүгдээрээ «эрүүл мэндийн ажилтан» байсан эсэх нь тодорхойгүйгээс гадна тэдний хэд нь «нас барсан» болох нь тодорхой биш байсан тул дүн мэдээг тоолох ажил хязгаарлагдмал байв. Тиймээс эдгээр тоон үзүүлэлт учир дутагдалтай

¹¹ Е Векслер, “Аргентин дахь коронавирус: Эрүүл мэндийн ажилтнуудын гаргасан санал гомдлын дагуу, хот ба муж нь хувийн хамгаалах хэрэгслийн түгээлтэд өөрчлөлт хийв”, Кларин 2020 оны 4 сарын 17, https://www.clarin.com/sociedad/coronavirus-argentina-medio-reclamos-personal-salud-ciudad-provincia-modifican-distribucion-equipos-proteccion-personal_0_NijkjuITD.html

¹² “КОВИД-19 ба нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ эрхэлдэг ажилтнууд” 2020 оны 5 сарын 6, <https://files.ssi.dk/COVID-19-ansatte-social-og-sundhedsvaesenet-uge19-as23>

¹³ Фолха де Сан Пауло, «Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд коронавирусын халдвар авсан тохиолдол нэг сарын дотор хоёр дахин ихэссэн», 2020 оны 6 сарын 12, <https://www1.folha.uol.com.br/equilibrioesaude/2020/06/numero-de-casos-do-coronavirus-em-profissionais-de-saude-mais-do-que-dobra-em-um-mes.shtml>

¹⁴ Сувилагчдын Холбооны Зөвлөл, observatoriadaenfermagem.cofen.gov.br

¹⁵ PEBMED, Ковид-19: Бразил улсад вирусийн улмаас амиа алдсан эмч нарын тоо зуу давжээ, 2020 оны 5 сарын 27, <https://pebmed.com.br/covid-19-brasil-ultrapassa-a-marca-de-cem-medicos-mortos-por-conta-do-virus/>

¹⁶ Мексикийн Засгийн газар, Хэвлэлийн бага хурал #COVID19, (2020). <https://www.youtube.com/watch?v=h4pceSA8Xbl>

¹⁷ Coronavirus (COVID-19) related deaths by occupation, England and Wales: deaths registered between 9 March and 25 May 2020, <https://www.ons.gov.uk/peoplepopulationandcommunity/healthandsocialcare/causesofdeath/bulletins/coronaviruscovid19relateddeathsbyoccupationenglandandwales/deathsregisteredbetween9marchand25may2020#deaths-involving-covid-19-among-men-and-women-health-and-social-care-workers>

¹⁸ Коронавирустай холбоотой нас баралт, мэргэжил бүрээр, Англи улс, Уэлс: 2020 оны 3 сарын 9-нөөс 5 сарын 25-ны хооронд бүртгэгдсэн нас баралт, <https://www.ons.gov.uk/peoplepopulationandcommunity/healthandsocialcare/causesofdeath/bulletins/coronaviruscovid19relateddeathsbyoccupationenglandandwales/deathsregisteredbetween9marchand25may2020#deaths-involving-covid-19-among-men-and-women-health-and-social-care-workers>

¹⁹ CDC, АНУ-ын жишээ., <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html> [2020 оны 7 сарын 5-д шинэчлэгдэв]

²⁰ CDC, АНУ-ын жишээ., <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/cases-updates/cases-in-us.html>

байх магадлалтай. *Guardian* болон *Kaiser Health News*-ийн мэдээллээс үзэхэд АНУ-д тэргүүн шугамд ажиллаж буй 600 орчим эрүүл мэндийн ажилтан КОВИД-19 халдварын улмаас нас баржээ.²¹

- **ОХУ-ын** Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг КОВИД-19 цар тахлын үед амиа алдсан ажилтнуудын нэрсийг нэгтгэж,²² хэвлэлийн төв уг мэдээллийг баталгаажуулан 5-р сарын 18-ны байдлаар ОХУ-д 186 эрүүл мэндийн ажилтан КОВИД-19 халдварлын улмаас нас барсныг мэдээлсэн байна.²³ 6-р сарын 18-ны өдөр Росздравнадзор-ОХУ-ын эрүүл мэндийн хяналтын газрын дарга КОВИД-19-ын улмаас 489 эмч нас барсныг мэдэгдэв.²⁴ Хэдэн цагийн дараа тэд “тоон мэдээлэл албан ёсны биш харин интернэтээс авсан” гэж энэхүү мэдэгдлээсээ татгалзав.²⁵ Иймээс Эмнести Интернэшнл ОХУ-ын Засгийн газраас эдгээр тоог тодорхой болгохыг хүсч захидал илгээсэн.
- **Франц улс** эрүүл мэндийн ажилтнуудын нас баралтыг зөвхөн 4-р сарын сүүлээр бүртгэж эхэлсэн бөгөөд Эрүүл мэндийн газрын Ерөнхий захирал Жером Саломон өмнө нь “маш бага байсан” гэж ерөнхийлөн дурджээ.²⁶ Үүнээс үзэхэд одоо байгаа мэдээлэл бүрэн бус байх магадлалтай бөгөөд одоогоор судалгаанд хамрагдсан эмнэлгүүдийн 35% хувиас 30,000 гаруй тохиолдол, 16 нас баралт бүртгэгдсэн байна.²⁷ Бусад эмнэлгүүдийг бүрэн судалсны дараа үндэсний хэмжээнд энэ тоо илүү өндөр байх магадлалтай гэж таамаглаж байна. Нэмж дурдахад, “Францын Эмч нарын Бие даасан Тэтгэврийн Сан”-гийн судалгаагаар цар тахлын үед ажиллаж байсан 26 эмчийн нас баралтыг тоолсон бол “SOS Эмч нар”-ын мэдээлснээр эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийн 16% хувь нь КОВИД-19-ийн халдвар авсан гэж мэдэгджээ.²⁸ Мөн нийгмийн халамжийн ажилтнуудад КОВИД-19 хэрхэн нөлөөлж байгаа нь тодорхойгүй хэвээр байна.

Эмнести Интернэшнлийн хийсэн судалгаагаар эрүүл мэндийн ажилтнуудын нас баралтын хамгийн өндөр үзүүлэлттэй орнуудад АНУ (507), Орос (545), Их Британи (540, үүнээс: нийгмийн халамжийн ажилчид 262), Бразил (351), Мексик (248) Итали (188), Египет (111), Иран (91), Эквадор (82), Испани (63) багтжээ. Энэ мэдээллийг тогтмол шинэчилдэг бөгөөд хамгийн сүүлийн үеийн мэдээллийг эндээс үзнэ үү: <https://public.flourish.studio/visualisation/3015800/>²⁹

²¹ “Онцгой: АНУ-ын бараг 600 эрүүл мэндийн ажилтан Ковид-19-ийн улмаас амиа алдсан бөгөөд түүний тоо нэмэгдсээр байна”, *The Guardian*, 2020 оны 6 сарын 6, <https://www.theguardian.com/us-news/2020/jun/06/us-health-workers-dying-coronavirus-stats-data>

²² Эмгэнэлийн жарсаалт, <https://sites.google.com/view/covid-memory/home>

²³ М Литаврин нар, «Орост дор хаяж 186 эмч коронавирусийн улмаас нас барсан байна. Нас барагсдын тоо бусад орныхтой харьцуулахад 16 дахин их байна», 2020 5 сарын 19, <https://zona.media/article/2020/05/19/martyrology>

²⁴ ОХУ улс коронавирусийн улмаас амиа алдсан эмч нарын тоог эрс бууруулж байна, Ройтерс агентлаг, 2020 оны 6 сарын 18, <https://uk.reuters.com/article/uk-health-coronavirus-russia-medics/russia-revises-sharply-higher-coronavirus-death-toll-among-medics-idUKKBN23P1WU>

²⁵ https://web.telegram.org/#/im?p=@roszdravnadzor_official; Also: “Roszdravnadzor called unofficial data on nearly 500 physicians who died from COVID-19”, Interfax, 18 June 2020, <https://www.interfax.ru/russia/713731> үзнэ үү

²⁶ Л Гедж, “Эрх мэдэлтнүүд халдвар авсан болон нас барсан эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг чимээгүй илрүүлж эхэллээ”, Франц Интер 2020 оны 5 сарын 19, <https://www.franceinter.fr/societe/les-autorites-commencent-a-recenser-les-professionnels-de-sante-contamines-et-decedes-en-toute-discretion>

²⁷ Шинэ Коронавирусийн халдвар (SARS-CoV-2), КОВИД-19, <https://www.santepubliquefrance.fr/maladies-et-traumatismes/maladies-et-infections-respiratoires/infection-a-coronavirus/articles/infection-au-nouveau-coronavirus-sars-cov-2-covid-19-france-et-monde>

²⁸ Л Черел нар, “Ковид-19 гашуудал, Улс тэднээс нүүрээ буруулсан гэж ерөнхий эмч нарүздэг”, Франц Интер 2020 оны 6 сарын 5, <https://www.franceinter.fr/endeuilles-par-le-covid-19-des-medecins-generalistes-estiment-avoir-ete-trahis-par-l-etat>; CARMF, “Ковид-19 –өөс болж нас барсан 29 эмч нар”, 2020 оны 5 сарын 4, <http://carmf.fr/actualites/communiqués/2020/covid/cp-med-dcd-covid.pdf>

²⁹ Олон улс оронд COVID-19-тэй холбоотой эрүүл мэндийн ажилтнуудын нас баралтын талаар албан ёсны, дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй тул энэхүү зураглалыг улс орон бүрийн өөр өөр эх сурвалж ашиглан боловсруулсан болно. Энд орсон мэдээллүүд нь тухайн цаг мөчид бэлэн байгаа мэдээллийн товч мэдээлэл боловч улс орнуудын мэдээллийг болгоомжтой тайлбарлаж, харьцуулж үзэх хэрэгтэй. Нэгдүгээрт, “эрүүл мэндийн ажилтан” гэж хэн болох талаар улс орнуудад нэгдсэн ойлголт байхгүй байгаагаас гадна олон оронд зайлшгүй шаардлагатай ажилтнуудын мэдээлэл статистиكت огт тусгагдаагүй байна. Хоёрдугаарт, мэдээллийн эх үүсвэрийг улс орон даяар харьцуулах боломжгүй юм. Зарим улс орны засгийн газрууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын халдварлалт болон нас баралтын талаарх мэдээллийг нарийвчлан гаргасан байгаа бөгөөд энэхүү зураглалд дээрх мэдээллийг ашиглав. Бусад орнуудын хувьд Эмнести Интернэшнл нь иргэний нийгмийн хяналт гэх мэт засгийн газрын бус эх сурвалжуудад түшиглэсэн. Учир нь энэ талаарх засгийн газрын мэдээлэл нэг бол байхгүй эсвэл хангалтгүй байв. Мөн хэдийгээр найдвартай мэдээлэл байгаа ч тоон мэдээллүүдийг нь задлан шинжлэхэд зарим тохиолдолд хүндрэлтэй байв. Зарим улс оронд цар тахлын тархалтын цар хүрээ маш ноцтой байсан учраас эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын КОВИД-19-өөр халдвар авсан тоо ба

Ковид-19-ийн улмаас нас барсан эрүүл мэндийн ажилтнуудын тоо



Зарим улс орны мэдээлэл, дүн шинжилгээ нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд цар тахлын үед өвчлөлд илүү нэрвэгдэж, нас баралт өндөр түвшинд байгааг харуулж байна.

- Дэлхий даяарх хэд хэдэн судалгаанаас үзвэл эмнэлгийн ажиллах хүчний нэлээд хувийг эмэгтэйчүүд эзэлдэг байна. ДЭМБ-аас 2019 онд хийсэн судалгаагаар эрүүл мэнд, нийгмийн халамжийн ажилтнуудын 70% эмэгтэйчүүд эзэлж байгаа нь тогтоогджээ.³⁰ Тодруулбал **Испанид** КОВИД-19-ийн халдвар авсан нийт эрүүл мэндийн ажилтны 76.5% хувь нь эмэгтэйчүүд, мөн эрүүл мэндийн салбарын эмэгтэй ажиллах хүчний эзлэх хувь эрэгтэй ажилтнуудын эзлэх хувиас өндөр байна.³¹
- Их Британид өмнө нь хийсэн судалгаагаар ВАМЕ (өөрөөр хэлбэл хар арьст, ази эсвэл үндэстний цөөнх бүлэгт хамаардаг эрүүл мэндийн ажилтнууд) бүлэгт хамаарах эрүүл мэндийн ажилтнуудын КОВИД-19-тэй холбоотой нас баралтын хувийг нийт эрүүл мэндийн ажилтнуудын нас баралтын тоотой харьцуулахад харьцангуй их байгааг харуулсан. Зарим мэдээнээс үзвэл нас барсан эрүүл мэндийн ажилтнуудын 60 гаруй хувь нь дээрх ВАМЕ³²

нас баралт, өндөр байж болох юм. Бусад улс орны хувьд зохих ХХХ хангалтгүй байсан, эсвэл байгаа статистик нь зөвхөн нийт хүн амтай харьцуулахад эрүүл мэндийн ажилтнуудын нилээд хувь нь шинжилгээнд хамрагдсаныг харуулж байгаагаас энэ нь өндөр байж болох юм. Зарим улс орнууд мэдээлэл байхгүйгээс нийт тоо мэдэгдэхүйц дутуу үнэлэгдэх магадлалтай байна. Мөн улс орнуудын тоолох ялгаатай байдлаас шалтгаалан улс орнуудыг хооронд нь үнэн зөв харьцуулалт хийхэд хүндрэлтэй байна. Жишээлбэл, өмнө дурьдсанчлан АНУ-ын тоо баримт бүрэн бус мэдээлэл дээр үндэслэгдсэн бол Франц улс зөвхөн зарим эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдээс мэдээлэл цуглуулсан байна. Их Британи улс эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын ажилтнуудын аль алиных нь нас баралтыг бүртгэдэг цөөн улсын нэг юм. ОХУ-ын эрүүл мэндийн нийгэмлэгийн өгсөн нас барсан эмнэлгийн ажилтнуудын жагсаалтыг засгийн газар нь үгүйсгэж байна.

³⁰ Эрэгтэйчүүд удирддаг эмэгтэйчүүдийн байгууллагаас хүргэв: Дэлхийн эрүүл мэнд, нийгмийн салбарын ажиллах хүчний жендер ба тэгш байдлын шинжилгээ, Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, Ажиглагч цуврал №24, <https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/311322/9789241515467-eng.pdf>

³¹ <https://www.isciii.es/QueHacemos/Servicios/VigilanciaSaludPublicaRENAVE/EnfermedadesTransmisibles/Documents/INFORMES/Informes%20COVID-19/COVID-19%20en%20personal%20sanitario%2029%20de%20mayo%20de%202020.pdf>. As per data from the Ministry of Health as of 2018, women represent a majority in the health sector, especially among primary care nurses (78.7%), emergency nurses (71.23%), midwives (93.05% are women), nursing assistants (94.43%), paediatric nurses (73.11%) and administrative staff of health centres (82.44%). They are also in the majority, although to a lesser extent, in primary care (55.9%) and emergency medicine (54.71%). See: <https://pestadistico.inteligenciadegestion.mscls.es/publicoSNS/comun/Informe.aspx?IdNodo=23646> Үзэн үг

³² С. Марч нар, "Англи улсад Ковид-19-өөс болж нас барсан 10 эмчийн 6 нь - ВАМЕ бүлэгт хамаарч байна", *The Guardian*, 2020 оны 5 сарын 25, <https://www.theguardian.com/world/2020/may/25/six-in-10-uk-health-workers-killed-by-covid-19-are-bame>; Т.Кук нар, "Онцгой: Ковид-19-өөс болж нас барсан Үндэсний аюулгүй байдлын албаны ажилтнуудын нас барсан шалтгаанд хийсэн анализ", *HSJ*, 2020 оны 4 сарын 22, <https://www.hsj.co.uk/exclusive-deaths-of-nhs-staff-from-covid-19-analysed/7027471.article>. Мэдээллийн дагуу Үндэсний аюулгүй байдлын албаны ажиллах хүчний 79,2% нь "цагаан" арьст, 20,7% нь "азичууд", "хар арьст", "хятад", "холимог" буюу бусад "гэж тодорхойлдог." Үндэсний аюулгүй байдлын албаны

бүлэгт хамаарч байна гэж тогтоогдсон байна.³³ Энэ үзүүлэлт нь энэхүү хандлагын албан ёсны баталгаа болж байна.³⁴

- **Энэтхэгт** зайлшгүй шаардлагатай ажил мэргэжлүүд нь түүхээсээ улбаалан ялгаварлан гадуурхалд өртөж ирсэн кастын бүлэгтэй нягт холбоотой байна. Жишээлбэл, цэвэрлэгээний ажилтан нь (нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх, бохир ус, бие засах газар цэвэрлэх, хог түүж цэвэрлэх ажилд оролцдог) ихэвчлэн **далит** бүлэгт хамаарах хүмүүс байдаг. Энэтхэгт КОВИД-19 цар тахлын үед цэвэрлэгээний ажилтны ажлын байрыг илүү сайн хамгаалах, ажиллах нөхцөлийг сайжруулах талаар анхаарч ажиллахыг зааварлаж байсан байна. (Энэ талаар дараа нь дэлгэрэнгүй авч үзэх болно).³⁵ Цэвэрлэгээний ажилтнуудыг зохих хамгаалалтгүйгээр ажиллуулж байгаа нь нийгэмд ялгаварлан гадуурхагдаж ирсэн кастын бүлэгт харьцангуй ихээр нөлөөлсөн байж болно.
- **Финлянд улсад** Хельсинк Хотын захиргаанаас гаргасан өмнөх мэдээллээс харахад сомали хэлээр ярьдаг хүмүүс КОВИД-19-ын халдварт илүү өртсөн аж. Нийт хүн амын дунд өвчлөл 0.4% -тай байхад сомали хэлээр ярьдаг бүлэгт хамаарах хүмүүсийн 2.4% хувь нь халдварт өртсөн гэж мэдэгджээ. Зарим судалгаа сомали хэлээр ярьдаг бүлгийн хүмүүс ихэвчлэн зайлшгүй шаардлагатай ажилтнаар ажилд орох магадлал өндөр байдаг нь ийнхүү түвшин өндөр гарахад нөлөөлсөн байх магадлалтай гэж дүгнэжээ.³⁶

Эдгээр мэдээллээс үзвэл, дээр дурдсан зарим улс орнуудад, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад КОВИД-19 харьцангуй тэгш бус нөлөөлсөн байж болзошгүй гэсэн түгшүүр төрүүлж байгаа тул нэн яаралтай мөрдөн шалгах шаардлагатай байна. Энэ чиглэлээрх мэдээллийн найдвартай байдал, улс орнуудын мэдээлэл цуглуулах, тайлагнах арга хэлбэр харилцан адилгүйгээс цар тахлын энэ үе шатанд эцсийн тодорхой дүгнэлт хийхэд хэцүү байна. Тухайлбал, эрүүл мэндийн ажилтнуудын дунд халдварын тархалт өндөр байгаа нь бусад хүмүүсийг бодвол эдгээр ажилтнууд оношлогоо шинжилгээнд илүү хамрагдсантай холбоотой байж болох юм. Түүнээс гадна улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг янз бүрээр тодорхойсноос энэ мэдээлэлд зарим ажилтнууд хамрагдаагүй байж болох талтай.

Өөр өөр улс орнуудад эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай хичнээн ажилтан КОВИД-19-өөс шалтгаалан амьтаснаа алдсаныг тооцоолох, нас баралтын шалтгааны талаар дүгнэлт гаргахад арга зүйн асуудал чухал нөлөөтэй. Хэд хэдэн улс оронд тахал өвчний цар хүрээ, нөхцөл байдал хүнд ноцтой байсан тул эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын КОВИД-19-халдварын эндэгдэл, халдварын тоо өндөр байж болох юм. Зарим улс оронд зохих хувийн хамгаалах хэрэгсэл (ХХХ) хангалтгүйгээс энэ тоо өндөр байж магадгүй юм. Бусад орнуудад нь энэ талаар мэдээлэл байхгүй, эсвэл тоолдоггүй, эсвэл нуугдмал байж болно.

Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын КОВИД-19-ийн халдвар авсан болон халдварын шалтгаантай нас баралтын түвшний талаарх мэдээлэл маш чухал. Энэхүү мэдээлэл нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад ямар эрсдэл учирч байгааг ойлгох чухал арга хэрэгсэл болох ба ирээдүйд улс орнууд эрүүл мэндийн тогтолцоогоо илүү сайн бэлтгэхэд түлхэц болно. Түүнчлэн эдгээр өвөрмөц эрсдлүүдийн шалтгаан, цаашид хэрхэн урьдчилан сэргийлэх талаар бодох зайлшгүй шаардлагыг бий болгож өгнө. Энэхүү мэдээллийг ялгаварлан гадуурхахыг хориглох үндэслэл, ажлын байр, ажил мэргэжлээр нь ялган хувааж авч үзэх хэрэгтэй ба ингэснээр улс орнуудад тахал өвчний үр нөлөөг илүү сайн үнэлэх болон ирээдүйд тодорхой бүлгийг хамгаалахын тулд ямар стратеги бий болгох шаардлагатай зэргийг үнэлэх өргөн боломж нээгдэх юм.

ажиллах хүч-хэсгийг үзнэ үү: Угсаатны талаарх баримт ба тоо мэдээлэл”, 2020 оны 1 сарын 6, <https://www.ethnicity-facts-figures.service.gov.uk/workforce-and-business/workforce-diversity/nhs-workforce/latest#by-ethnicity>

³³ Мэдээллээс гадна: Английн нийтийн эрүүл мэнд: ВАМЕ бүлгүүдэд COVID-19-ийн үзүүлэх нөлөөллийг ойлгох нь, 2020 6сар, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/892376/COVID_stakeholder_engagement_synthesis_beyond_the_data.pdf

³⁴ Английн Нийгмийн эрүүл мэндийн салбар, КОВИД-19-ийн эрсдэл ба үр дагаврын ялгаа, 2020 оны 6 сар, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/892085/disparities_review.pdf

³⁵ Энэтхэгийн Эмнести Интернэшнл, Тэргүүн шугамд орхигдсон нь: Энэтхэгийн цэвэрлэгээний ажилчид КОВИД-19-ийн үеэр засгийн газраасаа яаралтай тусламж эрэлхийлж байна, 2020 оны 4 сарын 24, <https://amnesty.org.in/abandoned-at-the-front-line-indias-sanitation-workers-seek-immediate-help-from-the-government-amidst-covid-19/>

³⁶ Хельсинкэд 2017 онд нийтлэгдсэн тайланд (“Хотжилт - 2020 онд Хельсинкийн гадаад гаралтай оршин суугчдын талаархи дэлгэрэнгүй зураг”) дурдсанаар, Сомали гаралтай ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн тал хувь нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний салбарт ажиллаж байсан бөгөөд Сомали гаралтай ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн бараг 40% нь тээвэр, ложистикийн чиглэлээр ажиллаж байжээ. Гэсэн хэдий ч нөлөөллийн түвшний ялгааны бусад шалтгаанууд нь сомали хэл дээрх цар тахлын талаархи мэдээлэл дутмаг, сомали хэлээр ярьдаг нийгэмлэгийн олон гишүүн жижиг орон сууцанд амьдардагтай холбоотой байжээ.

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД
КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

Эмнести Интернэшнл

4.2 ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН (ХХХ) ХОМСДОЛ

Эмнести Интернэшнлийн мэдээлэл цуглуулсан 63 улс орон, нутаг дэвсгэрт эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад ХХХ хомсдолтой гэсэн мэдээлэл бүртгэгдсэн байна. Үүний дор хаяж 31-т нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажил хаялт, ажил хаялт хийхээ мэдэгдсэн, эсэргүүцлийн жагсаал хийсэн талаарх мэдээллийг Эмнести

Интернэшнлийн судлаачид бүртгэсэн байна.³⁷ Энэхүү тайланд ХХХ (Хувийн Хамгаалах Хэрэгсэл) гэдэгт эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг КОВИД-19-өөс өөрсдийгөө хамгаалах зорилгоор авч хэрэглэхийг зөвлөсөн бээлий, эмнэлгийн болоод мэс заслын нүүрний маск, нүдний шил, нүүрний хамгаалалт, нөмрөг, амьсгалын аппарат, хормогч зэрэг ХХХ, тоног төхөөрөмж, материалыг багтаасан болно.³⁸ Энэ хэсэгт байгаа олонх мэдээлэл зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажлын нөхцөлтэй төдийлөн хамаарахгүй, харин эрүүл мэндийн ажилтнуудын ажлын нөхцөлтэй илүү хамааралтай байгаа нь эрүүл мэндийн ажилтнуудын санаа зовох асуудал илүү их мэдээлэгдсэнтэй холбоотойг илэрхийлж байна. ХХХ-ийн хомсдол нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад адилхан нөлөөтэй. Эмнести Интернэшнл анх эхлэхээс нь эрсдэлийн ижил түвшинд ажиллаж байгаа эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хамгаалах стандарт ижил байх ёстой гэдгийг цохон тэмдэглэж ирсэн.



Испанийн Хуеска хотод байрлах Сан Хорхе эмнэлгийн яаралтай хүлээн авах хэсгийн хаалган дээр хувийн компаниас зээлээр авсан хогны уут, хамгаалалтын маск өмссөн яаралтай тусламжийн сувилагч (ICU). © 2020 Гетти Зурууд

«Бид өдөр бүр хүмүүс дээр очиж ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэхийг асуудаг. Гэхдээ бид ямар ч маск, бээлийгүйгээр очдог. Миний нүүрэндээ боож уясан алчуур бол зүгээр л сэтгэлээ хуурч байгаа зүйл. Энэ намайг хамгаалж чадахгүй.»

Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, Энэтхэг³⁹

³⁷ Жишээ үзнэ үү: Л Тогиба, “Папуа Шинэ Гвиней бэлтгэлгүй байна”: 4000 сувилагч Ковид-19-ын бэлэн байдлыг эсэргүүцэн ажил хаяна” The Guardian, 2020 оны 3 сарын 30, <https://www.theguardian.com/world/2020/mar/30/papua-new-guinea-is-not-prepared-4000-nurses-to-strike-over-covid-19-readiness>; “Өмнөд Африк дахь сувилагчид ХХХ, орлогын албан татварын хөнгөлөлт, Аюултай нөхцөл байдлын хөнгөлөлт зэргийг шаардаж эсэргүүцлээ илэрхийлэв”, Ардын Элч, 2020 оны 5 сарын 1, <https://peoplesdispatch.org/2020/05/01/nurses-in-south-africa-protest-demanding-ppe-income-tax-breaks-and-danger-allowance/>

³⁸ ДЭМБ, (КОВИД-19) Коронавирусын өвчний үе дэх хувийн хамгаалах хэрэгслийг зохистой ашиглах ба хүндрэлийн үед анхаарах зүйлс, Завсрын Удирдамж, 2020 оны 4 сарын 6, [https://www.who.int/publications/i/item/rational-use-of-personal-protective-equipment-for-coronavirus-disease-\(covid-19\)-and-considerations-during-severe-shortages](https://www.who.int/publications/i/item/rational-use-of-personal-protective-equipment-for-coronavirus-disease-(covid-19)-and-considerations-during-severe-shortages)

³⁹ Нийгмийн эрүүл мэндийн ажилтантай хийсэн ярилцлага, Энэтхэг, 4-5 сар 2020

Нийтийн үйлчилгээний олон улсын байгууллага (PSI), Дэлхийн өнцөг булан бүрийн 30 сая ажилтнууд, 700 гаруй холбоог эгнээндээ нэгтгэсэн Дэлхийн Үйлдвэрчний Эвлэлийн Холбооноос 2020 оны 5-р сарын 11-ний өдөр КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын өмнө тулгамдаж буй асуудлуудын талаар өөрийн гишүүдийн хийсэн судалгааг нийтлэв. Судалгаа 62 орны хариу мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд судалгаанд оролцсон үйлдвэрчний эвлэлүүдийн зөвхөн 23.8 хувь нь эрүүл мэндийн ажилтнуудад “XXX-ийг бүрэн, эсвэл нөхөн олгосон” гэж хариулсан (57 хувь нь олгогдоогүй гэж мэдэгдсэн), харин үйлдвэрчний эвлэлийн холбоодын 14.1 хувь нь төрийн үйлчилгээний ажилтнуудад зохих XXX олгогдсон, (64.1% нь тэдэнд огт олгогдоогүй) гэж мэдээлсэн байна.⁴⁰ Түүнчлэн бүс нутгийн түвшинд мэдэгдэхүйц ялгаа байсан.Тухайлбал, Америк хоорондын бүсэд судалгаанд хамрагдагсдын 69.7% нь эрүүл мэндийн ажилтнуудад зохих XXX олгогдоогүй гэж хариулсан бол 76.1% нь халдвар авсан хүмүүстэй холбоо тогтоож болзошгүй төрийн үйлчилгээний ажилтнуудад зохих XXX олгогдоогүй гэжээ.⁴¹ Ази тивд эдгээр үзүүлэлт 50% ба 51.4% тус тус байв.⁴² Олон улсын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо (ITUC) өөрсдийн гишүүдийн дунд үүнтэй ижил төстэй судалгаа хийсэн байна. 2020 оны 4-р сарын 28-нд нийтлэгдсэн энэхүү судалгаанаас үзэхэд “эрүүл мэндийн болон асаргаа сувилгааны ажилтнуудад хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) хомсдолтой байгаа нь ихэнх улс орнуудын ноцтой асуудал болж байна” гэжээ. Улс орнуудын ойролцоогоор 51% нь “XXX хангамж ихэвчлэндээ ховор, хэзээ ч хүрэлцээтэй хэмжээнд байдаггүй” гэж хариулжээ.⁴³

Ийм нөхцөлд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд өөрсдийгөө хамгаалахын тулд янз бүрийн хамгаалалтын хэрэгслүүдэд найдахаас өөр замгүй болж байгаа нь тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж буй хэрэг юм. Зарим улс оронд нэгэнт XXX-ээр хангахгүй байгаагаас ажилтнууд өөрсдөө XXX-ийг худалдаж авах, үнийг нь төлөхөөс өөр аргагүй байдалд хүрч байна гэж мэдэгдэж байв. Бусад оронд хүмүүс хогны уут, борооны цув гэх мэтийг ашиглан өөрсдийгөө хамгаалах арга зам хайхаас аргагүй байдалд хүрсэн тухайгаа мэдээлэв. **Мехико** хотын нэгэн эмч Эмнести Интернэшнлд хэлэхдээ “Эмч нар бид бүгд сар бүрийн цалингийнхаа 12 орчим хувийг зориулалтын хамгаалах нөмрөг, нүүрний хамгаалалт, нүдний шил, хамгаалалтын шил худалдаж авахад зарцуулж байсан” гэв.⁴⁴

Их Британийн Эрүүл мэндийн Нийгэмлэг (BMA) 2020 оны 4-р сард Их Британийн 16000 гаруй эмч нарын дунд шаардлагад нийцсэн XXX-тэй холбоотой асуудлаар судалгаа хийсэн байна. Эрүүл мэнд болон нийгмийн халамжийн салбарын эмч нарыг хамруулсан уг судалгаанд оролцогчдын 48 орчим хувь нь тэдний ажилладаг тасагт XXX дутагдалтай тул өөрсдийн болон тасгийнхаа хэрэглээнд зориулан XXX-ийг худалдаж авсан, эсвэл хандивлагдсан XXX-ийг ашиглаж байгаа гэж хариулсан байна. Мөн эмч нарын 65% нь өөрийгөө “хэсэгчлэн эсвэл бүрэн хамгаалагдаагүй” гэж үзсэн байна.⁴⁵ **Шведийн** Үйлдвэрчний эвлэлийн холбооноос эрүүл мэндийн ажилтнуудын дунд явуулсан судалгаагаар гэрийн асаргааны ажилчдын 42% нь зохих XXX-гүй нөхцөл байдалд ажиллахаас аргагүйд хүрдэг гэж мэдэгдсэн бол 84% нь XXX-ийн дутагдалтай байдалд санаа зовж байгаагаа, 48% нь XXX-ийн хомсдолын талаар мэдээлсэн.⁴⁶ **АНУ-д** Үндэсний Сувилахуйн Нэгдсэн Холбоо (NNU) нь 23,000 орчим сувилагчдын дунд судалгаа явуулсан бөгөөд судалгаанд оролцогчдын 87% нь нэг удаагийн амьсгалын аппарат, эсвэл нэг удаагийн маскыг КОВИД-19ийн халдвар авсан өвчтөнд дахин хэрэглэхэд хүрч байгааг тогтоосон; КОВИД-19-ийн халдвар авсан нь батлагдсан өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлдэг

⁴⁰ PSI, КОВИД-19 хариу арга хэмжээний талаарх Холбооны судалгаа, Дэлхийн баримт бичгийн судалгаа, 2020 оны 5 сарын 11, https://pop-umbrella.s3.amazonaws.com/uploads/3abcd99c-219b-4b9e-af1e-fa3ac2c398b7_COVIDSurvey_GlobalSummaryIntro.pdf?key=

⁴¹ PSI, КОВИД-19 хариу арга хэмжээний талаарх Холбооны судалгааны үр дүн [Америк тивийн судалгаа], https://data.surveygizmo.com/r/310559_5eb95355d438c6.4011487

⁴² PSI, КОВИД-19 хариу арга хэмжээний талаарх Холбооны судалгааны үр дүн [Ази Номхон далайн орнуудын судалгаа], https://data.surveygizmo.com/r/310559_5eb40d60a27e33.72816889

⁴³ ITUC КОВИД-19 Дэлхийн Судалгаа – Гол дүгнэлтүүд, https://www.ituc-csi.org/IMG/pdf/200428_ituc_covid-19_globalsurveyreport_en.pdf

⁴⁴ Эмчтэй хийсэн ярилцлага, Мехико хот, Мексик, 2020 оны 4 сарын 24

⁴⁵ BMA судалгаагаар эмч нарын бараг тэн хагас нь хандивласан эсвэл өөрөө худалдаж авсан XXX-д найдаж байсан бөгөөд гуравны хоёр нь бүрэн хамгаалалтгүй гэж үзэж байна, 2020 оны 5 сарын 3, <https://www.bma.org.uk/news-and-opinion/bma-survey-reveals-almost-half-of-doctors-have-relied-upon-donated-or-self-bought-ppe-and-two-thirds-still-don-t-feel-fully-protected>

⁴⁶ Kommunal, “Хамгаалах хэрэгслийн талаархи шуурхай судалгаа”, 14 дэх долоо хоног: 2020 оны 4 сарын 1-2-ны өдрүүд

сувилагчдын 27% нь зохих ХХХ-гүйгээр 14 хоногийн турш ажилласан гэж мэдээлсэн, харин сувилагчдын 84 хувь нь тэднээс тестийн шинжилгээ хараахан аваагүй байгааг хэлсэн байна.⁴⁷

Нигерийн нэгэн эмч Эмнести Интернэшнлд хэлэхдээ “Миний ажилладаг эмнэлэгт мэс заслын маск хүрэлцээтэй бус. Эрх баригчид даавуугаар шаардлагад нийцэхгүй маск оёулахаар оёдолчидтой гэрээ байгуулсан. N95 маск өгөхөөс өмнө эмч, сувилагч нар эсэргүүцэл илэрхийлэхээс өөр аргагүй байсан.⁴⁸ Эдгээр маск нь тооны хувьд хангалттай байдаггүй. Бид дахин хэрэглэхийн тулд маскыг угаах ёстой болдог. Эмнэлгийн мэргэжилтнүүд аюулд орж байна. Бид үнэхээр хүнд нөхцөлд ажиллаж байна” гэжээ.⁴⁹

4-р сарын 5-нд КОВИД-19-ийн анхны тохиолдлыг бүртгэж байсан **Өмнөд Суданы** эрүүл мэндийн ажилтан Эмнести Интернэшнлд хэлэхдээ “Өнгөрсөн тавдугаар сард 4000ш орчим ХХХ байсан. Түүний магадгүй тал хувь нь, эсвэл дөрөвний гурав орчмыг нь тэргүүн шугамын ажилтнууд, мөн ариутгал хийж буй хүмүүс, оршуулгын багийнхан ашиглаж байсан. Дөрвөн мянга гэдэг нь бидний хүссэн хэмжээ биш, бидэнд дор хаяж 10,000 шаардлагатай байгаа боловч засгийн газар санхүүгийн хувьд бэрхшээлтэй байгаагаас хандив тусламжид л найдвар тавьж байна.”⁵⁰

Финляндад хийсэн судалгаагаар, (Финляндын Сувилагчдын Нийгэмлэгтэй хамтран хийсэн судалгаа) Финляндын эрүүл мэндийн ажилтнууд заримдаа нэг удаагийн нөмрөгний оронд борооны цув хэрэглэдэг байсан ба тэдэнд амны цаасаар маск хийхийг заадаг байжээ.⁵¹

Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд шаардлагад нийцсэн ХХХ хүрэлцэхгүй байгаа асуудлаар шүүх, эсвэл бусад захиргааны байгууллагад хандсан байна. **Их Британи, Өмнөд Африк, Швед, Энэтхэг, Зимбабве, Пакистан, Испани, Франц улсуудад** энэ асуудлаар төлөвлөгдсөн, явагдаж байгаа, эсвэл дуусгавар болсон шүүх ажиллагаа, эсвэл түүнтэй адилтгах засаг захиргааны байгууллагуудын хэргийн талаар Эмнести Интернэшнлд зохих мэдээллүүд бий. Зарим тохиолдолд шүүх ажилтнуудын талд шийдвэр гаргасан байна. Жишээлбэл, эрүүл мэндийн ажилтнуудын үйлдвэрчний эвлэлүүд өргөдөл гаргасны дараа **(хандсаны дараа)** Испанийн Дээд шүүх Эрүүл Мэндийн Яамнаас “эмнэлгийн ажилтнуудад зориулсан хамгаалах хэрэгслийг хамгийн сайн хуваарилах бүхий л бололцоот арга хэмжээг авч ажиллахыг хүсч, энэ зорилгоор авсан арга хэмжээг 15 хоног тутамд шүүхэд мэдэгдэж байхыг” хүсчээ.⁵²

Харин **Пакистаны** Лахор хотын дээд шүүхэд эрүүл мэндийн ажилтнууд бусад шаардлагуудын хамт “КОВИД-19-ийн эсрэг тэмцэж буй эрүүл мэндийн бүх ажилтныг ХХХ-ийн иж бүрдлээр хангах” талаар Шүүхээс Засгийн газарт чиглүүлэг өгөхийг хүсч өргөдөл гаргасан боловч шүүх нэгэмжлэлийг хэрэгсэхгүй болгов.⁵³ Түүнээс гадна, шүүх өргөдөл гаргагчдыг шүүмжилж, ...шүүхэд хэрэгсэхгүй нэхэмжлэл нь ямар ч үндэслэлгүй, шударга бус алхам бөгөөд нийгмийн сүлжээнд олны анхаарлыг татах гэсэн оролдлого юм... гэж үзэн ... Иймд **[өргөдөл]**-ийг нөхөх олговортойгоор хэрэгсэхгүй болгож байна ... Хэрэв нэр дурдагдсан байгууллага өргөдөл гаргагчийн үйлдэл нь төрийн үйлчилгээний хэм хэмжээтэй зөрчилдсөн, зүй зохиосгүй үйлдэл гэж үзвэл, холбогдох хуулийг зөрчсөн, эсхүл байгууллагын нэр хүндийг унагах зорилгоор ийнхүү өргөдөл гаргасан

⁴⁷ Үндэсний Сувилагчдын Холбоо, Сувилагчаас авсан шинэ судалгаа нь засгийн газар, ажил олгогчдын зүгээс сувилагч, өвчтөний аюулгүй байдлыг үл тоомсорлож зохих ХХХ-ээр хангахгүй байгаагийн наад захын баталгааг харуулж байна, 2020 оны 5 сарын 20, <https://www.nationalnursesunited.org/press/new-survey-results>

⁴⁸ Нигери улсад энэ асуудлаар хэд хэдэн эсэргүүцлийн жагсаал зохион байгуулагдсан, жишээг үзнэ үү: Нигерийн эмч нар PPP-ийн дутагдалтай байдал, болон өөрсдийн нийгмийн асуудлыг эсэргүүцэн тэмцэв, Аль Жазира, 2020 оны 6 сарын 15, <https://www.aljazeera.com/news/2020/06/nigerian-doctors-strike-lack-ppe-welfare-concerns-200615084342885.html>; Нигерийн эмч нар вирусийн халдварын улмаас ажил хаялтыг зогсоов, VOA, 2020 оны 6 сарын 21, <https://www.voanews.com/africa/nigerian-doctors-end-strike-virus-cases-spike>

⁴⁹ Эмчтэй хийсэн ярилцлага, 2020 оны 4 сарын 27 [утсаар]

⁵⁰ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Өмнөд Судан, 2020 оны 6 сарын 11.

⁵¹ Жишээ үзнэ үү: “Сувилагч нар өөрсдийгөө борооны цув, гал тогооны алчуураар хамгаалахыг зааварлав.- Коронавирусийн судалгаа өдөр тутмын баргар амьдралыг илтгэв”, 2020 оны 4 сарын 17, <https://sairaanhoitajat.fi/sairaanhoitaja-ohjeistettu-suojautumaan-sadetakkiin-ja-talouspaperiin-koronakysely-paljastaa-karun-arjen/>; “Хамгаалалтын хэрэгслийн хомсдол одоо ч үргэлжилсээр - одоо хамгаалалтын хантааз ч хомсдож байна”, 2020 оны 4 сарын 22, <https://www.tehy.fi/fi/mediatiedote/tehy-n-kysely-pula-suojavarusteista-jatkuu-nyt-vahissa-suojatakit>

⁵² <http://www.poderjudicial.es/cgpj/es/Poder-Judicial/Tribunal-Supremo/Sala-de-prensa/Notas-de-prensa/El-Tribunal-Supremo-requiere-a-Sanidad--todas-las-medidas-a-su-alcance--para-distribuir-medios-de-proteccion-al-personal-sanitario>

⁵³ Шүүхийн шийдвэр Эмнести Интернэшнлийн архивт бий.

гэдэг нь тогтоогдвол эрх бүхий этгээдийн зүгээс тэдгээрийн эсрэг шүүх ажиллагаа эхлүүлэх эрхтэй болно” гэж мэдэгдсэн байна.

Дэлхий даяар эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад ХХХ-ийн олдоц муу, олж авахад хэцүү байсан явдалд олон шалтгаан бий. Эрэлт огцом нэмэгдсэнээс дэлхийн хэмжээнд жинхэнэ хомсдол үүссэн гэдэг нь цорын ганц шалтгаан биш юм. Зарим улс орны хувьд баримталж буй бодлого нь өөрөө эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад шаардлагатай хамгаалах хэрэгслийг олж авахад хэцүү болгож байв. Жишээлбэл, цар тахлын эхэн үед Никарагуагийн засгийн газар улс орны дотоодод КОВИД-19-ийн эрсдлийг бууруулахыг оролдохдоо эрүүл мэндийн ажилтнуудад зайлшгүй шаардлагатай ХХХ хэрэглэхийг хориглож байсан байна.⁵⁴

Олон улс оронд энэ талаарх мэдээлэл хомс байгаа нь ХХХ-ийн хэр зэрэг дутагдаж байгааг тогтоох явцыг хүндрэлтэй болгосноос гадна эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтныг зохих хэмжээгээр ХХХ-ээр хангахад хичнээн хэмжээний хөрөнгө шаардлагатай талаар дэлхий нийтийн тооцоо хараахан гараагүй байна. Цар тахлын эхэн үед, “бээлий, эмнэлгийн маск, амьсгалын аппарат, нүдний шил, нүүрний хамгаалалт, нөмрөг гэх мэт ХХХ-ийн хангамжийн хязгаарлагдмал байдлаас болж КОВИД-19-ийн өвчтөнийг халамжлах эмч, сувиллагч болон бусад тэргүүн эгнээнд ажиллагсдыг хамгаалалтгүй орчинд орхиж байна” гэж ДЭМБ-аас анхааруулсан ба есөн нэмэгдэж буй эрэлтийг хангахын тулд ХХХ-ийн үйлдвэрлэлийн хэмжээг 40%-иар нэмэгдүүлэх шаардлагатай гэж тооцоолсон байна.⁵⁵

ХХХ-ийн хомсдолын цар хүрээний хэмжээг үндэсний үнэлгээ тодорхой зааж өгдөг. **АНУ-д “GetUsPPE”** хэмээх вэб дээр суурилсан платформ нь тус улсын 632 эрүүл мэндийн тусламж үйчилгээ үзүүлдэг газруудын мэдээлэлд үндэслэн 2020 оны 4-р сард мэдээлэл нийтэлжээ. Уг мэдээллээс харахад судалгаанд хамрагдсан байгууллагуудын дийлэнх нь ХХХ-ийн хоёр долоо хоног хүрэхгүй хугацааны нөөцтэй үлдсэн байв. Тухайн үед 36% нь нүүрний хамгаалалтын үлдэгдэлгүй, 22% нь N95 амьсгалын замын халдвараас сэргийлэх маскгүй, 20% нь нэг удаагийн хамгаалах нөмрөггүй байжээ.⁵⁶ 2020 оны 5-р сард **Пакистаны** Үндэсний командлалын Төвөөс “нэг удаагийн 19,960 бээлий, 1.6 сая латекс (**latex**) бээлий, 963,638 нүдний шил, 84.327 нүүрний хаалт, 166.633 нэг удаагийн малгай, 178.323 улавч, 13.501 усны гутал, 5 сая мэс заслын маскны хомсдол үүссэн” гэж мэдэгдсэн байна.⁵⁷

ОХУ-ын “Ведомости” сонинд 5-р сарын 1-ний байдлаар амны хаалт 26 хувь, амьсгалын замын халдвараас сэргийлэх маск 27 хувь, бээлий 17 хувь, хамгаалалтын хувцас 30 хувийн хангамжтай байна гэж үнэлжээ.⁵⁸ Худалдааны хязгаарлалт нь олон улсын зах зээл дээр ХХХ худалдан авахаар өрсөлдөж буй зарим орны байдлыг улам хурцатгасан байж болно. Цар тахал дэгдэлт эхэлснээс хойш дэлхийн хэд хэдэн улс орон ХХХ болон зайлшгүй шаардлагатай зарим бараа бүтээгдэхүүний импортын болон экспортын журамдаа өөрчлөлт оруулжээ. Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ) нь КОВИД-19-ийн хүрээнд улс орнуудаас авч хэрэгжүүлсэн худалдааны арга хэмжээнд хяналт тавьж ажилласан байна.⁵⁹ Тэдний мэдээллээс үзэхэд 2020 оны 6-р сарын 5-ны байдлаар 56 орон, худалдааны хоёр холбоо (**Европын холбоо, Евразийн эдийн засгийн холбоо**) ХХХ-ийн нийт эсвэл зарим экспортыг, эсвэл ХХХ-ийн үйлдвэрлэлийн түүхий эдийг экспортлохыг хориглох, хязгаарлах арга хэмжээ авчээ. Жишээлбэл, **Колумб, Бангладеш** зэрэг орнууд зарим төрлийн ХХХ дээр экспортын түр хориг тавьсан байна. Хэд хэдэн улс орон тарифыг бууруулж, импортын квотыг нэмэгдүүлэх зэргээр ижил төрлийн бүтээгдэхүүний импортын дүрмийг ч өөрчилсөн байна. Улс орнууд дээр дурдсан хамгаалалтын арга хэмжээ авах үндэслэл бүхий шалтгаантай байж болно. Тухайлбал, тэд өөрсдийн нутаг дэвсгэрт эрүүл мэндийн

⁵⁴ Эмнести Интернэшнл, Эмчилгээний өртөг: КОВИД-19 ба түүнээс цаашир хугацаанд Америк дах эрүүл мэндийн ажилчдын эрх, (Index: AMR01/2311/2020)

⁵⁵ ДЭМБ, Хувийн хамгаалах хэрэгслийг хомсдол дэлхийн хэмжээнд эрүүл мэндийн ажилтнуудад аюул учруулж байна, 2020 оны 3 сарын 3, <https://www.who.int/news-room/detail/03-03-2020-shortage-of-personal-protective-equipment-endangering-health-workers-worldwide>

⁵⁶ Дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү: <https://getusppe.org/>

⁵⁷ “Засгийн газар огцом нэмэгдэхийг таамаглаж байна”, *Даун*, 2020 оны 5 сарын 1, https://epaper.dawn.com/print-textview.php?StoryImage=01_05_2020_001_009

⁵⁸ А Соколов, “Орост яагаад коронавирусээс хамгаалах хангалттай хэрэгсэл байхгүй байна вэ” *Ведомости* 2020 оны 5 сарын 1, <https://www.vedomosti.ru/society/articles/2020/05/01/829484-ne-hvataet-sredstv-zaschiti>

⁵⁹ ДХБ, КОВИД-19: Худалдаа, худалдан авахтай холбоотой арга хэмжээнүүд, https://www.wto.org/english/tratop_e/covid19_e/trade_related_goods_measure_e.htm

болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хэрэгцээт ХХХ-ээр хангах шаардлага тулгарсан байж болно. Гэсэн хэдий ч эдгээр арга хэмжээ нь ХХХ үйлдвэрлэдэггүй, одоогоор ХХХ-ийн нөөцгүй болсон тул зөвхөн импортоос хамааралтай улс орнуудад хомсдлыг улам хүндрүүлэх эрсдэлтэй байдаг. ЭЗНСЭ-ийн Хорооноос “Оролцогч улсууд КОВИД-19-тэй тэмцэхэд өөрийн орноос гадна дэлхийн хэмжээнд хүчин чармайлт гаргаж ажиллах үүрэг хүлээдэг. Ялангуяа дэлхийн өндөр хөгжилтэй орнууд цар тахлын дэлхийн хамгийн ядуу хохирогчдод амин чухал хэрэгцээт тоног төхөөрөмж олж авахад нь хүндрэл учруулахгүйн тулд эмнэлгийн тоног төхөөрөмжийн экспортыг хязгаарлах аливаа шийдвэр гаргахаас зайлсхийх хэрэгтэй” гэдгийг тэмдэглэжээ.⁶⁰

4.3 АЖЛЫН ХЭТ АЧААЛАЛ БА СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ

Одоогийн нөхцөл байдлыг зүйрлэж хэлбэр, өдөр бүр гүйлтийн зам дээр хамгийн хүрдэн дээр нь тохируулан хүрдаа хадгалахыг хичээн гүйж байгаатай адил бөгөөд хүн бүр ядарч туйлдсан, сандарч тэвдсэн байдалтай байна» Эрчимт эмчилгээний тасгийн сувилалгчдын хувьд бид нэг өвчтөнтэй байдаг байсан бол 3-5 өвчтөнтэй болсон. Эмнэлгийн бусад тасгуудаас бидэнд туслахаар мэргэжил нэгт нөхөд маань ирсэн хэдий ч тэд ийм орчинд ажиллаж дасаагүйгээс сандарч тэвдэх зүйл их гардаг, бидний өгч чадахгүй маш их дэмжлэг, зааварчилгаа тэдэнд хэрэгтэй байдаг.

40 насандаа нөхрөө алдаж, 2 хүүхдээ ганцаараа өсгөж байсан эмэгтэйд амьсгалын аппаратанд оруулахыг түлд хариуцаж байсан сувилалгч гарыг нь атган тайвшруулан, унтуулах тариа хийж, хүү нь ээждээ утсаар баяртай гэж хэлэхийг сонсоод би их уйлсан. Сэтгэл их хүнд байсан.»

Сувилалгч, Их Британи⁶¹

Хэд хэдэн улс оронд угаасаа ажлын ачаалал өндөртэй ажилладаг байсан эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ачаалал цар тахлын үед улам бүр нэмэгдсэн. Энэ хэцүү цаг үед ажлын цаг нэмэгдэж, ажлын байрны нөхцөл өөрчлөгдөх (жишээ нь, ээлжийн амралтаа хэзээ авах нь тодорхойгүй болох г.м) зэрэг нь ажилтнуудыг улам бүр ядарч сульдах, сэтгэлийн зовиур, стресс, түгшүүрт автахад хүргэж байгааг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Заримдаа, энэ нь тэдний ажлын цаг болон бусад нөхцөл, болзлыг өөрчлөн шинэчлэх хууль эрх зүйн арга хэмжээ авснаас үүдэлтэй бол бусад үед цар тахлын халдвар нэмэгдсэнээс шалтгаалж байв. Эмнести Интернэшнл эмнэлгийн ажилтнуудын ажлын цагийг сунгах эсвэл үйлчилгээний нөхцөлийг өөрчлөх албан ёсны арга хэмжээ авсан орнуудын жишээг дурдлаа.⁶²

⁶⁰ ЭЗНСЭ-ийн Хороо, Коронавирусийн өвчлөл (КОВИД-19) цар тахлын болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх мэдэгдэл, E/C.12/2020/1, 2020 оны 4 сарын17, <http://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=4slQ6QSmlBEDzF EovLCuW1AVC1NkPsgUedPIF1vfPMKXidSV%2fGyVFSavr6nixzSlX6zld%2bu5KD26NraabijKaWMnkFhhMb4MahybE5l%2foU5sQSh 6PCbcepqz10iCYklyq>

⁶¹ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Англи, 2020 оны 4 сарын14 [утсаар]

⁶² Жишээлбэл, Финляндад Онцгой байдлын албаны тухай хуулийн дагуу засгийн газар “эрүүл мэндийн салбарт ажиллах үүргийг” танилцуулж, тогтоол гаргасан байна. Энэхүү тогтоолын дагуу “Эрүүл мэндийн салбарт ажиллах үүрэг хүлээсэн, ажиллах тушаал нь гарсан хүн эрүүл мэндийн салбарт шаардлагатай ажлуудыг хийх ёстой. Ажлын захиалгыг нэг удаад хамгийн ихдээ хоёр долоо хоног гаргаж, нэг удаа сунгаж болно» гэжээ. Гэвч 3-р сарын 19 –нөөс 5-р сарын 13 хүртэл хүчинтэй байх хугацаанд энэхүү тогтоолоор ажлын захиалга хийгдээгүй байна. Онцгой байдлын албаны тухай хуулийн өөр нэг тогтоолоор эмнэлгийн ажил олгогчдод ажлаас халах хугацааг сунгах, ээлжийн амралтыг хойшлуулах, эсвэл илүү цагаар ажиллах захиалга өгөхийг зөвшөөрөв. Үүнийг ажил олгогчид ажилтны ажлын нөхцөлийг өөрчлөхөд ихэвчлэн ашигласан. Үүнтэй адилаар, Турк улсад эрүүл мэндийн ажилтнуудын ажлаас гарах хүсэлтийг хязгаарласан тогтоол гарсан байна. Үүнд: “Энэ тогтоол гарснаас хойш гурван сарын хугацаанд хувийн болон нийтийн салбарт ажиллаж байгаа, аль ч эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байсан эсвэл томилогдсон эрүүл мэндийн ажилтнууд цар тахлын хүрээнд хоёр дахь мэдэгдэл гарах хүртэл хугацаанд ажлаасаа гарахыг хориглоно. Энэхүү шийдвэрийг цар тахлын эсрэг үр дүнтэй тэмцэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасалдуулахгүй байх зорилгоор гаргасан”. Хуулбар Эмнести Интернэшнлийн архивт байгаа болно. 1930 оны Хөдөлмөрийн тухай конвенцийн 2014 оны протоколын дагуу “Энэхүү протокол, конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээг үндэсний хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, ажил олгогч байгууллагатай болон холбогдох ажилчдын төлөөлөлтэй зөвшилцсөний дараа болон холбогдох байгууллагаас тогтооно”. Эмнести Интернэшнл янз бүрийн улс орнууд эрүүл мэндийн ажилтнуудын ажлын нөхцөлд албан ёсны өөрчлөлт оруулсан эсэхийг шинжлээгүй. Гэсэн хэдий ч үүнийг ажил олгогч болон холбогдох ажилчдын байгууллагатай зөвлөлдсөний дараа хийх нь нэн чухал юм.

Өвчтөний тоо нэмэгдэхийн хэрээр эрүүл мэндийн ажилтнуудын ажлын ачаалал ихээхэн нэмэгдсээр байв. Эрчимт эмчилгээний тасаг гэх мэт зарим хэсгүүдийн ажил илүү их төвөгтэй болсон.

Парагвай улсын эмнэлгийн ажилтан Эмнести Интернэшнлд хэлэхдээ “Ковид-19 болохоос өмнө бид завсарлага авч чаддаг байсан. Харин КОВИД гарснаас хойш түр завсарлах ч боломжгүй болсон”.⁶³ **Өмнөд Африкийн** эрүүл мэндийн ажилтан санаа зовниж буй олон асуудлуудынхаа талаар “Миний хувьд хамгийн том асуудал бол бид хэдий ядарсан ч гэсэн нэг өвчтөнөөс нөгөө рүү яаран шилжих явцдаа санамсаргүйгээр нүүр нүүрэндээ хүрснээр өөрсдийгөө вирусийн халдвар авахад хүргэж байгаа явдал гэв. Бид бас маш их хөлөрч, хөлсөндөө зунгааралдаж байна. Намайг КОВИД-19 дээр ажиллахыг болиулсан ба одоо нэмэлт эмчээр ажиллаж байна. Энэ нь би зөвхөн ажилласан үедээ л цалин авдаг гэсэн үг юм. Тиймээс би өмнөхөөсөө ч илүү их стресст орж байна”⁶⁴ хэмээн өгүүлсэн юм. **Египетийн** Эмч нарын Синдикат (Эмч нарын холбоо) байгууллагын төлөөлөгч Эмнести Интернэшнлд «Зарим эмч нар иж бүрэн ХХХ-тэйгээ завсарлагагүйгээр 14 цагийн турш ажиллахад хүрсэн., энэ нь хэт ядрах, ингэснээр анхаарлын төвлөрөл буурч, өөрсдийгөө хамгаалах, ХХХ-ээ зохих ёсоор хэрэглэх чадваруудад нөлөөлсөн”⁶⁵ гэж ажлын цагаа тайлбарлан хэлсэн.

Өмнөд Суданд, тухайн улсын хэмжээнд үйлчлэх ганцхан туршилтын лабораторитой ба өмнөд хилийн дагуу туршилтын ганц гар утасны лаборатори үйлчилдэг,⁶⁶ лабораторийн техникчид өдөрт 16 цаг хүртэл ажиллаж, 5000 дээжийг хүлээж авч шинжлэн буцаах зэргээр ажилладаг гэж хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлж байна.⁶⁷ Ажилтнуудын хувийн амьдралд ч бас дарамт үүсдэг байна. **Энэтхэгийн** нийгмийн эрүүл мэндийн ажилтан “Би хоёр настай хүүхэдтэй, түүнийг халдвар авахаас айж шөнөдөө гадаа тагтан дээрээ унтаж байна” гэж Эмнести Интернэшнлд хэлжээ.⁶⁸ Түүнээс гадна, ажлын ачаалал ихэссэнтэй холбоотойгоор ажилтнуудын гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага ч нэмэгдсэн, ялангуяа энэ үеэр сургууль болон хүүхэд харах төвүүд хаагдсан тул хүүхдүүдээ харж асрах зэрэг гэр орны ажлын ачаалал нь нэмэгдсэн ч тэд урьдынх шигээ бусдын дэмжлэгийг (цэвэрлэгээ, хоол хийх тусламж) авах боломжгүй болсон байна.

Ажлын ачаалал нэмэгдсэнээс үүдэн сэтгэлийн түгшүүр, стресс нэмэгдэх нь тэдний сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байна. КОВИД-19 цар тахал эхэлсний дараагаар **Португалийн** эрүүл мэндийн ажилтнуудын дунд явуулсан 2 судалгаа 2020 оны 4-р сард хэвлэгдсэн. Уг судалгаанд оролцсон нийт эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн 75% нь өөрсдийн сэтгэл түгшүүрийн түвшинг «өндөр», эсвэл «маш өндөр» гэж дүгнэсэн бол 14.6% нь сэтгэл хямралын түвшингээ дунд, эсвэл ердийн түвшинд байна гэж мэдэгджээ.⁶⁹ Нөгөө нэг Португалийн судалгаанд хамрагдсан сувилагч нар энэ хугацаанд сэтгэл түгшүүр 40%-иар нэмэгдсэн нь ажлын цаг нэмэгдсэнтэй холбоотой болохыг тогтоожээ.⁷⁰ Сувилагчдын 57% нь унтах хугацааг «муу», эсвэл «маш муу» гэж хариулсан бөгөөд сувилагчдын 48% нь амьдралынхаа чанарыг «муу», эсвэл «маш муу» гэж хариулсан байна. Ярилцлагад хамрагдсан сувилагч нарын 1.4% нь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж авахаар хайсан байна.⁷¹

Британийн Анагаах ухааны сэтгүүлд саяхан нийтлэгдсэн нэгэн баримт бичигт «Хятадын эрүүл мэндийн ажилтнуудын дунд сэтгэл хямрал (50.3%), сэтгэл түгшүүр (44.6%), нойргүйдэл (34.0%)» байна гэж тэмдэглэгджээ”.⁷² Италид цар тахлын үед тэргүүн болон хоёрдугаар шугамд

⁶³ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Парагвай, 2020 оны 4 сарын29 [утсаар]

⁶⁴ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Өмнөд Африк, 2020 оны 6 сарын 10 [утсаар]

⁶⁵ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Египет, 2020 оны 6 сарын10 [утсаар]

⁶⁶ Өмнөд Суданы Эрүүл Мэндийн Яам, КОВИД-19 долоо хоногийн нөхцөл байдлын тайлан, 2020 оны 6-р сарын 22-28, Эмнести Интернэшнлийн архивт бий

⁶⁷ Маура Аяк, Кара Анна нар “Өмнөд Суданд вирусийн дэгдэлт “ хяналтаас гарч” байна”, *Ассошиэйтед Пресс*, 2020 оны 6 сарын 22, <https://arnews.com/265a7d7cbb6bb6ec29f4bcb1c69e739d>. Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Өмнөд Судан, 2020 оны 6 сарын11

⁶⁸ Нийгмийн эрүүл мэндийн ажилтантай хийсэн ярилцлага, Энэтхэг, 2020 оны 4-5 сар

⁶⁹ Universidade Noca de Lisboa, 2-р асуулгын үр дүн: Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн эрсдэл вирусийн хүрэнээс ч давлаа, <https://barometro-covid-19.ensp.unl.pt/resultados-do-questionario-2-os-riscos-para-os-profissionais-de-saude-vao-muito-para-alem-do-virus/>

⁷⁰ Синтез, Синтезийн судалгаагаар: КОВИД-19 нь сувилагчийн сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлж байна, <http://cintesis.eu/en/cintesis-study-reveals-covid-19-is-affecting-nurses-mental-health/>

⁷¹ Синтез, Синтезийн судалгаагаар: КОВИД-19 нь сувилагчийн сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлж байна.

⁷² Ж Гоулд, «Ковид-19: эрүүл мэндийн ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг үр дүн», *Британийн Анагаах ухааны*

ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын дунд хийсэн судалгаагаар залуу эмэгтэйчүүд ба тэргүүн шугамд ажиллаж байгаа сувилагч асрагч нарын сэтгэцийн эрүүл мэндийн асуудал ихэнх хувийг эзэлж байна”.⁷³ Бусад пандемик болон эпидемикийн мэдээллүүд ч үүнийг нотолж байна.⁷⁴

Зарим улс орнууд цар тахлын эсрэг ажиллах ажилтнуудынхаа тоог нэмэгдүүлэх талаар идэвхтэй арга хэмжээ авсан байна. Үүнд, эрүүл мэндийн ажилтнуудыг илүүтэйгээр авч ажиллуулах, нийгмийн эрүүл мэндийн салбарт богино хугацаанд ажиллах сайн дурынхныг урих зэрэг арга хэмжээнүүд багтаж байна.⁷⁵ Гэвч эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажлын байранд шаардлагатай сэтгэлзүйн туслалцааг үзүүлэхийн тулд илүү өргөн хүрээтэй арга хэмжээ авах шаардлагатай. КОВИД-19 өвчний дэгдэлтийн үед сэтгэцийн эрүүл мэнд болон сэтгэл зүйг анхааралдаа аван тодорхой дүн шинжилгээ хийж эрүүл мэндийн ажилчидад зориулсан удирдамжийг ДЭМБ-аас хэвлэн гаргасан.

Энэ удирдамжид эрүүл мэндийн байгууллагуудын менежерүүдэд өгөх хэд хэдэн практик зөвлөмж багтсан болно. Үүнд бүх ажилтантай сайн харилцаа холбоотой байхыг эрхэмлэх, үнэн зөв мэдээллээр хангагдах нөхцөлийг бүрдүүлэх; ажилтнуудыг стресс ихтэй ажлаас стресс багатай ажил руу сэлгэх; туршлага багатай ажилтнуудыг илүү туршлагатай ажилтантай хамтран ажиллуулах; ажлын завсарлагатай болгож урам зоригийг сэргээх, хянах; стресст өртсөн, эсвэл гэр бүлийн гишүүдийнхээ дайралтад өртдөг ажилтнуудад ажлын хатан хуваарийг хэрэгжүүлэх; ажилтнууд сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг хаанаас, яаж авч болох талаар мэддэг байх, ийм үйлчилгээнд хамрагдах боломжийг хөнгөвчлөх зэрэг зөвлөмжүүд багтсан байна.⁷⁶

4.4 ЦАЛИН ХӨЛС БА НӨХӨН ОЛГОВОР

Эрүүл мэндийн ажилтнуудын ажлын ачаалал ихэсч, ажил мэргэжлийн бусад эрсдэл нэмэгдсэн ч цалин хөлсийг нь шударгаар олгохгүй байх, мэргэжлээс шалтгаалсан өвчин туссан, эсвэл нас барсан тохиолдолд нөхөн олговор олгохгүй байх зэрэг асуудлууд хэд хэдэн оронд гарсан байна. Энэ нь ялангуяа, тодорхой зарим ажилтнуудын хувьд, цалингийн хомсдол, хүнд хөдөлмөрийн нөхцөл зэрэг өмнө нь удаан хугацаанд үргэлжилж ирсэн өргөн хүрээний асуудлуудаас үүсдэг. Жишээлбэл, ДЭМБ-ын мэдээлж буйгаар эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлс дахь жендэрийн дундаж зөрүү эрүүл мэндийн ажилтнуудын хувьд 28% орчим байна.⁷⁷

Хямралын эхэн үед **Пакистаны** нэгээс доошгүй мужид КОВИД-19-тэй тэмцэх засгийн газрын тэргүүлсэн санг дэмжих зорилгоор эрүүл мэндийн ажилтнуудын цалинг (мөн бусад төрийн байгууллагын ажилчдын цалинг) 10% бууруулсан байна.⁷⁸

Индонезийн Сувилагчдын Холбооны Хууль эрх зүйн Туслалцааны газрын нарийн бичгийн дарга мэдэгдэхдээ: **Индонезид** төрийн өмчит болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн сувилагчид 2020 оны 5-р сарын 25-ны байдлаар цалингаа хасуулсан ба амралтын өдөр ажилласны урамшуулал аваагүй гэсэн 330 тохиолдол гарсан гэж мэдэгджээ. Тэдний 65% нь түр ажилтнууд байжээ.

Өмнөд Суданы засгийн газраас цалинждаг эмч нар 2-р сараас хойш цалингаа аваагүй,

сэтгүүл, 369, 2020, <https://www.bmj.com/content/369/bmj.m1815>

⁷³ Р Росси нар, « Итали дахь Коронавирусийн КОВИД-19 цар тахлын үед тэргүүн болон хоёрдогч тэргүүн шугамд ажиллаж байсан эрүүл мэндийн ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийн үр дүн. COVID-19) тахал”, 3 (5) JAMA Network Open, 2020 <https://jamanetwork.com/journals/jamanetworkopen/fullarticle/2766378>

⁷⁴ С Дутта, “КОВИД-19-ын тэргүүн шугамд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэнд, уян хатан байдлыг дэмжих нь”, *Дэлхийн Банкны блог*, 2020 оны 5 сарын 28, <https://blogs.worldbank.org/health/supporting-mental-health-and-resilience-frontline-covid-19-coronavirus-health-care-workers>

⁷⁵ Грек, Их Британийн жишээнүүд багтана.

⁷⁶ ДЭМБ, КОВИД-19-ийн дэгдэлтийн үеийн сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэцэд нөлөөлөх байдлын талаар, 2020 оны 3 сарын 18, https://www.who.int/docs/default-source/coronaviruse/mental-health-considerations.pdf?sfvrsn=6d3578af_2

⁷⁷ М Бониол нар, “Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний жендэрийн тэгш байдал: 104 орны шинжилгээ”, ДЭМБ-ын Эрүүл мэндийн ажилчдын ажлын баримт бичиг, 2019 оны 3 сарын 1, р 3 <https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/311314/WHO-HIS-HWF-Gender-WP1-2019.1-eng.pdf?sequence=1&isAllowed=y>

⁷⁸ М Бхатти, «Эмч нарын цалингийн 10 хувийг КОВИД-19 санд суутгаж байгааг эмч нар буруу гэж үзэж байна», *The News*, 2020 оны 4 сарын 4, <https://www.thenews.com.pk/print/639038-doctors-feel-wronged-as-govt-deducts-10pc-of-their-salaries-for-covid-19-fund>

нийгмийн хамгааллын мөнгө болон эрүүл мэндийн зардлын нөхөн төлбөр ч олгогдоогүй байна. Эмч нар нэг өдрийн ажил хаялт зарласны дараа засгийн газар тэдэнд цалингийн үлдэгдэл хэсгийг нөхөх зорилгоор нэг удаадаа бөөнд нь 40 ам доллартай тэнцэх хэмжээний мөнгийг орон нутгийн мөнгөн тэмдэгтээр олгохоор санал болгов. “Эмч нар энэ бол бидний шаардсан зүйл биш гэж татгалзжээ. Засгийн газар өнгөрсөн сард 10,000 SSP (Өмнөд Суданы паунд) санал болгосон байна. Дараа нь, энэ сарын эхээр [зургадугаар сарын] хэрэв та нар засгийн газрын тавьсан саналыг энэ сардаа багтаан хүлээн авахгүй бол та нартай гэрээгээ цуцлах болно” хэмээн зарим хүмүүсийг заналхийлснийг нэгэн эмч Эмнести Интернэшнлд хэлсэн юм.⁷⁹

Гватемала улсын засгийн газар КОВИД-19 цар тахлыг эмчлэх тусдаа эмнэлэг байгуулах шийдвэр гаргаж, уг эмнэлэгт ажиллах эрүүл мэндийн нэмэлт ажилтнуудыг түр гэрээгээр авч ажиллуулжээ. 5-р сарын эхээр тус эмнэлэгт ажилладаг нэг ажилтантай Эмнести Интернэшнл ярилцав.⁸⁰ Тэд тухайн үед уг эмнэлэгт 40 хоног ажиллаад байсан бөгөөд энэ хугацаанд цалин хөлс огт олгогдоогүй байна. Гватемала улсын Хүний Эрхийн Омбудсманы газрын төлөөлөгчид: тус эмнэлгийн эмч нарын тал хувь нь албан ёсны гэрээ байгуулаагүй бөгөөд тэдний хэн нь ч цалин хөлс олгогдоогүйг батлав.⁸¹



ГВАТЕМАЛАД ЭМНЭЛГИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛЧДЫГ АЖЛААС ХАЛЖ, ЦАЛИН ХӨЛСИЙГ НЬ ОЛГООГҮЙ БАЙНА⁸²

3-р сарын 21-ний өдөр Гватемалагийн Засгийн газар КОВИД-19 халдвараар өвчилсөн өвчтөнүүдийг хүлээн авч эмчлэх зорилгоор Гватемала хотын “Парке де ла Индустриа” (Аж үйлдвэрийн парк)-д 319 ортой түр эмнэлэг нээв. Тавдугаар сарын эхээр эмнэлгийн ажилтнууд эмнэлэгт ажиллах гэрээ, цалин, аюулгүй байдал хангалтгүй байгааг олон нийтийн өмнө буруушаан эсэргүүцэв. Улсын Аудитын Газрын мэдээлэлд үндэслэн хийсэн хэвлэлийн мэдээнээс үзвэл эмнэлгийн чиг үүргийг гүйцэтгэх чадавхи болон чадвартай хүний нөөц дутагдалтайгаас болж энэ эмнэлэг Конгрессоор баталж өгсөн зориулалтын төсвийн 2% хүрэхгүй хувийг зарцуулсан байна.

6-р сарын 5-ны өдөр тус эмнэлэгт ажиллаж байсан эмнэлгийн цэвэрлэгээний 46 ажилтныг ажлаас халжээ. Ажлаас халах цорын ганц шалтгаан нь Эрүүл мэндийн яамнаас тавьж байгаа шаардлага буюу захиргааны шаардлагын дагуу тэд ажлаа хадгалахын тулд ахлах сургууль эсвэл их сургуулийн зэрэгтэй байх шаардлагатай байв. Эдгээр ажилчдын ихэнх нь зөвхөн суурь боловсрол эзэмшсэн байжээ. Түүнээс гадна, 3-р сарын 24-ний өдрөөс эхлэн ажилласан тэдний цалинг (эмнэлэгт ажиллаж байсан бусад эрүүл мэндийн ажилтнуудын нэгэн адил) олгоогүй, мөн ажилгүйдлийн нөхөн олговрыг өгөөгүй байна. 6-р сарын 5-ны өдөр халагдсан 46 ажилтныг хамгаалж, цалинг нь яаралтай төлөх, ажлаас халагдсан нөхцөл байдлын талаар хараат бус шалгалт хийхийг Эмнести Интернэшнлээс Нийтийн эрүүл мэнд, Нийгмийн туслалцааны сайдад хандан уриалав.

Гэрээний дагуу цалингаа авч байгаа эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ч бас тэдний цалин хөлс нь бага ба одоо хийж буй нэмэлт ажлууд болон цар тахал үед ажлын байран дээр учирч болох эрсдлийг тооцохгүй байгаа талаар санаа зовниж буйгаа илэрхийлсэн байна. **Энэтхэгт** нийгмийн эрүүл мэндийн нэгэн ажилтан Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлагын үеэр, “Бид сардаа тогтмол INR 3000 рупи (ойролцоогоор 40 доллар) олдог, хүргэлт хийхэд туслах, вакцинжуулалт хийх гэх мэт бусад ажил хийж нэмэлт орлого олдог. Гэвч бид одоо зөвхөн КОВИД-19-тэй холбоотой ажил үүрэг гүйцэтгэж байгаа тул бидний орлогод бага

⁷⁹ Өмнөд Судан, Эрүүл мэндийн ажилтнуудтай хийсэн ярилцлага, 2020 оны 6-р сарын 11, Мөн үзнэ үү: П.Акол, «Нэг эрүүл мэндийн ажилтан КОВИД-19-ээс болж нас баржээ, Өмнөд Суданд тэргүүн шугамын анхны эмчийн нас баралт”, *Eye Radio*, 2020 оны 5 сарын 29, <https://eyeradio.org/one-health-care-worker-dies-of-covid-19-first-front-line-fatality-in-sudan>; М.Айак ба С.Анна “Өмнөд Суданд Вирусийн дэгдэлт ‘хяналтаас гарч байна’”, *Associated Press*, 2020 оны 6 сарын 22, <https://apnews.com/265a7d7cbb6bb6ec29f4bcb1c69e739d>

⁸⁰ Эрүүл мэндийн ажилтантай хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 12-14-ний өдрүүдэд [утсаар]

⁸¹ Гватемала дахь Хүний эрхийн Омбудсманы Тамгын газрын байцаагчтай хийсэн ярилцлага (Procuraduría para los Derechos Humanos –PDH), Гватемала, 2020 оны 5 сарын 13

⁸² Эмнести Интернэшнл, Гватемала: КОВИД-19 ба эмнэлгийн ажилчид ажлаас халагдсан; цалин хөлс олгогдоогүй, (Index: AMR 34/2465/2020)

ч атугай нөлөөлдөг байсан дээрх нэмэлт ажлуудыг хийх боломжгүй болсон.”⁸³ “Үүгээр бид юу хийх юм бэ? INR 3000 Рупи гэдэг бол инээдтэй буюу доромжилж байгаа юм шиг бага хэмжээ, бид гэр бүлээ бүхэлд нь аюулд оруулж байна. Нөхөр маань намайг өдөр бүр буруутгадаг” гэж түүний хамтрагч нэмж хэлэв.⁸⁴ Цалингийн энэ хэмжээ нь Энэтхэгийн олон муж улс дахь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ч доогуур байна.

Египетэд Эрүүл мэндийн яам эмч нартаа хэрэв тэд КОВИД 19-ийн тохиолдлуудтай 14 хоногийн турш ажиллаж, дараа нь дахин 14 хоног хорио цээрийн хязгаарлалтад байвал EGP 20,000 (сард ойролцоогоор 1200 доллар) цалин өгнө гэж амлажээ.

Гэсэн хэдий ч ихэнх эмч нар амласан дүнгийн зөвхөн дөрөвний нэг орчим хувийг (сард 300 орчим доллар) авчээ. Цар тахлын дэгдэлт эхлэхээс өмнө олон эмч хувийн амбулатори болон эмнэлэгт ажиллаж орлогоо нэмэгдүүлдэг байжээ.⁸⁵ Эмнести Интернэшнлийн олж үзсэн нэгэн албан бичигт Эрүүл Мэндийн Яамнаас тэднийг хувийн амбулатори, болон эмнэлэгт ажиллахаа больж, тэдний орлого, амьжиргаанд ноцтой нөлөөлж болох «КОВИД-19-тэй тэмцэх тулаан»-д нэгдэхийг шаардсан байв.

Олон орны засгийн газрууд КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн ажилтнуудын орлогыг нэмэх зорилгоор хөнгөлөлт үзүүлэх, эсвэл тусгайлсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг ажлууд хийжээ. Эмнести Интернэшнл нь ийнхүү арга хэмжээ авсан дэлхийн дор хаяж 29 улс орны тайлан байгааг тэмдэглэв. Энэ нь нааштай алхам болсон хэдий ч, зарим улс орны ажилтнууд эдгээр хөнгөлөлтийг бодитоор эдэлж чадаагүй, эсвэл КОВИД-19 цар тахлын үед эн тэнцүү, зарим тохиолдолд бүр илүү эрсдэлт нөхцөлд ажилладаг эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай зарим ажилтнуудыг хамруулаагүй зэрэгт ажилтнууд санаа зовж байна.

Жишээлбэл, **Гана улсын** засгийн газар «тэргүүн шугамд ажиллагсад»⁸⁶ цалин нэмэгдүүлэх, нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих, гурван сарын хугацаанд татвар төлөхөөс чөлөөлөх гэх мэт хөнгөлөлтүүд үзүүлжээ. Гэсэн хэдий ч, КОВИД-19-ийн улмаас нас барсан хүмүүсийн цогцсыг халдваргүйжүүлэх, тусгаарлах, оршуулах зэрэг ажил КОВИД-19-ийн эсрэг авч байгаа хариу арга хэмжээнд чухал үүрэг гүйцэтгэдэг ажилтнууд хамрагдаагүй байна.⁸⁷ Энэтхэгийн засгийн газар «Прадхан Мантри Гариб Кальян» багцыг буюу КОВИД-19-тэй тэмцэж буй эрүүл мэндийн ажилтнуудад, үүнд эмнэлэгт ажиллаж буй халдваргүйжүүлэх ажилтнуудыг оролцуулан 2020 оны 3-р сарын 30-ны өдрөөс эхлэн INR 50 lakh (ойролцоогоор 66,150 ам.доллар) өртөг бүхий КОВИД-19-ийн нас баралтын даатгалын багцыг нэвтрүүлжээ.⁸⁸ Гэхдээ энэ багц нь эмнэлгүүдийн гэрээт ажилчдад хамаарах эсэхийг тодруулж өгөөгүй байна. Түүнчлэн хот, суурин газраас хатуу хог хаягдал цуглуулж хаяж байгаа хүмүүс, тэр дундаа хорио цээрийн бүсэд ажиллаж байгаа хүмүүс ямар нэг хөнгөлөлтийн гадна орхигджээ.⁸⁹ **Их Британид** КОВИД-19-ийн улмаас амиа алдсан эрүүл мэндийн ажилтнуудын ар гэрийнхнийг Их Британид тодорхойгүй хугацаагаар үнэ төлбөргүй үлдэхийг зөвшөөрсөн (оршин суухтай дүйцэхүйцээр) хөнгөлөлтийн багцаас хаалгач, цэвэрлэгч, нийгмийн халамжийн ажилтнуудыг эхлээд орхигдуулсан байна. Дараа нь тэдгээр

⁸³ Нийгмийн эрүүл мэндийн ажилтантай хийсэн ярилцлага, Энэтхэг, 2020 оны 4-5 сар

⁸⁴ Нийгмийн эрүүл мэндийн ажилтантай хийсэн ярилцлага, Энэтхэг, 2020 оны 4-5 сар. (Нийгмийн эрүүл мэндийн Магадлан итгэмжлэгдсэн идэвхтэн) Эдгээр ажилчид нь нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд ба Энэтхэг дэх “олон нийт ба нийгмийн эрүүл мэндийн системийн хоорондын гүүр болж ажиллахаар бэлтгэгдсэн” эмэгтэйчүүд юм. Ерөнхийдөө тэд эрүүл мэндийн дараах олон чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнд: <https://nhm.gov.in/index1.php?lang=1&level=1&sublinkid=150&lid=226>. Нийгмийн эрүүл мэндийн ажилтанг сайн дурын ажилтан гэж үздэг бөгөөд тогтмол цалин авдаггүй. Харин оронд нь гүйцэтгэж буй ажилд нь тэдний ажиллаж буй муж улсаас хамааран 2000 - 4000 рупи хүртэлх хамгийн бага цалин сар бүр өгөх ба дээр нь урамшуулал өгдөг. Цар тахлын үед ажлыг нь нэмэгдүүлж 1000 рупигээр нэмж урамшуулах болжээ. Энэ нь олон муж улсын цалингийн хамгийн бага хэмжээнээс доогуур байна, Дэлгэрэнгүйг үзнэ үү: https://www.indiabudget.gov.in/budget2019-20/economicsurvey/doc/vol1chapter/echap11_Vol1.pdf

⁸⁵ Эрүүл мэндийн ажилтантай хийсэн ярилцлага, Египет, 2020 оны 6 сарын 9 [утсаар]

⁸⁶ Гана улсын засгийн газар КОВИД-19 халдвар авсан өвчтөнүүдтэй шууд харьцаж ажилладаг эмч, сувилагч, бусад эрүүл мэндийн ажилтнуудыг «тэргүүн шугамд ажиллагсад» гэж тодорхойлсон

⁸⁷ К Дарко, «Байгаль орчны эрүүл мэндийн ажилтнууд Ковид-19 урамшууллын багцаас хасагдсандаа сэтгэл хангалуун бус байна», *MyJoy Online*, 2020 оны 5 сарын 11, <https://www.myjoyonline.com/news/national/environmental-health-workers-unhappy-with-exclusion-from-covid-19-stimulus-package/>

⁸⁸ Pradhan Mantri Garib Kalyan-ы багц: КОВИД-19-тэй тэмцэж буй эрүүл мэндийн ажилчдын даатгал, Түгээмэл асуулт хариулт, <https://www.mohfw.gov.in/pdf/FAQPradhanMantriGaribKalyanPackageInsuranceSchemeForHealthWorkersFightingCOVID19.pdf>

⁸⁹ Энэтхэгийн Эмнести Интернэшнл, Тэргүүн шугамд орхигдсон нь: Энэтхэгийн халдваргүйтгэлийн ажилчид КОВИД-19-ийн үеэр засгийн газраас яаралтай тусламж эрэлхийлж байна, 2020 оны 4 сарын 24, <https://amnesty.org.in/abandoned-at-the-frontline-indias-sanitation-workers-seek-immediate-help-from-the-government-amidst-covid-19/>

ажил мэргэжлийн хүмүүсийг хамруулахаар нэмэлт өөрчлөлт оруулжээ.⁹⁰

КОВИД-19: МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧЛӨЛ

Энэ асуудал нь хэрэв эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ажлын байран дээрээ КОВИД-19-ийн халдвар авсны улмаас өвчилсөн, нас барсан тохиолдолд нөхөн олговор авах боломжийн тухай асуудалтай холбоотой.

1964 оны ОУХБ-ын Хөдөлмөр Эрхлэлтийн Ослын Тэтгэмжийн Зөвлөмжид мэргэжлээс шалтгаалах өвчнийг “хөдөлмөрлөх явцад үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл, эсвэл аюултай нөхцөл байдлын нөлөөллөөс шалтгаалан ажилтны бие махбодод үүссэн өвчин” гэж ойлгоно гэсэн байдаг. Түүнчлэн энэхүү зөвлөмжид “ажилтан (а) ядаж тодорхой хугацаанд энэхүү нөхцөл байдалд ажиллаж байсан бол (б) хамгийн сүүлийн хөдөлмөр эрхлэлтийг цуцалснаас хойш тодорхой хугацаанд өвчний шинж тэмдэг илэрсэн бол тухайн өвчин мэргэжлээс гаралтай гэсэн таамаглал байх ёстой” гэжээ. Хэрэв КОВИД-19 цар тахал нь мэргэжлээс шалтгаалсан өвчин гэж тооцогдвол хөдөлмөрлөх явцдаа КОВИД-19 халдвар авч өвчилсөн эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд зохих эмнэлгийн тусламж, мөнгөн тэтгэмж, хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд болон нас барсан тохиолдолд олгох нөхөн олговор, оршуулгын тэтгэмж зэрэг олон төрлийн хөнгөлөлт авах боломжтой байх ёстой.⁹¹

Зарим улс орнууд КОВИД-19-ийг мэргэжлээс шалтгаалах өвчин гэдгийг илт хүлээн зөвшөөрсөн бол,⁹² бусад улс орнууд мэргэжлээс шалтгаалах өвчин гэж авч үзээгүй байгаа бөгөөд энэ нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг төлөөлдөг олон байгууллагын хүсч буй гол хүсэлт юм.⁹³ ОУХБ-аас гаргасан мэдээллээс харахад дор хаяж 13 улс орон КОВИД-19-ийг зарим мэргэжилтнүүдийн хувьд мэргэжлээс шалтгаалах өвчний ангилалд оруулсан бол, бусад найман улс оронд хүн ажлын байран дээрээ байхдаа халдвар авсан нөхцөлд ингэж үзнэ гэж мэдэгдсэн байна. (ОУХБ-ын хяналт нь эцсийн дүгнэлт биш юм).⁹⁴ ДЭМБ-ын удирдамжид заасны дагуу “эмнэлгийн байгууллагын ажилтнууд болон менежерүүд зэрэг эрүүл мэндийн ажилтны удирдлагууд [...]хэрэв ажлын байрандаа КОВИД-19-ийн халдвар авсан бол нөхөн төлбөр авах эрхийг хүндэтгэх, нөхөн сэргээх болон эмчилгээ үйлчилгээнд хамрагдах эрхийг хүндэтгэх ёстой. Үүнийг мэргэжлийн нөлөөллөөс үүдэлтэйгээр үүссэн мэргэжлээс шалтгаалах өвчин гэж авч үзэх ёстой” гэж мэдэгдсэн.⁹⁵ ОУХБ энэ талаар цааш мэдэгдэхдээ “Хөдөлмөрлөх үйл ажиллагааныхаа үр дүнд халдвар авсан бол КОВИД-19-ийн халдварыг хөдөлмөрийн осол гэж тооцно” гэж мэдэгдэв.⁹⁶

КОВИД-19 нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын мэргэжлээс шалтгаалах өвчин болохтой холбоотой асуудал нь КОВИД-19-ийг илрүүлэх шинжилгээтэй нягт холбоотой. Шинжилгээ нь КОВИД-19-ийг мэргэжлийн өвчин гэж авч үзсэн тохиолдолд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эдлэх эрх, авах хөнгөлөлтийг эдлүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Жишээлбэл, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг КОВИД-19-ийн шинжилгээнд хамруулаагүй нөхцөлд эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, эмчилгээ

⁹⁰ А Вудкок, «Коронавирус: Амиа алдсан Үндэсний аюулгүй байдлын албаны цагаач гаралтай асрагч, хаалгач, зөвөөрлөгч нарын ар гэрийнхэн дээрх халамжаас орхигдов», *The Independent*, 2020 оны 5 сарын 19 <https://www.independent.co.uk/news/uk/politics/coronavirus-nhs-cleaners-leave-to-remain-scheme-home-office-a9523111.html#gsc.tab=0>; Коронавирус (КОВИД-19): Үндэсний аюулгүй байдлын албаны болон эрүүл мэнд, нийгмийн халамжийн нас барсан ажилтнуудын гэр бүлийн гишүүдэд зориулсан тэтгэмжийн сан, 2020 оны 5 сарын 20, <https://www.gov.uk/guidance/coronavirus-covid-19-bereavement-scheme-for-family-members-of-nhs-and-health-and-social-care-workers>

⁹¹ ОУХБ-ын стандартууд ба КОВИД-19 (коронавирус), 2020 оны 5 сарын 29, https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_norm/---normes/documents/genericdocument/wcms_739937.pdf

⁹² Улс орнуудын хийсэн ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл линкээр орж үзнэ үү: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/---emp_ent/documents/publication/wcms_741360.pdf

⁹³ Жишээ үзнэ үү, “КОВИД-19-ийг ажил мэргэжлээс шалтгаалах өвчин гэж хүлээн зөвшөөрөх тухай Дэлхийн Холбооны Зөвлөлийн гаргасан мэдэгдэл”, 2020 оны 4 сарын 28, https://www.ituc-csi.org/IMG/pdf/cgu_statement_ivmd2020_en.pdf

⁹⁴ Энэ талаарх улс орнуудын дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл линкээр орж үзнэ үү: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/---emp_ent/documents/publication/wcms_741360.pdf

⁹⁵ ДЭМБ, Коронавирусийн өвчний дэгдэлт (КОВИД-19): эрүүл мэндийн ажилтнуудын эрх, үүрэг, хариуцлага, хөдөлмөрийн эрүүл мэнд болон аюулгүй байдал, Завсрын Удирдамж, 2020 оны 3 сарын 18, https://www.who.int/docs/default-source/coronaviruse/who-rights-roles-respon-hw-covid-19.pdf?sfvrsn=bcabd401_0

⁹⁶ ОУХБ-ын стандартууд ба КОВИД-19 (коронавирус), 2020 оны 5 сарын 29, https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_norm/---normes/documents/genericdocument/wcms_739937.pdf

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

Эмнести Интернэшнл

хийлгэхийг шаардах эрхгүй болох ба КОВИД-19 нь мэргэжлээс шалтгаалсан өвчин гэж хүлээн зөвшөөрч, тохиолдолд ч тэд нөхөн төлбөр болон бусад холбогдох тэтгэмж авах эрхгүй болно.

Одоогийн байдлаар эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг КОВИД-19-ийн шинжилгээнд хамруулах эсэх нь улс орнуудын хувь хүн бүрийг шинжилгээнд хамруулах стратегиас хамаарна. Зарим байгууллагууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хоёуланг нь шинжилгээ зайлшгүй хийлгэх шаардлагатай бүлэгт хамруулахыг хүссэн. Учир нь тэд КОВИД-19-ийн халдвар авах өндөр эрсдэлтэй ба ажил үүргээ гүйцэтгэж байх явцдаа бусдад халдвар дамжуулагч байх өндөр магадлалтай. Иймд улс орнууд КОВИД-19-ийг мэргэжлээс шалтгаалах өвчин гэж хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай гол ажилтнуудыг өөрсдийн харьяаллын хүрээнд КОВИД-19-ийн шинжилгээ хийлгэх эн тэргүүний бүлэгт хамруулахыг хууль тогтоомжоороо баталгаажуулах ёстой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ТАЙВАН ЗАМААР ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХ

КОВИД-19-тэй холбоотой дээр дурдагдсан заналхийлэл, дарамт шахалтын улмаас хэд хэдэн орны эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд нөхцөл байдлынхаа талаар олон нийтэд хэлж, ялангуяа хувийн хамгаалах хэрэгслээр (ХХХ) хангах, хөдөлмөрийн нөхцөлөө илүү сайжруулахыг шаардан жагссан байна. Дэлхийн 31 орны эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ажлын нөхцөлөө сайжруулахыг шаардан олон нийтийн жагсаал цуглаан хийж, ажил хаялт зарласан буюу ажил хаялт зарлахаа мэдэгдсэн талаар Эмнести Интернэшнл байгууллагад мэдээлсэн ба бусад зарим орнуудын хувьд ажил олгогчиддоо дээрх асуудлаар санаа зовниж байгаагаар илэрхийлж байсан гэжээ. Зарим улс оронд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг санаа зовниж буй асуудлаа ил болгоход саад болох үүднээс засгийн газрын зүгээс тодорхой хязгаарлалт тогтоож, зааварчилгаа гаргасныг Эмнести Интернэшнл олж тогтоожээ. Мөн зарим орнуудад албан ёсны хязгаарлалт тавиагүй ч дор дурдсанчлан, эрх баригчдыг шүүмжилснийхээ төлөө хэлмэгдүүлэлт, эсэргүүцэлтэй тулгарах эрсдэл бүхий иргэний нийгмийн хаалттай орон зайд үйл ажиллагаа явуулж байсан тул тэдний олонхи нь сэтгэл түгшээж буй олон асуудлаа нийтэд ил тод мэдээлж хэлмэгдүүлэлтэд өртөхөөс эмээж байсан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 19-р зүйлд заасны дагуу хүн бүр, түүний дотор эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй ба энэ эрх нь бүх төрлийн мэдээлэл, шинэ санааг хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг хамаарна.”⁹⁷ Энэхүү эрх нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн хэв журам болон бусдын эрхийг хамгаалах үүднээс тодорхой хязгаарлалт тавигдаж болох боловч эдгээр хязгаарлалтыг хуульд заасны дагуу зайлшгүй шаардлагатай тохиолдолд тодорхой хэмжээгээр хязгаарлах ба энэ нь холбогдох хууль ёсны зорилгод чиглэсэн бөгөөд ялгаварлан гадуурхахгүй байхад чиглэх ёстой.⁹⁸ Олон нөхцөл байдалд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд нь хүний эрүүл байх эрх болон мэдээлэл авах эрхийг дэмжиж хамгаалдаг тул хүний эрхийг хамгаалагчид байдаг. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын тунхаглалд хүний эрхийн төлөө ажиллаж байгаа бүх хүний хүртэх ёстой үндсэн хамгаалалтыг тусгасан болно.⁹⁹ Эдгээр хамгаалалт нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад ч хамаатай. Түүнчлэн, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн дагуу улс орнууд шүгэл үлээгчдийг ч хамгаалах үүрэгтэй.

⁹⁷ ИУТЭОУП-ын 19-р зүйл

⁹⁸ Иргэний болон Улс төрийн эрхийн Олон улсын Пактын заалтуудыг хязгаарлах, хасах тухай Сиракусагийн зарчим, НҮБ-ын баримт бичиг. E/CN.4/1984/4 (1984); ЭЗНСЭОП-ын Ерөнхий зөвлөмж №14-ийн 29-р зүйлд зааснаар аливаа хязгаарлалт нь "... пропорциональ байх ёстой, өөрөөр хэлбэл, хамгийн бага түвшинд хязгаарлалтыг батлах ёстой ... "болон" ... тодорхой хугацаатай байх бөгөөд тэдгээрийг хянах шаардлагатай." Мөн Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №34-ийг үзнэ үү, CCRP/C/GC/34, 2011 оны 9-р сарын 12.

⁹⁹ Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Хүний эрх, үндсэн эрх чөлөөг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах хувь хүн, бүлэг, нийгмийн байгууллагуудын эрх, үүрэг хариуцлагын тухай тунхаглал, 1999 оны 3-р сарын 8-ны A/RES/53/144, <https://www.ohchr.org/Documents/Issues/Defenders/Declaration/declaration.pdf>

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд заасны дагуу Улс орнууд хийсэн үйлдэлдээ буруутгагдаж, шийтгэл хүлээж болзошгүй байгаа шүгэл үлээгчийг хамгаалах үүрэгтэй ба шүгэл үлээгчид холбогдох мэдээллүүдийг найдвартай, хэлмэгдүүлэлтээс айхгүйгээр нээлттэй болгох механизмыг бүрдүүлэх үүрэгтэй.¹⁰⁰ Түүнээс гадна, эдгээр эрх нь хүмүүст мэдээллийг хүртээмжтэй болгоход чухал ач холбогдолтой бөгөөд эрүүл мэндийн ажилтнууд КОВИД-19 цар тахлын тархалт, цар хүрээ, засгийн газрын хариу арга хэмжээний талаарх мэдээллийн чухал эх сурвалж болж өгдөг.

Хэдий тийм ч засгийн газар, ажил олгогчид ажилтнуудыг дуугүй болгохыг оролдох, ярихыг зүрхэлсэн хүмүүсийг хэлмэгдүүлж байсан талаар олон мэдээлэл гарсан. Зарим улс оронд эсэргүүцлийн жагсаал хийхийг хориглох, эсвэл хүч хэрэглэх болон бусад хэлбэрээр дарамт учруулсан бол зарим засгийн газрын зүгээс ажилтнуудыг сэтгэл зовоож буй асуудлаа нийтэд мэдээлээгүй байх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Бусад орнуудын хувьд ажилтнууд эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө санаа зовж буй асуудлуудыг гаргаж ирснээрээ ажил олгогчдын дарамтанд орсон байна.

Зарим засгийн газрууд эрүүл мэндийн ажилтнуудад “засгийн газрын бодлого”-ын талаарх мэдээллийг олон нийтэд ярихгүй байх талаар анхааруулга гаргасан бөгөөд үүнд хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) -ийн хомсдол болон тахлын эсрэг хариу арга хэмжээг хэрхэн авч байгаа талаарх мэдээлэл зэргийг багтаасан байна. **Гондурас**т эрүүл мэндийн ажилтнууд, ялангуяа богино болон түр гэрээ байгуулсан ажилтнууд хэд хэдэн эмнэлэгт хаалтын гэрээ (олон нийтэд нээлттэй бус гэрээ) байгуулахыг шаардаж, ажил дээрээ юу болж байгааг, түүний дотор эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар олон нийтэд ярихыг хориглосон байна. Гондурасын эрүүл мэндийн нэг ажилтан Эмнести Интернэшнл байгууллагатай хийсэн ярилцлагын үеэр “цар тахлын үед зөвхөн нэг бус өөр олон эмнэлэг нууцлалын гэрээ байгуулсан талаар мэдэгджээ. Хэрэв тэднийг гадагш мэдээлэл өгвөл ажлаас нь хална гэж сүрдүүлсэн байна”.¹⁰¹ Гондурасын Анагаах ухааны коллежийн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч Эмнести Интернэшнл байгууллагын төлөөлөлтэй ярилцахдаа: зарим эрүүл мэндийн ажилтнууд ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын нөхцөл байдлын талаар ярьж байгаад ажлаас халагдсан гэж мэдэгджээ.¹⁰² **Польшид** Эрүүл мэндийн дэд сайд тархвар зүй судлаачид, эмнэлгүүдэд КОВИД-19 цар тахлын талаар олон нийтэд ярих ёсгүй гэж мэдэгджээ.¹⁰³ **Малайзад** Эрүүл мэндийн яамнаас төрийн албан хаагчдад (төрд ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг багтаан) зориулан, засгийн газрын бодлогыг шүүмжлэх, ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжлэхэд хүлээлгэх сахилгын арга хэмжээний талаар санамж танилцуулсан байна.



←👁
Poster
© Amnesty
International

Орчуулга: Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр олон нийтийн мэдэгдэл хийх, засгийн газрын бодлогод тайлбар өгөх дуртай юу? Тэгвэл та болгоомжтой байгаарай. Та 19(1) ба 19(2), PU(A) 395/1993 дүрмийн дагуу сахилгын шийтгэл авч болно. [Төрийн албан хаагчдын дүрэм 1993 (Үйл ажиллагаа ба сахилга бат)]

UIN.MN
УИХНЫ САНАА

¹⁰⁰ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг түгээн дэлгэрүүлэх, хамгаалах тухай Тусгай илтгэгчийн тайлан, А/70/361, 2015 оны 9-р сарын 8, https://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/70/361. Тусгай илтгэгчийн хэлснээр, шүгэл үлээгч гэдэг нь “тухайн үйл явдлыг олж илрүүлэхдээ энэ нь үндэсний болон олон улсын хууль тогтоомжийг зөрчсөн, эрх мэдлээ урвуулан ашигласан, хог хаягдал үүсгэсэн, залилан мэхлэсэн, эсвэл хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон нийгмийн аюулгүй байдалд хор хохирол учруулсан гэх мэт нийтийн эрх ашигт заналхийлсэн буюу хохирол учруулсан үйлдэл гэж үзэн энэхүү үйл явдлын талаарх мэдээллийг үнэн зөвөөр илчилж, олон нийтэд ил гаргасан хүн юм.”

¹⁰¹ Эмнести Интернэшнл нь эмнэлгээс 2020 оны 4-р сарын 3-ны өдөр бүх ажилчдад ирүүлсэн захидлын хуулбарыг үзэхэд захирлын ажлын өрөөнд ирж нууцлалын гэрээнд гарын үсэг зурахыг хүссэн захидал байв. XXX-ийг бодитоор хараагүй тухай дурдсан байна. Үүнийг Эмнести Интернэшнл Гондурасын анагаах ухааны коллежийн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчтэй хийсэн ярилцлагын үеэр мөн нотолсон байна.

¹⁰² Анагаах ухааны коллежийн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчтэй хийсэн ярилцлага, 2020 оны 4-р сарын 20

¹⁰³ K Новоселска, “Эмч нарын асуудлын талаар ярихыг яамнаас хориглодог”, Prawo.pl, 2020 оны 3-р сарын 27, <https://www.prawo.pl/zdrowie/zakaz-publicznego-wypowiedania-sie-lekarzy-na-temat-epidemi,499036.html> - Эрүүл мэндийн дэд сайдын хэлснээр ийм саналыг Эрүүл мэндийн яам эсвэл Ерөнхий ариун цэврийн байцаагчтай зөвшилцсний үндсэн дээр зөвхөн үндэсний зөвлөх хэлж болно.

Бусад оронд тахал өвчний талаар санаа зовниж байгаагаа нийтэд мэдэгдсэн, ажил хаялт зарласан эсэргүүцэн тэмцсэн эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ноцтой үр дагавартай тулгарсан. Үүний хамгийн тод илрэл нь **Хятадын** шүгэл үлээгч эмч Ли Вэн Лян вирусийн халдвар авсны дараа нас барсан явдал юм.

Ли Вэн Лян нь Ухань хотод ажиллаж байсан нүдний эмч юм. Тэрбээр 2019 оны 12-р дугаар сарын сүүлчээр БНСУ-ын өмнөд нутагт эхэлсэн амьсгалын замын цочмог хам шинжийн (SARS) өвчний шинж тэмдэгтэй өвчтөнүүдийн талаар эмч нарт хандан сэрэмжлүүлэг илгээжээ.¹⁰⁴ Тэрбээр цагдаагийн байгууллагаас “анхааруулга захиа” авсан байна.

Ли Вэн Лян Ухань-ий төв эмнэлэгт ажиллаж байхдаа 2020 оны эхээр КОВИД-19-ийн халдвар авчээ. Дараа нь тэр өвчний улмаас 2020 оны хоёрдугаар сард нас барсан. Үндэсний Хяналтын Хорооноос Ли Вэн Ляныг шүгэл үлээсний дараа түүнд хэрхэн хандаж байсан талаар мөрдөн шалгалт явуулжээ. Мөрдөн шалгагчид энэхүү анхааруулга захиаг “зохисгүй бөгөөд холбогдох хууль сахиулах журмыг хүндэтгээгүй” гэж үзэн цагдаагийн байгууллагад хүчингүй болгохыг санал болгожээ.¹⁰⁵



МАЛАЙЗЫН ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУД ЭСЭРГҮҮЦЛИЙН ТАЙВАН ЖАГСААЛ ХИЙСНИЙХЭЭ ТӨЛӨӨ ТОРГУУЛЖЭЭ

2020 оны 6-р сарын 2-ны өдөр Малайзын цагдаа нар эмнэлгийн цэвэрлэгээ эрхэлдэг компанийн эсрэг суулт хийж байсан эмнэлгийн ажилтнууд, идэвхтнүүдийн тайван цугларалтыг тараав. Ажилтнуудын гомдол нь компанийн зүгээс үйлдвэрчний эвлэлийн гишүүн ажилтнуудад шударга бус ханддаг, мөн түүнчлэн эмнэлгийн цэвэрлэгээний ажилтнуудад хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) хомс байгаа зэрэг асуудлыг хөндөж тавьжээ. Цагдаа нар тэднийг “зөвшөөрөлгүй цуглаан зохион байгуулсан” хэмээн буруутгаж таван идэвхитнийг нэг шөнийн дотор баривчилж торгон, эвлэлдэн нэгдэх, хуран цугларах эрх чөлөөг нь зөрчсөн байна. Эмнести Интернэшнл Малайзын Дотоод хэргийн сайдад хандан тэднийг буруутгасан бүх хэргийг цуцлахыг уриалж байна.¹⁰⁶

Пакистанд 2020 оны 4-р сард эрүүл мэндийн ажилтнууд хөдөлмөрийн нөхцөл, XXX дутмаг байгааг эсэргүүцэн тэмцэв. Мөн тэр сард Залуу эмч нарын холбоо өлсгөлөн зарлажээ.¹⁰⁷ Дөрөвдүгээр сарын 6-ны өдөр Кветта-д эсэргүүцэн жагссан эмч нарын эсрэг хамгаалалтын алба хүч хэтрүүлэн хэрэглэж, тэднийг зодож, 53 ажилтныг дор хаяж 24 цагийн турш хорьж саатуулсан байна.¹⁰⁸ **Хонконгт** Эмнэлгийн удирдах ажилтнуудын холбооны 9000 эрүүл мэндийн ажилтнууд

¹⁰⁴ Эмнести Интернэшнл, Хятад: Эмчийн үхэл нь коронавирусийн дэгдэлтийн үе дэх хүний эрхийн зөрчлийг онцлон харуулж байна, 2020 оны 2-р сарын 7, <https://www.amnesty.org/en/latest/news/2020/02/china-doctor-death-highlights-human-rights-failings-in-coronavirus-outbreak/>

¹⁰⁵ “Хятад Доктор Ли Вэн Лян-тай холбоотой асуудлаар хийсэн мөрдөн шалгах ажлын тайлан гаргажээ”, Синьхуанет, 2020 оны 3-р сарын 19, http://www.xinhuanet.com/english/2020-03/19/c_138896212.htm

¹⁰⁶ Үйлдвэрчний эвлэлийнхний мэдэгдэж байгаагаар, COVID-19 цар тахал эхэлсэн цагаас хойш цэвэрлэгээний ажилчдад COVID-19 өвчлөлийн эргэн тойрон орчин болон байгууламжийг цэвэрлэхэд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл хүртээмжтэй байгаагүй бөгөөд цэвэрлэгээний үйлчилгээ эрхэлсэн компани нь (Edgenta UEMS) тэдэнд хангалттай тооны маск, бээлий олгоогүй байна. Үйлдвэрчний эвлэл тус компанийг ажилтнуудад онцгойлон ялгавартай хандаж байсныг буруутгаж байв. Зургадугаар сарын 3-нд тус компани холбооноос гаргасан мэдэгдлийг няцаасан мэдэгдэл гаргажээ. Гэсэн хэдий ч үйлдвэрчний эвлэлийн хууль ёсны төлөөлөгчид анхны мэдэгдэлдээ тууштай зогсож байв. 6-р сарын 19-ний өдөр Малайзын Эмнести Интернэшнлд бичсэн захидалдаа компани уг мэдэгдлийг дахин няцаахын зэрэгцээ цар тахал эхэлснээс хойш тэд олон арга хэмжээ авч ажилласан гэж мэдэгджээ. Үүнд, үйлдвэрчний эвлэлээс гаргасан мэдэгдлийг хянах дотоод ажлын хэсэг байгуулах; Малайзын хойд хойгт байрлах нэр бүхий эмнэлгүүдэд XXX-д хяналт шалгалт хийх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний (ЭМТҮ) ажилтнуудтай уулзалт хийх; (ЭМТҮ) ажилтнуудын санал хүсэлт, сэтгэл зовоосон асуудлыг дээд удирдлагатай хуваалцах онлайн суваг болох PrihatinLine-ийг хөгжүүлэх г.м

¹⁰⁷ “Пакистаны эмч нар өлсгөлөн зарлаж байна”, Энэтхэг, 2020 оны 4-р сарын 25, The Hindu, 25 April 2020, <https://www.thehindu.com/news/international/pakistan-doctors-on-hunger-strike/article31434755.ece>

¹⁰⁸ S Khan “Пакистан дахь COVID-19: Төр засаг, эмч нар яагаад харшлах вэ?”, Дойче Велле, 2020 оны 4-р сарын 16, <https://www.dw.com/en/covid-19-in-pakistan-why-the-government-and-doctors-are-at-odds/a-53149990>

Засгийн газраа тус хотод коронавирусийн дэгдэлт үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд эх газрынхаа хилийг хаагаагүйд буруутган Засгийн газрын эсрэг ажил хаялт явуулахаар санал нэгдэв. Хожим нь, Хонконгод ажил хаялт явуулах эрх нь хуулиар хамгаалагдсан байдаг ч хууль тогтоогч нар ажил хаясан эмч нарыг ирээдүйд эмнэлгийн янз бүрийн чиглэлээр мэргэшүүлэхийг хориглох замаар шийтгэхийг санал болгов.¹⁰⁹ Энэ тухай хуульд заагдаагүй хэдий ч эмч нарыг айлгах үүднээс, тэднийг ажил хаялт зохион байгуулахгүй, оролцохгүй байхыг анхааруулсан түгшүүртэй мессеж илгээж байсан байна. **Энэтхэгт** нэгэн эмч түүний эмнэлэгт хэвтэж буй “КОВИД-19-ийн вирусийн халдвартай өвчтөнүүдийг эмчилж буй эмч нарт засгийн газраас хангаж өгч байгаа хамгаалалтын хэрэгсэл нь хомс байгаа талаар санаа зовнин Фэйсбүүктээ хэд хэдэн бичлэг нийтэлсний дараа түүнийг цагдаа нар байцаасан бөгөөд утсыг нь хураан авчээ.”¹¹⁰ Калькутта-ийн Дээд шүүхээс эрх баригчдад түүний гар утсыг буцааж өгөхийг тушааж, “өргөдөл гаргагч-эмчийг зохих шүүхийн зөвшөөрөлгүйгээр үргэлжлүүлэн байцаах ёсгүй” гэсэн чиглэл өгсөн байна.

«Би сэтгэлээр маш их унаж байна. Засгийн газар, нутгийн захиргааны албан хаагчид эмч нарыг хамгаалахын тулд чадах бүхнээ хийхгүй байна ... Бидэнд тэмцэхээс өөр ямар ч найдвар алга. Гэтэл одоо бидний тэмцэхийг ч хориглож байна. Тэд бидний амыг барьж байна.»

Эрүүл мэндийн ажилтан, Пакистан¹¹¹

Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой асуудал болон цар тахлыг Засгийн газрууд нь хэрхэн даван туулж байгаа талаар нийтэд ил болгож ярьснаас үүдэн тэднийг ажлаас халсан, эсвэл сахилгын шийтгэл хүлээлгэсэн тохиолдол хэд хэдэн улс оронд гарсан байна. Жишээлбэл, **Никарагуад** эрүүл мэндийн ажилтнууд үг хэлснийхээ төлөө ажлаас халагдсанд санаа зовж байгаагаа Хүний эрхийн Америк хоорондын Комисс илэрхийлсэн байна.¹¹² **Бразилын** Эрүүл мэндийн ажилтнуудын Холбооны төлөөлөл “Дарамт шахалт нь заналхийлэх байдлаар явагдаж байна” гэж Эмнести Интернэшнлд хэлэв.¹¹³ **ОХУ-д** дотоод шүүрлийн эмч Юлия Волковаг эмч нарыг хувийн хамгаалах хэрэгслээр (ХХХ) хангахыг шаардан 3-р сарын 25-ны өдөр твиттер дээрээ видео нийтлүүлсний дараа эрх баригчид түүнийг КОВИД-19-ийн тухай “зориудаар хуурамч мэдээлэл тараасан” хэмээн буруутгаж, түүнд захиргааны хэрэг үүсгэжээ.

“Би видеоогоороо хэнийг айлгачихсан юм бэ? Би энд эмнэлгийнхээ талаар хэлээгүй, ахлах эмчийнхээ нэрийг ч дурдаагүй. Би зөвхөн биднийг орчин үеийн хамгаалах хэрэгслээр хангахыг шаардаж байна гэж хэлсэн шүү дээ ” гэж Юлия Волкова Эмнести Интернэшнлтэй уулзахдаа хэлэв.¹¹⁴

UIN.MN
СҮДАЛГААНЫ САН

¹⁰⁹ “Ажил хаясан эмч нарыг мэргэшүүлэхийг хориглох: “Ban strike doctors from specialisations: Regina Ip”, RTHK 8 April 2020, <https://news.rthk.hk/rthk/en/component/k2/1519571-20200408.htm>

¹¹⁰ Доктор Индранил Хан в Баруун Бенгалийн муж ба бусад, WP 5326 (W) of 2020, https://www.scribd.com/document/454566448/Calcutta-NC-Indranil-Khan-writ-petition-order#fullscreen&from_embed

¹¹¹ Эмчтэй хийсэн ярилцлагаас, 22 May 2020, Lahore, Pakistan

¹¹² Хүний эрхийн Америк хоорондын Комиссын мэдэгдлийг эндээс авах боломжтой: <https://twitter.com/cidh/status/125514989533529287?s=21>

¹¹³ Эмчтэй утсаар хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 20

¹¹⁴ Эмч Юлия Волковагийн эсрэг үүсгэсэн хуурамч мэдээллийн хэргийг цуцлахыг шаардсан Эмнести Интернэшнлийн шаардлагыг үзнэ үү, 2020 оны 5-р сарын 8-ны өдөр, <https://eurasia.amnesty.org/2020/05/08/amnesty-international-trebu-et-prekrasheniya-dela-o-fake-news-v-otnoshenii-vracha-yulii-volkovoj/>



ТАТЬЯНА РЕВВА¹¹⁵

ОХУ-Д ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ЭМЧ ХАВЧИЛГАД ӨРТӨЖ БАЙНА

Калач-на-Дону дахь эрчимт эмчилгээний тасгийн эмч, доктор Татьяна Ревва КОВИД-19 цар тахалтай тэмцэж байгаа эмнэлгийн ажилтнуудад хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) дутагдалтай байгаа талаар эмнэлгийн удирдлагад удаа дараа гомдол гаргасны дараа хавчилгад өртөх, ажлаас халах заналхийлэл болон ажил мэргэжилтэй холбоотой бусад асуудлуудтай нүүр тулжээ.

Гуравдугаар сарын эхээр, тэрээр өөрийн ажилладаг эмнэлгийн эмч нарт тулгарч буй асуудлын талаар санаа зовниж буйгаа хараат бус үйлдвэрчний эвлэлийн холбоо болох Эмч нарын холбоонд мэдэгдэж, үүсээд буй нөхцөл байдлын талаар видео бичлэг хийжээ. Эмч нарын холбоонд түүний бичсэн захидал болон видео бичлэг олон нийтэд ил болсон байна. Тэрбээр Эмнести Интернэшнлд хэлэхдээ, нэг сарын хугацаанд эмнэлгийн удирдлагаас хоёр удаа албан ёсоор зэмлүүлж, нэг удаа бичгээр сануулга авч, зургаан удаа ажил дээр гарсан зөрчлийн талаар бичгээр тайлбар гарган өгөх шаардлагатай болсон гэв.

Өвчтөний нууцлалыг зөрчсөн гэж Татьяна Реввагийн эсрэг сахилгын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн байна. Өвчтөн нь зүрхний шигдээстэй гэж оношлогдон эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт хэвтэж байсан түүний аав юм. Татьяна Ревва зөвлөлдөх эмч нь биш байсан ч гэсэн өвчтөний анкетыг бөглөх ёстой гэсэн үндэслэлээр албан ёсоор зэмлэл хүртжээ. Энэ нь түүний хийх ажил биш юм. Татьяна Ревва энэ үйл явдлыг холбоонд ирүүлсэн захидалдаа болон сэтгүүлчтэй хийсэн ярилцлагадаа дурдсан боловч эцгийнхээ хувийн мэдээлэл, оношийг дэлгэсэнгүй, улмаар өвчтөний хувийн нууцыг зөрчөөгүй. Гэсэн хэдий ч энэ нь түүний сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэслэл болж, түүнийг ажлаас халахад хүргэсэн бөгөөд энэ нь XXX дутагдалтай холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлснийхээ төлөө шийтгэгдсэн гэж таамаглаж байна.



Волгоград мужийн Калач-на-Дону хотын төв дүүргийн эмнэлгийн эмч Татьяна Ревва, 2020 оны 4-р сар. © Хувийн

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

¹¹⁵ Эмнести Интернэшнл, ОХУ: Шүгэл үлээгч эмч нар хавчин шахагдаж байна: Татьяна Ревва, 2020 оны 5-р сарын 11, EUR 46/2301/2020, <https://www.amnesty.org/en/documents/eur46/2301/2020/en/>

Египетэд эрх баригчид «хуурамч мэдээлэл түгээх», «терроризм» гэх мэт маш олон төрлийн хэргийг нэр заан ашиглаж, эрүүл мэндийн ажилтнуудыг дур мэдэн баривчлах, цагдан хорих, захиргааны арга хэмжээ авч байгааг Эмнести Интернэшнл баримтжуулсан байна.¹¹⁶ Эрүүл мэндийн ажилтнуудын санаа зовнин гаргаж тавьсан асуудлуудад хөдөлмөрийн аюултай нөхцөл, шаардлага хангасан хувийн хамгаалах хэрэгслийн (ХХХ) хомсдол, халдварын хяналтын сургалт хангалтгүй байдал, эрүүл мэндийн ажилтнуудыг шинжилгээнд бүрэн хамруулахгүй байдал, эрүүл мэндийн зайлшгүй тусламж үйлчилгээний хүртээмж хангалттай биш зэрэг асуудлууд багтаж байв. Үндэсний аюулгүй байдлын албанаас энэ оны 3-6-р сарын хооронд **дур зоргоор баривчлагдсан эрүүл мэндийн есөн ажилтны** (долоон эмч, хоёр эм зүйч) хэргийг шалгаж байгааг Эмнести Интернэшнл баримтжуулсан. Тэднийг буруутгах болсон шалтгаан нь ердөө өөрсдийн эрүүл мэндтэй холбоотой асуудлыг сөхөн тавьж, нийгмийн сүлжээний нийтлэлд илэрхийлсэн явдал юм. Эмнести Интернэшнл мөн дээрхтэй ижил асуудлыг хөндөж тавьсан хамт ажиллагсдынх нь аюулгүй байдалд заналхийлсэн, удирдлагын зүгээс дарамталсан явдлыг гэрчилсэн долоон эмчтэй ярилцсан байна. 6-р сарын 27-ны өдөр Египетийн аюулгүй байдлын хүчнийхэн Эмч нарын Синдикатын (Эмч нарын холбоо) гишүүдийг тус улсын хэмжээнд Ковид-19-өөр амиа алдагсдын тоо нэмэгдэж байгаа явдалд эмч нарын үүрэг хариуцлагын талаар Ерөнхий сайдад мэдээлэх зорилгоор хэвлэлийн бага хурал зохион байгуулахыг нь хориглосон байна. Энэхүү үйл явдалд оролцсон Синдикатын гишүүний хэлснээр, аюулгүй байдлын албаныхан Синдикатыг бүсэлж, хэвлэлийн хурал зохион байгуулагчдыг хурлаа хойшлуулахыг шаардсан байна.¹¹⁷ Эмч нарын Синдикатын мэдээлснээр хоёр эмчийг Ерөнхий сайдын мэдэгдлийг шүүмжилсэн үйл явдлыг нийгмийн сүлжээгээрээ сурталчилсан хэмээн саатуулжээ. Эмч нарын Синдикатаас ирсэн эх сурвалжаас үзвэл эмч нарыг заналхийлж, Үндэсний аюулгүй байдлын алба байцааж, захиргааны хэрэг үүсгэн, торгууль ногдуулж байгааг батлав. Тэр хэлэхдээ «Энэ талаар бидэнд маш олон гомдол ирж байна. Үүний хажуугаар бусад хүмүүс энэхүү дарамт, заналхийллээс зайлсхийн хувийн хамгаалах хэрэгслээ (ХХХ) өөрсдийн мөнгөөр авч хэрэглэхээс аргагүй байдалд хүрч байна. Тэд эмч нарыг үхэл болон шоронгийн аль нэгийг нь сонгоход хүргэж байна” гэжээ.¹¹⁸

АНУ-д Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд Ковид 19 цар тахалтай холбоотой асуудлаар эсэргүүцлээ илэрхийлэх боломжтой боловч ажил олгогчдын зүгээс эрүүл мэндийн ажилтнуудаа дарамтлах, сахилгын арга хэмжээ авах, шударга бусаар халах зэргээр айлган сүрдүүлж тэднийг дуугүй болгосон талаар хэд хэдэн мэдээлэл гарсан. АНУ-д бүртгэлтэй 4 сая сувилагчийн эрх ашгийг төлөөлж ажилладаг Америкийн Сувилагчдын нийгэмлэгээс гаргасан мэдэгдэлд «ажил олгогч нь сувилагч болон бусад эрүүл мэндийн ажилтнуудаас Ковид-19-өөр өвчилсөн хүмүүсийг асран халамжилж байхдаа хувийн аюулгүй байдлаа хангуулах талаар хууль ёсны асуудал тавьсны төлөө ажил олгогчдын зүгээс авч байгаа хариу арга хэмжээний талаар мэдээлэл аваад санаа зовниж байгаа тухайгаа дурдсан байна. Айлган сүрдүүлсэн, ажлаас халсан, нийгмээс тусгаарласан талаарх мэдээ тайлангууд нь байж боломгүй зүйл юм” гэж дурьджээ.¹¹⁹



ТАЙНИКА СОМЕРВИЛЛ¹²⁰ **АНУ-ЫН ГЭРИЙН АСРАГЧ**

Тайника Сомервилл нь Иллинойс мужийн Кук дүүргийн Бриджвью Эрүүл мэндийн төвд сувилагчийн туслахаар ажиллаж байгаад 4-р сарын 2-нд ажлаасаа халагджээ. Үүнээс хоёр хоногийн өмнө тэр бусад хэдэн ажилтнуудын хамтаар эрх баригчдад хандан ажлын байранд нь хувийн хамгаалах хэрэгслэл (ХХХ) дутмаг байгаа талаар дурдан, ХХХ-ээр хангаж өгөхийг шаардан гаргасан хүсэлтээ уншиж Фэйсбүүк хуудсандаа шууд видео дамжуулалт хийсэн байжээ.

AMN.MN
СУДАЛГААНЫ САН

¹¹⁶ Эмнести Интернэшнл, Египет: Эрүүл мэндийн ажилтнууд 'үхэл эсвэл шоронд гэсэн боломжгүй сонголтыг хүчээр хийхэд хүрч байна, 2020 оны 6-р сарын 18, <https://www.amnesty.org/en/latest/news/2020/06/egypt-health-care-workers-forced-to-make-impossible-choice-between-death-or-jail/>

¹¹⁷ Эрүүл мэндийн ажилтантай утсаар хийсэн ярилцлага, Египет, 2020 оны 6-р сарын 29

¹¹⁸ Эрүүл мэндийн ажилтантай утсаар хийсэн ярилцлага, Египет, 2020 оны 6-р сарын 10

¹¹⁹ Америкийн мэдээллийн агентлаг (ANA) "Ковид-19-ийн талаар сэтгэл зовниж асуудлыг гаргаж тавьсан сувилагч нарын эсрэг авсан хариу арга хэмжээний талаар сонсоод сэтгэл түгшив, 2020 оны 4-р сарын 9, <https://www.nursingworld.org/news/news-releases/2020/ana-disturbed-by-reports-of-retaliation-against-nurses-for-raising-concerns-about-covid-19-safety/>

¹²⁰ Эмнести Интернэшнл, Эмчилгээний өртөг: КОВИД-19- цар тахлын үе болон түүний дараах үеийн Америк дахь эрүүл мэндийн ажилтнуудын эрх (Index: AMR 01/2311/2020)

Сувилагчийн туслахаар 20 гаруй жил ажилласан тэрээр хувийн асрамжийн газарт ахмад настай оршин суугчдыг хооллох, усанд оруулах, амин чухал шинж тэмдгүүдийг шалгах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хийж ахмад настныг асардаг байв. Таиника Сомервилл асрамжийн газарт КОВИД-19 өвчлөл байгааг компани хэрхэн нууцалж байгаад сэтгэл дундуур байсан тухайгаа Эмнести Интернэшнлд “Бид КОВИД-19 өвчлөл асрамжийн газарт байсан гэдгийг олж мэдээд нүүр рүүгээ алгадуулах мэт болсон. Бүх л хугацааны туршид компани бидэнд асрамжийн газрын барилга дотор халдвар илрээгүй гэж хэлж байсан. Эцэст нь бид сонины өгүүллээс олж мэдсэн” хэмээн өгүүлсэн юм.

Таиника Сомервиллийг өгсөн зааврыг биелүүлэхээс татгалздаг гэж компани нь гүтгэн, амаар болон бичгээр буруутгаж байгааг Эмнести Интернэшнлд хэлжээ. Ажлын байрныхаа нөхцөл байдал, хувийн хамгаалах хэрэгсэл дутагдалтай байгаа талаар нийгмийн сүлжээгээр мэдээлснээсээ болж ажлаасаа халагдсан гэж тэр үзэж байна. Эмнести Интернэшнл Сомервиллийн ажил олгогчдын толгой компанид захидал илгээж, эдгээр асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн боловч хариу хараахан ирээгүй байна. Таиника Сомервилл: яг одоо ажилдаа буцаж орохыг л хүсч байна гэж Эмнести Интернэшнл байгууллагад хэлжээ.



Таиника Сомервилл,
Сувилагчийн туслах,
Иллинойс, АНУ Illinois, USA.
© Хувийн

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

6. ГУТААН ДОРМЖЛОЛ БА ХҮЧИРХИЙЛЭЛ

Олон улс оронд эрүүл мэндийн ажилтнууд урьд өмнө байгаагүй олон нийтийн эв нэгдэл, дэмжлэгийг олж харсан. Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад олон нийтийн зүгээс талархал илэрхийлж, тэдэнд хүндэтгэл үзүүлж байв. Харамсалтай нь, зарим оронд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд Ковид-19 цар тахлын эсрэг ажил мэргэжлээсээ болж гутаан доромжлол, хүчирхийлэлд өртсөн байдаг. Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг ийм гутаан доромжлол, хүчирхийлэлд өртөхгүй байхыг баталгаажуулах, гутаан доромжилсон явдлыг буруушааж, шаардлагатай тохиолдолд тэдний эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийн аливаа хэргийг мөрдөн байцаах, шүүх ажиллагаа явуулах ёстой. Ажил олгогчид, тэр дундаа хувийн хэвшлийн ажил олгогчид ч ажил эрхлэлттэй нь холбоотой гутаан доромжлол, хүчирхийлээс ажилтнуудаа хамгаалахын тулд дор дурьдсан шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.

Хүний эрхийн талаархи олон улсын гэрээнүүдэд тэгш эрх, үл ялгаварлагдах эрхийг баталгаажуулсан байдаг.¹²¹ Улс орнууд үл ялгаварлагдах эрхийг нэн даруй бусад эрхүүдтэй хамтад нь хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд олон улсын эрх зүйгээр баталгаажсан бусад бүх эрхийг хэрэгжүүлэхэд чухал хамаатай. ЭЗНСЭ-ийн Хорооноос Оролцогч улсууд ялгаварлан гадуурхах бодит шалтгаан болсон нөхцөл байдал, хандлагаас урьдчилан сэргийлэх, багасгах, арилгах арга хэмжээг ямарч нөхцөлгүйгээр нэн даруй авах ёстой гэжээ.¹²² ЭЗНСЭ-ийн Хороо Оролцогч улсууд “хувийн салбар дах хувь хүн, аж ахуйн нэгжийг ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулсан хууль тогтоомжийг батлах зэрэг арга хэмжээ авах ёстой” гэдгийг тэмдэглэсэн.¹²³

Гутаан доромжлол нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг нийтийн тээвэр зэрэг зайлшгүй шаардлагатай үйлчилгээ авах, орон байрандаа хүрч очиход бэрхшээлтэй болгох, эсвэл олон нийтийн зүгээс үзүүлэх сөрөг хандлага гэх мэт хэлбэрээр илэрч байна. **Филиппиний** Манила хотын улсын хамгийн том эмнэлгийн сувилагч Роза [нэрээ нууцалсан] Эмнести Интернэшнлд хэлэхдээ:

«Би нийтийн тээврийн автобусаар гэртээ харьж яваад ялгаварлан гадуурхалд өртсөн. Тэр үед нийтийн тээврийг хориглоогүй байсан. Би дүрэмт хувцастайгаа явж байсан тул эмнэлгийн ажилтан гэдэг маань тодорхой байсан нь мэдээж. Маш олон удаа автобус миний урд зогсолгүй явсан. Хэрэв би автобусанд суувал дотор нь байгаа хүмүүс надаас зайлсхийх болно. Заримдаа би дүрэмт хувцсаа өмсөлгүйгээр ажилдаа явах тухай бодох болсон. Үүнээс болоод торгуулсан ч хамаагүй” гэв.¹²⁴

Мөн **Нигерийн** нэгэн эмч “Би эмнэлгийн дүрэмт хувцастайгаа явж байсан тул супермаркетад

¹²¹ ЭЗНСЭОУП; ИУТЭОУП; Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийн устгах тухай олон улсын Конвенц; Арьс өнгөөр Алагчлах Бүх Хэлбэрийн устгах тухай олон улсын Конвенц; Хүүхдийн эрхийн тухай Конвенц.; болон Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний эрхийн тухай Конвенц зэрэг орно.

¹²² ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №20: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг ялгаварлан гадуурхахгүй байх, Е/С.12/ГС/20, 2009 оны 7 сарын 02, § 8(b)

¹²³ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №20: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг ялгаварлан гадуурхахгүй байх, Е/С.12/ГС/20, 2009 оны 7 сарын 02, § 11

¹²⁴ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 27,

намайг оруулаагүй” гэж Эмнести Интернэшнлд мэдэгджээ.¹²⁵

Хүмүүс эрүүл мэндийн ажилтнуудыг Ковид-19 зөөвөрлөж, халдвар тараана гэж үзсэнээс орон сууц, зайлшгүй шаардлагатай үйлчилгээний газруудад нэвтрүүлэхгүй байсан талаар мэдээллүүд байна. Арав гаруй улс оронд эрүүл мэндийн ажилтныг амьдардаг газраас нь хөөх, нүүлгэн шилжүүлэх оролдлого хийх зэргээр амьдрах газар олоход хүндрэлтэй болгож байсан, эсвэл амьдардаг газарт нь гутаан доромжлох зэрэг асуудал тулгарч байсан тухай мэдээлжээ.¹²⁶

«Сүүлийн гурван сарын хугацаанд, эмнэлгийн ажилтнуудад халдсан халдлагын тоо мэдэгдэхүйц нэмэгдсэн. Үүнд Ковид-19-тэй холбоотойгоор хүн амын дунд үүссэн стресс, түгшүүр, үймээн самуун зэрэг гол хүчин зүйл нөлөөлсөн. Эмнэлэгт амьсгалын аппарат дутагдалтай байгаад эмч нарыг буруутгаж байв. Өвчтөнийг КОВИД-19 халдвартай хэмээн сэжиглэвэл бас л эмч нарыг буруутгаж байв. ЗМЯ-ны гаргасан алдаатай шийдвэрүүд болон тоног төхөөрөмжийн хомсдолд өвчтөний хамаатан садан нь ихэвчлэн эмч нарыг хамаатуулж буруутган бие махбодод нь халдах болон хэл амаар дайрч доромжилж байна».

Эмч, Судан¹²⁷

Цаашилбал, КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эсрэг халдлага нэмэгдэж байгаа нь хамгийн их сэтгэл зовоосон асуудал болж байна. Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд дайралтад өртөж байна, тухайлбал, ажлын байрандаа, ажил руугаа явах замдаа, мөн түүнчлэн гэр орондоо хүчирхийлэлд өртөж байна. 2020 оны 5-р сард 30 сая гаруй эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдийг төлөөлсөн эрүүл мэндийн болон хүмүүнлэгийн дэлхийн 13 байгууллага эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг халдлага нэмэгдэж байгааг буруушааж мэдэгдэл (тунхаглал) гаргажээ. Мэдэгдэлд «эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг КОВИД-19-тэй холбоотойгоор 200 гаруй дайралтын тохиолдол гарсан нь уг өвчний эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж буй тэргүүн шугамынханд төдийгүй нийгэмд аюул занал учруулж байгаа явдал юм» гэж дурдсан байна.¹²⁸ Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн талаар орон нутгийн болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн нийтэлж байсан ба ийм хэргүүд дэлхийн олон орны хэмжээнд бүртгэгдсэн байна.¹²⁹

Жишээлбэл, **Мексикт** эрүүл мэндийн ажилтнуудыг гудамжинд явж байхад нь халдаж, нэг сувилагч руу хлортой бодис цацсан байна.¹³⁰ 4-р сарын 28-ны байдлаар, Мексикийн Дотоод хэргийн яам тус улсын 22 мужид эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг халдсан хамгийн багадаа 47 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд халдлагын 70% нь эмэгтэйчүүдийн эсрэг хийгдсэн байна.¹³¹ Ялгаварлан Гадуурхалаас Урьдчилан Сэргийлэх Үндэсний Зөвлөлөөс (ЯГУСУЗ) 3-р сарын 19-нөөс 5-р сарын 8-ны хооронд эрүүл мэндийн ажилтнуудын дунд КОВИД-19-өөс үүдэлтэй ялгаварлан гадуурхсан тухай 265 гомдол ирсэн ба үүний 17 нь эмчээс, 8 нь сувилагчаас, 31 нь захиргааны болон дэмжин туслах ажилтнуудаас ирсэн байна.¹³² **Филиппинд** нэгэн эмнэлгийн хангамжийн ажилтан руу гудамжинд халдаж, довтлогчид түүний нүүр рүү цайруулагч бодис цацсан

¹²⁵ Эмчтэй хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 13 [утсаар]

¹²⁶ Эдгээр орнуудад Этиоп, Непал, Сальвадор, Гондурас, Энэтхэг, Индонез, Чили, Аргентин, Итали зэрэг улсууд багтана.

¹²⁷ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Хартоум муж, Судан улс, 2020 оны 5-р сарын 26, WhatsApp-аар.

¹²⁸ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эсрэг хүчирхийллийн өнөөгийн байдлын талаарх эрүүл мэндийн нийгэмлэгийн мэдэгдэл, <https://healthcareindanger.org/resource-centre/declaration-by-the-health-care-in-danger-community-of-concern-about-the-current-situation-of-violence-against-health-care/>

¹²⁹ Д МакКэй нар “Ялангуяа дэлхий нийт КОВИД-19-тэй тэмцэж байгаа энэ үед, эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг халдлагыг зогсоох хэрэгтэй”, 395 Lancet, хуу 1743, 2020 [https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)31191-0/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)31191-0/fulltext); “Ковид-19 үеэр эрүүл мэндийн ажилтнууд гэнэтийн бай болж байна”, Эдийн засагч, 2020 оны 5-р сарын 11, <https://www.economist.com/international/2020/05/11/health-workers-become-unexpected-targets-during-covid-19>

¹³⁰ К Семпл, “Сувилагч болохоос айж байна”: Эрүүл мэндийн ажилтнууд халдлагад өртөж байна, New York Times, 2020 оны 4-р сарын 27, <https://www.nytimes.com/2020/04/27/world/americas/coronavirus-health-workers-attacked.html>

¹³¹ Дотоод хэргийн яам “КОВИД-19-той холбоотой эрүүл мэндийн урьдчилан таамаглаагүй нөхцөл дэх хүний эрхийн зөрчлийн ажиглалт”, 2020 оны 4-р сарын 28. 2020 оны 5-р сарын 12-ны өдөр шинэчлэгдсэн. <https://www.gob.mx/segob/documentos/observaciones-sobre-violaciones-a-derechos-humanos-durante-la-contingencia-sanitaria-por-covid-19> - ээс авав.

¹³² J Xantomitola, “Конапрэдэд хамгийн их гомдол гаргасан гурав дахь бүлэг бол эрүүл мэндийн ажилтнууд”, <https://www.jornada.com.mx/2020/05/11/politica/005n2pol> - ээс авав.

байна.¹³³ **Энэтхэгийн** Индор хотод хүмүүс КОВИД-19 шинжилгээ хийлгэхээр нутагтаа ирсэн эрүүл мэндийн ажилтнууд руу чулуу шиджээ.¹³⁴ **Орос улсад** бүлэг хүмүүс түргэн тусламжийн ажилтнууд руу дайрч, “халдвар авсан хүмүүс хаана байгааг хэлэхийг шаарджээ”.¹³⁵ **Франц улсад** дээрэм үйлдэгдсэн, эрүүл мэндийн ажилтнуудын гэрт нэвтэрч, ХХХ-ийг хулгайлсан тохиолдол бүртгэгджээ.¹³⁶ Мөн 4-р сараас хойш **Пакистанд** эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг хэд хэдэн удаа хүчирхийлэл үйлдсэн тохиолдлыг Эмнести Интернэшнл бүртгэсэн байна. Эмнэлгүүдийг эвдлэн сүйтгэж, олон эмч нар дайралтад өртсөн бөгөөд тэрчлэн тэдний нэгийг нь Терроризмын Эсрэг Хүчний нэг гишүүн бууджээ. Залуу эмч нарын нийгэмлэгийн мэдээлснээр эрүүл мэндийн ажилтнууд өдөр бүр халдлагад өртөж байгаа бөгөөд яг тодорхой тоог “тоолж баршгүй” юм гэжээ”.¹³⁷

Эмнести Интернэшнл нь энэхүү илтгэлийг боловсруулах явцдаа эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад тулгарч байсан хүчирхийллийн талаар сэтгэл түгшээсэн түүх, тайланг сонсож байв. **Бразил дахь** Эмнести Интернэшнлд Эмнэлгийн ажилтнуудын нийгэмлэгийн төлөөлөгч мэдэгдэхдээ: тэрээр эмчилгээ хийлгэхээр ирсэн өвчтөнүүдийн ар гэрийнхэн эмнэлгийн дотор эрүүл мэндийн ажилтнууд руу дайрч халдлагад өртсөн тохиолдлыг харсан тухайгаа хэлэв.¹³⁸ **Суданд** Суданы Эмч нарын Төв Хороо (СЭТХ) 2020 оны 3-р сараас 5-р сарын хооронд улс орон даяар эрүүл мэндийн ажилтнуудад халдсан 28 халдлага бүртгэгдсэн гэж мэдээлэв. Нэгэн эмч “Би КОВИД 19-ийн хариу арга хэмжээний үеэр нэгэн хэргийн гэрч болсон. Эмнэлгийн ажилтнууд вирусийн халдварын улмаас өвчтөний ар гэрийг эмнэлэгт нэвтрэхгүй байхыг сануулахад уг этгээд аюулгүй байдлын албаны гишүүн байсан бөгөөд эмч рүү дайрч, шархдуулсан” хэмээн Эмнести Интернэшнлд мэдэгдсэн юм.¹³⁹

Эдгээр халдлагын шалтгаан, сэдлээс үл хамааран эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эсрэг хүчирхийллийг тэвчих ёсгүй. Ажилтнуудыг ажлаа аюулгүй хийж чаддаг байх баталгааг бүрдүүлэх нь тэдний аюулгүй байдал төдийгүй эмчлэн асруулж буй хүн бүрийн аюулгүй байдлын асуудал юм.

Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд руу халдсан зарим тохиолдол нь оронд аюулгүй албаныхан болон хууль сахиулах ажилтнуудтай холбоотой байв. Тухайлбал **Нигери улсад** Ерөнхийлөгч эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хорио цээр, цагийн хязгаарлалтаас чөлөөлсөн шийдвэр гаргасан байна. Гэсэн ч тэд **зорчих хязгаарлалт**, хамгаалалтын албаныхны дарамт, айлган сүрдүүлэлттэй тулгарсаар байна.¹⁴⁰ 2020 оны 5-р сарын 20-ны өдөр Нигерийн Анагаах ухааны нийгэмлэгийн Лагос мужийн салбар нь Лагос дахь эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалалтын албаныхан дарамталсны дараа гишүүддээ гэртээ үлдэх чиглэл өгчээ. 4-р сард Дельта муж улсын Асаба хотын Холбооны эмнэлгийн төвийн эмч нар эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалалтын ажилтнууд дарамтлахын эсрэг тэмцэн ажил хаялт хийв.¹⁴¹ Нигерийн нэг эрүүл мэндийн ажилтан Эмнести Интернэшнлд “Би КОВИД-19-өөс тусгаарлах төвүүдийн нэгэнд тэргүүн шугамд ажилладаг ажилтнуудын нэг ... Аюулгүй байдлын хувьд орон даяар ажилладаг манай гишүүд иргэний үнэмлэхээ харуулахаас гадна

¹³³ К Семпл, “Сувилагч болохоос айж байна”: Эрүүл мэндийн ажилтнууд халдлагад өртөж байна, New York Times, 2020 оны 4-р сарын 27, <https://www.nytimes.com/2020/04/27/world/americas/coronavirus-health-workers-attacked.html>

¹³⁴ “Ковид-19: Хотод эрүүл мэндийн ажилтнууд руу халдав, Индор хотод гарсан халдлагын 7-д нь чулуугаар шидсэн байна” Hindustan Times, 2020 оны 4 сарын 3, <https://www.hindustantimes.com/india-news/covid-19-health-workers-attacked-in-cities-7-held-in-indore-for-pelting-stones/story-ZlBAlxXRhH7aFQyLZb8wmN.html>

¹³⁵ “Кострома хотод коронавирусийн шинжилгээ хийсний улмаас эмч нарын баг руу довтолжээ”, K1News, 2020 оны 4 сарын 16, <https://k1news.ru/news/koronavirus/v-kostrome-napali-na-brigadu-vrachey-iz-za-analizov-na-koronavirus/>. Үүнийг бас үзнэ үү, “Оросууд коронавирусийн шинжилгээ авахаар ирсэн эмчийг зодсон талаар видео бичлэгт нийтлэгджээ”, Lenta, 2020 оны 4 сарын 18, <https://lenta.ru/news/2020/04/18/skoraya/>

¹³⁶ R Noel et al, “Коронавирус: маск хулгайлах, эмнэлгийн асрагчид руу дайрч довтолох, ХХХ-ийн хомсдол үүсэх бүрд тэвчээр улам бүр алдагдаж байв”, Франц улс, Блю, 2020 оны 3 сарын 22, <https://www.francebleu.fr/infos/faits-divers-justice/coronavirus-masques-voles-soignants-agresses-quand-la-penurie-renforce-les-inciviles-1584893642>

¹³⁷ Дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү: Эмнести Интернэшнл, Нээлттэй захиа: Пакистан дахь эрүүл мэндийн ажилтнуудын хамгаалал. TGA ASA 33.2020.005, 2020 оны 7 сарын 1, <https://www.amnesty.org/download/Documents/ASA3326332020ENGLISH.pdf>

¹³⁸ Эмчтэй хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 20 [утсаар]

¹³⁹ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Судан улс, Хартоум муж улс, 2020 оны 5 сарын 27, WhatsApp-аар.

¹⁴⁰ “Цагийн хязгаарлалт тогтоох: Лагос NMA Эмч нарт чиглэсэн зааварчилгаа, Эмнэлгийн ажилтнууд өнөөдөр 18 цагаас эхлэн гэрээс гарахгүй байх,” Channels Television, 2020 оны 5 сарын 20, <https://www.channelstv.com/2020/05/20/curfew-lagos-nma-directs-doctors-health-workers-to-stay-at-home-from-6pm-today/>

¹⁴¹ “Карантин: Дельта мужийн эмч нар цагдаа нарын харгис хэрцгий байдлын эсрэг тодорхойгүй ажил хаялт эхлүүлжээ,” MSN News, 2020 оны 4 сарын 10, <https://www.msn.com/en-za/news/other/lockdown-doctors-in-delta-embark-on-indefinite-strike-over-police-brutality/ar-BB12qXpA>

заримдаа дүрэмт хувцсаа өмсөж байсан ч хамаагүй хамгаалалтын албаныхны дарамттай маш их тулгардагт бид сэтгэл их дундуур байна. Тэд зорчиход хязгаарлалт тавьж, айлгаж, дарамтласаар байна” гэсэн юм.¹⁴² **Непалд** цагдаа нар “хөл хорио зөрчсөн” гэсэн үндэслэлээр эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэсэн хоёр тохиолдол гарчээ. Цагдаа нар уучлал гуйж, тухайн албан тушаалтнуудад сахилгын арга хэмжээ авсан гэж мэдэгдэв.¹⁴³

«Засгийн газрууд, ажил олгогчид, ажилчдын байгууллагуудад хандан ажлын байрандаа болон ажилдаа ирж, буцах замдаа эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг хүчирхийллийг үл тэвчих арга хэмжээ авах, эрүүл мэндийн ажилтнууд болон тэдний гэр бүлд нийгмийн дэмжлэг, хүндэтгэлийг эрчимжүүлэхийг ДЭМБ-аас уриалж байна».

ДЭМБ-ын мэдэгдэл¹⁴⁴

Эдгээр халдлага болсон зарим орны засгийн газрууд хариу арга хэмжээ авахаар ажиллаж байна. Эрүүл мэндийн ажилтнууд халдлагад өртсөн зарим тохиолдлуудад хариуцлага хүлээлгээр хүмүүсийг баривчилсан бөгөөд цөөн хэдэн улсын засгийн газрууд эрүүл мэндийн ажилтнуудын үүргийг тодорхойлж, тэдний эсрэг хүчирхийллийг үл тэвчиж, үл зөвшөөрнө гэдгээ албан ёсоор мэдэгджээ. Тухайлбал, **Мексикт** засгийн газар эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг дэмжин олон нийтэд мэдэгдэл хийж, тэдний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна.¹⁴⁵ Итали,¹⁴⁶ Филиппин, Аргентин¹⁴⁷ зэрэг зарим улс оронд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг дарамтлах, ялгаварлан гадуурхсан тохиолдолд шийтгэл оногдуулах хууль тогтоомжийг хэлэлцэж, баталсан байна.

Эрүүл мэндийн ажилтнуудыг аливаа хүчирхийллээс хамгаалахын тулд эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд болон засгийн газар хэд хэдэн алхамыг хийх шаардлагатай байна. Жишээлбэл, Олон улсын Улаан Загалмайн Хороо (ОУЗХ) нь КОВИД-19-ийн хариу арга хэмжээний үеэр эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн үед ямар хариу арга хэмжээ авах зөвлөмжийг багтаасан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналтын хуудас”-ыг боловсруулжээ. Үүнд стресс, хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй эрүүл мэндийн ажилтнуудыг хэрхэн дэмжих; эрсдлийг хэрхэн үнэлэх, бэлэн байдлын арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх; ажилтнуудын эрх, үүргийг хэрхэн сурталчлах; олон нийттэй харилцахын ач холбогдол; аюулгүй байдлын хүчнийхэнтэй хэрхэн уялдаатай ажиллах; эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг хүчирхийллийн үйлдлийг баримтжуулах хэрэгцээ шаардлагын талаар тодорхой удирдамжийг багтаасан байна.¹⁴⁸ Хүмүүст цар тахлын талаар найдвартай, нотолгоотой мэдээлэл олж авах боломж олгох нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг гутаан доромжлох асуудлыг шийдвэрлэх түлхүүр болно. Мэргэжлийн хүмүүс болон мэргэжлийн холбоодын зүгээс нэмэлт зөвлөмж гаргасан байна. Үүнд: эрүүл мэндийн ажилтнууд ажилдаа явах болон ирэх үедээ хүчирхийлэл, гутаан доромжлолд өртөх эрсдлийг бууруулах зорилгоор тусгай тээврийн

¹⁴² Сувилагчтай хийсэн ярилцлага, Нигер, 2020 оны 5 сарын 29 [утсаар]

¹⁴³ “Эмч нарыг зодохын эсрэг цагдаа нар тэмцэж байна” Хөгжиж буй Непал, 2020 оны 4 сарын 16, <https://risingnepaldaily.com/mustread/police-take-action-against-dsp-lamsal-for-beating-doctors>

¹⁴⁴ ДЭМБ, “КОВИД-19 халдварт өвчний үед эрүүл мэндийн бүхий л ажилтнуудад эрүүл, аюулгүй, зохистой ажиллах нөхцөлийг хангахыг ДЭМБ-аас уриалж байна”, 2020 оны 4 сарын 28, <https://www.who.int/news-room/detail/28-04-2020-who-calls-for-healthy-safe-and-decent-working-conditions-for-all-health-workers-amidst-covid-19-pandemic>

¹⁴⁵ «Мексикийн Засгийн газар (2020, 4 сарын 23). “IMSS эрүүл мэндийн ажилтнуудын халдлагыг зогсоохыг уриалав”. <http://www.imss.gob.mx/prensa/archivo/202004/211> сайтаас үзнэ үү

¹⁴⁶ Хууль эрх зүйн мэдээлэл 18Ө - Bill n. 867-B, эндээс үзнэ үү: [http://www.senato.it/japp/bgt/showdoc/18/DDLPRES/0/1152754/index.html?part=ddlpres_ddlpres1-articolato_articolato1;S di Santo, “Okay by the House to the bill against aggression”, Nurse24, 21 May 2020, <https://www.nurse24.it/infermiere/leggi-normative/ddl-contro-aggressioni-sanitari-ok-camera.html>](http://www.senato.it/japp/bgt/showdoc/18/DDLPRES/0/1152754/index.html?part=ddlpres_ddlpres1-articolato_articolato1;S%20di%20Santo,%20Okay%20by%20the%20House%20to%20the%20bill%20against%20aggression%20Nurse24,%2021%20May%202020,%20https://www.nurse24.it/infermiere/leggi-normative/ddl-contro-aggressioni-sanitari-ok-camera.html)

¹⁴⁷ Аргентинд энэ нь зөвхөн Буэнос Айрес хотод батлагдсан орон нутгийн шинжтэй хууль юм. Илүү дэлгэрэнгүйг эндээс үзнэ үү: <https://www.telam.com.ar/notas/202005/469413-legislatura-portena-multas-discriminar-personal-salud.html>

¹⁴⁸ ОУЗХ, КОВИД-19 ба эрүүл мэндийн тусламжийн эсрэг хүчирхийлэл, КОВИД-19-ын эсрэг аюулгүй хариу арга хэмжээ: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналтын хуудас, https://healthcareindanger.org/wp-content/uploads/2020/05/4469_002_Safer_COVID-19_Response-Checklist_for_Health-care_Services-Lr_1.pdf

хэрэгслээр хангах;¹⁴⁹ эрүүл мэндийн ажилтнуудыг зохих ХХХ-ээр хангах, ингэснээр тэдний КОВИД-19-ийн халдвар авахаас эмээх айдас багасна;¹⁵⁰ эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг үйлдэгдсэн хүчирхийлэлд хариуцлагын механизмыг баталгаажуулах;¹⁵¹ зэргийг багтаасан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁴⁹ P Forgiione, “Ковид-19 цар тахлын үе дэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эсрэг хүчирхийллийн шинэ хэлбэрүүд”, 5 сарын 15, 2020, *The BMJ Opinion*, <https://blogs.bmj.com/bmj/2020/05/15/new-patterns-of-violence-against-healthcare-in-the-covid-19-pandemic/>

¹⁵⁰ P Forgiione, “Ковид-19 цар тахлын үе дэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эсрэг хүчирхийллийн шинэ хэлбэрүүд”, 5 сарын 15, 2020, *The BMJ Opinion*, <https://blogs.bmj.com/bmj/2020/05/15/new-patterns-of-violence-against-healthcare-in-the-covid-19-pandemic/>

¹⁵¹ D McKay et al, “Дэлхий ертөнц КОВИД-19-тэй тулалдаж байгаа энэ үед эрүүл мэндийн ажилтнуудын эсрэг халдлагыг нэн даруй зогсоох хэрэгтэй”, 395 *Lancet*, p 1743, 2020 [https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)31191-0/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)31191-0/fulltext)

7. БҮТЦИЙН АСУУДЛУУД

Өнөөдөр эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын өмнө нилээдгүй бэрхшээл тулгарч байна. Энэ тайланд тэдгээр тулгамдсан асуудлуудын ихэнхийг дурьдсан. Үүнд: цар тахлын үр дүнд гарч ирэн анхаарлын төвд орсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өргөн хүрээний бүтцийн асуудлууд ба нийгмийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо зэрэг багтана. Энэхүү тайлан нь эдгээр бүх үндсэн асуудлыг нарийвчлан судалж чадаагүй ч судалгааны явцад олон дахин давтагдаж байсан дөрвөн гол асуудлыг энэ хэсэгт онцлон авч үзсэн.



Эмнэлгийн Тусламж, Үйлчилгээ эрхлэгчдийн Үндэсний Эвлэлийн ажилтнууд бүтэн шөнө хоригдоод суллагдсаны дараа.
Байршил: Ipoh, Perak, 6 сарын 3, 2020. © Хувийн

ХЭРЭГЦЭЭНЭЭС БАГА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯМРАЛ, ДУТУУ ҮНЭЛСЭН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТОГТОЛЦОО

Дэлхий даяар эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн тогтолцоонд санхүүжилт дутмаг, тэргүүлэх салбарын хэмжээнд авч үзээгүй байсан тул КОВИД-19 цар тахал зэрэг гэнэтийн үйл явдал тохиолдоход асуудал илүү хүндэрч байна. Энэ нь дэд бүтэц тааруу, тоног төхөөрөмж хангалтгүй, боловсон хүчин дутмаг гэх мэт янз бүрийн нөхцөлд өөр өөр хэлбэрээр илэрчээ. Их Британийн Анагаах ухааны сэтгүүлээс дэлхийн эрүүл мэндийн санхүүжилтийн чиг хандлагыг судалж, эрүүл мэндийн нийтлэг эмчилгээ үйлчилгээний 218 арга хэмжээ бүхий “зайлшгүй шаардлагатай багц”-ын нэг хүнд ногдох жилийн үнэ 100 доллар (78 фунт буюу 90 евро) болно, харин 108 арга хэмжээ бүхий үндсэн багц болох “эн тэргүүний шаардлагатай багц”-ын нэг хүнд ногдох үнэ 50 доллар болно” гэжээ. 2016 оны тухайн үеийн хамгийн сүүлийн үеийн мэдээллээс үзвэл, дундаас доогуур орлоготой 49 орны 24 нь; бага орлоготой орнуудаас нэг нь ч дээр дурдсан тусламж үйлчилгээний аль ч багцад иргэдээ хамруулж чадаагүй байна. Эцэст нь, судалгаагаар “Эрүүл мэндийн зардлын тоон хэмжээ ихэсч байгаа боловч дэлхийн олон улс орнуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх үндсэн суурь багцын санхүүжилт дэндүү бага хэвээр байна, эрүүл мэндийн асуудалд засгийн газрууд тэргүүлэх ач холбогдол өгөхгүй байна” гэж дүгнэсэн байна.¹⁵²

Үүнээс болж зарим улс орны эрүүл мэндийн байгууллагууд дэд бүтцийн хомсдолд өртөж, ингэснээр цар тахлын үед эрүүл мэндийн ажилтнуудыг илүү сул дорой болгож, тэдний эрүүл мэнд, аж амьдралдаа эрсдэл учруулж байна. Жишээ нь, **Парагвайн** нэгэн сувилагч “Манай эмнэлэг бүтэн хоёр долоо хоногийн турш хэрэглээний усгүй байсан. Эмнэлгийн дэд бүтэц зохих түвшинд ердөө ажиллахгүй байна” гэжээ.¹⁵³ Үүнтэй адилаар, **Нигерийн** нэгэн сувилагч “Миний ажилладаг улсын эмнэлэгт эрүүл мэндийн ажилтнуудад гар угаах ус байхгүй байна. Эмч, сувилагч нар ариун цэврийн шаардлага хангахгүй аягаар ус авчирч угааж байна” гэж Эмнести Интернэшнлд өгсөн ярилцлагадаа дурьджээ.¹⁵⁴ **Венесуэльд** эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд явуулсан саяханы судалгаагаар Венесуэлийн эрүүл мэндийн системийн КОВИД-19-тэй тэмцэх чадварыг судлахад эмнэлгийн ажилтнуудын 31.8% нь ундны усгүй, 64.2% нь 2-р сарын 27-ноос 3-р сарын 1-ний хооронд л ундны устай байснаа мэдээлсэн байна. 5-р сарын 16-ны өдөр КОВИД-19-ийн нөлөөллийн талаар хийсэн өөр нэг үндэсний судалгаагаар эрүүл мэндийн салбарынхны 57.14%-д нь бээлий, 61.9% -д нь маск, 76.19% -д саван, 90.48% -д ариутгагч бодис дутагдалтай гэж мэдээлсэн байна.¹⁵⁵

Засгийн газрын хэмнэлтийн арга хэмжээ зэрэг тодорхой бодлогын улмаас зарим оронд, нийгмийн эрүүл мэндийн салбарт хэрэгцээнээс бага хөрөнгө оруулалт хийж нийгмийн эрүүл мэндийн зардлыг ихээхэн бууруулж, хүмүүсийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг бууруулахад нөлөөлсөн юм.¹⁵⁶

Жишээлбэл, хэмнэлтийн арга хэмжээ нь Грекийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг бууруулж, олон хүмүүс шаардлагатай үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, нийгмийн эрүүл мэндийн **тогтолцоонд** нэвтрэхэд хүндрэл учруулж, эрүүл мэндийн ажилтнуудад учруулах дарамтыг нэмэгдүүлжээ.¹⁵⁷ Грекийн нэг эмнэлгийн ажилтан Эмнести Интернэшнлд “Эрүүл мэндийн салбарт санхүүгийн хямрал гарсан үед ихэнх эмнэлгүүд шаардлагатай боловсон хүчний тал хувьтай ажилладаг байсан ба ... [Бид] бүгдээрээ хамгаалагдаж чадаагүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, ажилтнуудын аюулгүй байдал зэрэгт хамгаалалт байдаггүй.

¹⁵² M Schdferhoff et al, “Дэлхийн эрүүл мэндийн санхүүжилтийн чиг хандлага”, *BMJ* 2019; 365:l2185, <https://www.bmj.com/content/365/bmj.l2185>

¹⁵³ Эмчтэй хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 29 [утсаар]

¹⁵⁴ Сувилагчтай хийсэн ярилцлага, 2020 оны 5 сарын 27 [утсаар]

¹⁵⁵ HRW, “Венесуэл улс: Ковид-19-тэй тэмцэхэд яаралтай тусламж шаардлагатай байна”, <https://www.hrw.org/news/2020/05/26/venezuela-urgent-aid-needed-combat-covid-19>; Үүнийг бас үзнэ үү: <https://sfo2.digitaloceanspaces.com/estaticos/var/www/html/wp-content/uploads/2020/03/ENCUESTA-MUV-COVID-19.pdf>

¹⁵⁶ Үүнийг үзнэ үү. Эмнести Интернэшнл, Сэхээн амьдруулах шаардлагатай: Хэмнэлтийн арван жилийн дараах Грекийн Эрүүл мэндийн тогтолцоо, (Index: EUR 25/2176/2020); Эмнести Интернэшнл, Буруу замнал: Испанийн хэмнэлтийн арга хэмжээ эрүүл байх эрхэд нөлөөлсөн нь, (Index: EUR 41/8136/2018)

¹⁵⁷ Эмнести Интернэшнл, Сэхээн амьдруулах шаардлагатай: Грекийн эрүүл мэндийн тогтолцоо хэмнэлтийн арван жилийн дараа, (Индекс: EUR 25/2176/2020)

[Манай эмнэлэгт] шаардлагатай ажилтнуудын тэн хагас нь л ажилладаг бөгөөд хэрэв [КОВИД-19] тохиолдол нэмэгдвэл бид ямар ч боломжгүй болно”¹⁵⁸ гэж өгүүлжээ. Үүнтэй адилаар, **Испанийн** эрүүл мэндийн ажилтан хэлэхдээ “Манайд боловсон хүчин хангалтгүй байна. Үүнээс ч дор юм нь Испани шиг ийм орны хувьд, хангалтгүй нөөц, танагдаж буй төсөв юм. Цар тахлын үеийн нөхцөл байдал ийм л байна”¹⁵⁹ хэмээн өгүүлсэн байна.

Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Хорооны хэлснээр, “2007-2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас эхлэн “нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад нийгмийн хөтөлбөрүүдэд хийх хөрөнгө оруулалт буурснаар эрүүл мэндийн систем, нийгмийн хөтөлбөрүүд хэдэн арван жилийн турш суларсан. Тиймээс тэд одоогийн цар тахлын эрчимтэй тархалтыг даван туулахын тулд үр дүнтэй хариу арга хэмжээг шуурхай авахад бэлэн бус байгаа юм.”¹⁶⁰ КОВИД-19 цар тахлаас сэргэх төлөвлөгөө нь аюулгүй байдал, хүний эрхийг зохих ёсоор харгалзалгүйгээр хэмнэлтийн арга хэмжээнд үндэслэхгүй байх нь маш чухал юм.

Цаашилбал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хувийн хэвшлийн үүрэг улам бүр нэмэгдсээр байна. НҮБ-ын ядуурал, хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн хэлснээр, олон нийгэмд улсын өмчийг өргөнөөр хувьчилсан нь хүний эрхийн хамгаалалтыг сулруулж, ядуу амьдарч буй иргэдийг улам бүр эмзэг болгоход хүргэж байна.¹⁶¹ Улс орнууд хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллахаар төлөвлөхдөө эмзэг бүлгүүдийн тусгайлсан хэрэгцээг анхааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй, боломжтой байлгах тогтолцоог бий болгох, хүний эрхийн нөлөөллийн талаархи мэдээллийг цуглуулж, нийтлэхийг баталгаажуулахын тулд хувьчлалд оролцсон төрийн болон хувийн оролцогчдод стандарт тогтоох гэх мэтээр тэднийг хүний эрхийн асуудлаар үүрэгжүүлэн ажиллуулах ёстой.¹⁶²

ЦАР ТАХЛЫН БЭЛЭН БУС БАЙДАЛ

Зарим улс орнууд цар тахлын эхэн үед хангалттай бэлтгэхгүй байна гэдэг болгоомжлол эрүүл мэндийн зарим ажилтнуудын дунд байсан. Жишээлбэл, **Суданы** нэгэн эмч бусад асуудлуудаас гадна, цар тахал гарахаас өмнө эрүүл мэндийн ажилтнууд халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих талаар сургалтанд хамрагдаагүй тул тахлын үед өөрсдийгөө хамгаалах чадвар сул гэдгээ Эмнести Интернэшнлд тайлбарлав.”

Эрүүл мэндийн яамнаас цөөн тооны эрүүл мэндийн ажилтнуудад халдвараас урьдчилан сэргийлэх, хянах сургалтыг зохион байгуулдаг...Цаашилбал, ихэнх эмнэлгүүдэд хүний нөөц дутагдалтай байдаг”¹⁶³ гэж тэр эмэгтэй хэлэв. Яагаад бид шөнөжингөө ажиллаж КОВИД-19-ийн халдвартай өвчтөнг эмнэлэгт эрэмбэлэж байна вэ...? КОВИД-19 цар тахлын дэгдэлт гарснаас хойш гурван сарын хугацаа өнгөрөөд байхад засгийн газар яагаад биднийг зохих сургалтад хамруулаагүй вэ? ” гэж **Египетийн** өөр нэг эмч хэлэв.¹⁶⁴

КОВИД-19-ийн тохиолдол хараахан гараагүй байсан эмнэлэгт ажилладаг **Аргентин** улсын нэгэн эмчтэй Эмнести Интернэшнл ярилцсан. Ярилцлагын үеэр энэ эмнэлэг байрладаг мужид халдварын 47 батлагдсан тохиолдол гарсан. Ажилтнууд нь КОВИД-19 хямралд хариу арга хэмжээ авахад бэлтгэгдсэн гэж тэр бодож байгаа ч зохих ХХХ-ээр хангагдаагүй байгаадаа санаа зовниж байв. Тэрээр Эмнести Интернэшнлд хэлэхдээ, ихэнх эмч нар халдвар авахаас айж, өөрсдөө ХХХ худалдаж авахад хүрсэн гэжээ.

¹⁵⁸ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Грек улс, 2020 оны 4 сарын 1 [утсан харилцаагаар]

¹⁵⁹ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Мадрид, 2020 оны 4 сарын 14

¹⁶⁰ Committee on Economic, Social and Cultural Rights, Statement on the coronavirus disease (COVID-19) pandemic and economic, social and cultural rights, E/C.12/2020/1, 17 April 2020, <http://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=4slQ6QSmlBEZ FEovLCuW1AVC1NkPsgUedPIF1vPMKXidSV%2fGyVFSAvr6nizxSIX6zd%2bu5KD26NraabijKaWMnkFhhMb4MahybE51%2foU5sQSh6PCbcepqzI0iCYklyq>

¹⁶¹ Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай Илтгэгчийн тайлан, А/73/396, 2018 оны 9 сарын 26, <https://undocs.org/A/73/396>

¹⁶² Нэн ядуурал ба хүний эрхийн асуудлаарх Тусгай Илтгэгчийн тайлан, А/73/396, 2018 оны 9 сарын 26, <https://undocs.org/A/73/396>

¹⁶³ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Судан, Хартоум муж, 2020 оны 5 сарын 7, WhatsApp-аар

¹⁶⁴ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Египет улс, 2020 оны 6 сарын 9 [утсан харилцаагаар]

Эхний хэдэн долоо хоногт эрх баригчид өөрсдөө амны маск хийж өмсөх даавуу өгсөн”.¹⁶⁵ Өмнөх бүлэгт дурьдсан Олон улсын Нийтийн Үйлчилгээний байгууллагаас хийсэн судалгаанд оролцогчдын 33.2% нь холбогдох ажилтнуудад Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаар холбогдох сургалт явуулаагүй гэж тэмдэглэжээ.¹⁶⁶

2020 оны 4-р сард **Их Британийн** нэгэн сувилагч Эмнести Интернэшнлд хэлэхдээ: “Энд ихэнх өдрүүдэд ХХХ-ийн хангамжийн талаарх асуулт л давамгайлж байсан ба тасралтгүй нийлүүлэх баталгаа байхгүй байсан. Одоогийн байдлаар яаралтай тусламжийн тасагт эн тэргүүнд шаардлагатай гэж чухалчилсан хэдий ч манай эмнэлгийн бусад тасгуудад хангалттай хангамж байхгүй байгааг бид мэднэ. Бид хангалттай бэлтгэгдээгүй гэж бодож байна: энэ хямрал 1-р сард эхэлсэн боловч бид зөвхөн 3-р сард л захиалгаа нэмэгдүүлж байлаа”.¹⁶⁷

Эдгээр сэтгэл түгшээсэн асуудлуудыг тайлангийн 2 дахь хэсэгт тусгасан байгаа.¹⁶⁸ Эмнести Интернэшнл тахал өвчнөөс өмнө улс орнуудын бэлэн байдлын түвшинг судалж үзээгүй бөгөөд эдгээрийг удирдамж, шилдэг туршлагатай харьцуулж үзээгүй боловч улс орнууд өөрийн орны эрүүл мэнд, нийгмийн тогтолцоог ийм арга хэмжээнд хэр зэрэг бэлтгэгдсэн байгааг болон юуг сайжруулах, өөрчлөх шаардлагатай байгааг үнэлэх тогтолцоог бий болгох ёстой. Энэхүү цар тахалд улс орнуудын бэлэн байдлыг үнэлэх нь улс орнууд ирээдүйд гарч болох цар тахалд хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх чухал арга зам юм.

ИЛ ТОД БАЙДАЛ БА ХАРИУЦЛАГА

Ил тод байдал, хариуцлагын зарчим маш чухал. Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад цар тахлын талаар мэдээлэл авах, энэ талаар холбогдох шийдвэр гаргахад оролцох, холбогдох мэдээллийг чөлөөтэй хуваалцах боломжтой байх ёстой. Цаашилбал, эрүүл байх эрх нь зөрчигдсөн аливаа хохирогч эрхээ сэргээлгэх шүүхийн болон захиргааны бусад зохих арга хэрэгслээр үр дүнтэй хангагдах эрхтэй.¹⁶⁹ Өмнөх бүлэгт авч үзсэн эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг шийтгэж, хэлмэгдүүлсэн асуудлуудыг ил тод хариуцлагатай шийдвэрлэх, тэдний ажлын нөхцөлийг бэхжүүлэх, эрүүл мэндийн тогтолцоог сайжруулахдаа оролцоо, ил тод байдал, хариуцлагын зарчмуудыг тусгах шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна. Хариуцлагын асуудалд өөр бусад янз бүрийн асуудлаас гадна тахал өвчний хүрээнд төрийн буруутай үйл ажиллагааны талаарх хэргүүдийг хараат бусаар, бодитойгоор мөрдөн шалгах хэрэгцээ ч орно.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТУСЛАМЖ

КОВИД-19 цар тахал нь бүх улс орнууд хамтран ажиллаж, олон улсын хамтын ажиллагаа, тусламж үзүүлэх үүргээ биелүүлснээр хүний эрхийг дэлхий даяар бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг тод томруунаар харуулав. Дэлхий нийтээрээ хамтын шийдэл шаардсан дэлхий нийтийн тулгамдсан асуудалтай тулгараад байгаа бөгөөд дэлхийн зарим улс орнууд бусад орны тусламжгүйгээр цар тахлын дэгдэлтийн эрүүл мэнд, нийгмийн үр дагаврын эсрэг хариу арга хэмжээ авах нөөц чадавхгүй байна. Зарим **улс орнууд бусад орнуудад материал бусад нөөцөөр хангахын төлөө боломжоороо ажиллаж байгаа бол зарим нь энэ үүргээсээ ухарч байна.** Жишээлбэл, АНУ ДЭМБ-ын хооронд үүссэн асуудал шиг улс орнууд

¹⁶⁵ Тукуман мужийн эмчтэй хийсэн ярилцлага, Аргентин улс, 5 сарын 22, 2020. Аргентин улсад халдвар тархаснаас хойш ХХХ болон түүний хомсдолын талаар санаа зовоосон өргөн хүрээний асуудлууд үүссэн, эндээс үзнэ үү: “Коронавирус: «Хэрэв бид халдвар авсан бол өвчтөнүүдийг хэн анхаарч халамжлах вэ?», Хангамж материал хомс байгаа тухай эмч нарын гомдол санал”, La Nacion, 23 April 2020, <https://www.lanacion.com.ar/sociedad/coronavirus-miedo-contagiarse-enfermeros-medicos-denuncian-falta-nid2355345>; “Аргентин дахь Коронавирус: хоёр видеон дээр эмч нар хамгаалалтын иж бүрдэл найдваргүй болох талаар анхааруулж байна”, Infobae, 4 сарын 24 2020, <https://www.infobae.com/coronavirus/2020/04/24/coronavirus-en-argentina-dos-videos-alertan-sobre-la-precariedad-de-los-kits-de-proteccion-para-los-medicos/>

¹⁶⁶ PSI, КОВИД-19 Холбооны хариу арга хэмжээний судалгаа, Дэлхийн тойм, 5 сарын 11, 2020, https://pop-umbrella.s3.amazonaws.com/uploads/3abcd99c-219b-4b9e-af1e-fa3ac2c398b7_COVIDSurvey_GlobalSummaryIntro.pdf?key=

¹⁶⁷ Эмнэлгийн ажилтантай хийсэн ярилцлага, Англи улс, 4 сарын 13, 2020 [утсан харилцаагаар]

¹⁶⁸ Жишээ үзнэ үү: P Chetterje, “КОВИД-19-цар тахлын тархалтыг хянахад Энэтхэг улсын бэлэн байдалд гарсан дутагдал”, The Lancet, 20 (5), 2020, [https://www.thelancet.com/journals/lanpub/article/PIIS1473-3099\(20\)30300-5/fulltext](https://www.thelancet.com/journals/lanpub/article/PIIS1473-3099(20)30300-5/fulltext); M Gilbert et al, “КОВИД-19-ийг импортлогдон орж ирэхээс хамгаалах Африкийн орнуудын бэлэн байдал ба эмзэг байдал:загварчилсан судалгаа”, The Lancet, 395 (10227), 2020, [https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)30411-6/fulltext](https://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)30411-6/fulltext)

¹⁶⁹ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №14: Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх, E/C.12/2000/4, 8 сарын 11, 2000, §40

хямралд хариу үйлдэл үзүүлэх олон талт байгууллагуудын дэмжлэгийг авахаас татгалзах нь цар тахлын эсрэг олон улсын хариу арга хэмжээг сулруулах эрсдэлтэй. Үүний нэгэн адил, ХХХ худалдан авахын эсрэг худалдааны хориг арга хэмжээ авах нь (өмнөх бүлэгт тайлбарласан болно) зарим улс орнуудын эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг хамгаалах чадварыг алдагдуулж байна.

Олон улстай хамтран ажиллах, тусламж үзүүлэх үүрэг хүлээсний хувьд КОВИД-19 цар тахлын үед ч мөн хүмүүсийн эрх болон эрүүл мэндийг хамгаалж байгаа ажилтнуудад шаардлагатай санхүүгийн тусламжийг нөөц бүхий улс орнууд үзүүлэхийг шаардаж байна.¹⁷⁰ Улс орнуудын өмнө КОВИД-19 цар тахлыг дэлхийн хэмжээний гамшиг гэж үзэж эмчлэх нэн яаралтай шаардлага тулгарч байгаа ба шаардлагатай тохиолдолд санхүүгийн туслалцаа үзүүлэх зорилгоор хамтран ажиллах, вирусийн эсрэг хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаархи сайн туршлагын талаарх мэдээлэл, вирусийн тухай шинжлэх ухааны мэдээлэл, эмнэлгийн тоног төхөөрөмж болон ХХХ-ийг дотооддоо үйлдвэрлэх талаарх техникийн мэдээллээ хуваалцах болон вакцин бэлэн болмогц дэлхий даяарх бүх хүн вакцинд тэгш хамрагдах боломжийг баталгаажуулах шаардлагатай байна.



¹⁷⁰ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №14: Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх, Е/С.12/2000/4, 8 сарын 11, 2000, §4

8. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ БА ХЭМ ХЭМЖЭЭ

«Ажилтнууд бол хэрэглээний материал биш. Улсын эсвэл бизнесийн салбарт ажилладгаас үл хамааран ажилтан бүр чухал. Ажилтан бүр коронавирус гэх мэт ажлын байранд үүсч болзошгүй аюулт нөлөөллөөс хамгаалагдах эрхтэй... Өнөөдрийн бидний мессеж энгийн боловч маш чухал: Ажилтан бүр хамгаалагдсан байх ёстой.»

Тусгай илтгэгчийн мэдэгдэл¹⁷¹



Африкийн Зимбабве дахь жуулчны газруудын нэгэнд (хүмүүс хамгийн ихээр очдог) Коронавирусийн анхны тохиолдол илэрснийг тус улс зарласны дараа эрүүл мэндийн ажилтнууд Зимбабвегийн Хараре хотын улсын эмнэлэгт үзүүлэхээр очсон мотоциклчид болон бусад хүмүүст тандалт үзлэг хийжээ. Эдийн засгийн хямралын улмаас бараг нуран унаад байсан үндэсний эрүүл мэндийн тогтолцоонд цар тахал дахин заналхийлж эхэллээ. 2020 оны 3-р сарын 20, © Tsvangirayi Mukwazhi/AP/Shutterstock

¹⁷¹ “Ажилтан бүр ямарч нөхцөлгүйгээр КОВИД-19-өөс хамгаалагдсан байх зайлшгүй шаардлагатай.” - НҮБ-ын хүний эрхийн шинжээчид, 2020 оны 5-р сарын 18, <https://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25892&LangID=E>

Хүний эрхийг хянах зарим хороодоос КОВИД-19 цар тахлын хүрээнд хүний эрх зөрчигдөж байгаа асуудлаар мэдэгдлүүд гаргажээ. Мэдэгдлүүдэд эрүүл мэнд болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын хүний эрхийн асуудлуудыг хөндөж тусгасан байна. Тухайлбал, байгаль орчинд ээлтэй менежмент хийх, хорт бодис, хаягдлыг зайлуулахад хүний эрхийн нөлөөллийн асуудлаарх Тусгай шинжээч “Коронавирусийн цар тахлын эсрэг дэлхий нийтийн тэмцлийн тэргүүн шугамд ажиллаж буй зоригтон эмч, сувилагч, яаралтай тусламжийн ажилтнууд болон эмнэлгийн бусад мэргэжилтнүүд бол баатрууд юм” гэж дурджээ. Тэдний шаргуу хөдөлмөр, өөрийгөө үл хайхран зүтгэж байгаа нь хүн төрөлхтний хамгийн сайн сайхны төлөөх үйл хэрэг юм. Тэд хамгаалагдах ёстой ... Гэвч хамгаалалтын хэрэгслийн хомсдол нь коронавирустай тэмцэж буй бараг бүх оронд ноцтой асуудал хэвээр байна”.¹⁷²

“Цар тахлын эсрэг тэргүүн шугамд баатарлагаар ажиллаж буй эрүүл мэндийн ажилтнууд хувийн хамгаалах хэрэгсэл, хувцас хангалтгүй, эсвэл хомсдолтой байгаагийн улмаас халдвар авч байна ... Энэхүү хямралд хариу арга хэмжээ авч тэргүүн шугамд ажиллаж байгаа бүх эрүүл мэндийн ажилтнууд халдвар авахаас хамгаалагдаж зохих хувцас, хэрэгслээр хангагдсан байх ёстой. Түүнчлэн шийдвэр гаргагчид тэдэнтэй зөвлөлдөх, тэдний зөвлөгөөг анхаарч үзэх нь нэн чухал юм. Эрүүл мэндийн ажилтнууд КОВИД-19 цар тахлын болзошгүй дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчилгээний үр дүнтэй арга хэмжээ авахад чухал үүрэг гүйцэтгэнэ.” гэж ЭЗНСЭ-ийн Хороо хэлсэн байна.¹⁷³ Үүний адилаар Европын Нийгмийн эрхийн Хорооноос “Эрүүл мэндийн салбарын хангалттай тооны мэргэжилтнүүдийг авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл эрүүл, аюулгүй байх боломжтой бүх арга хэмжээг авах ёстой. (Дүрмийн 3-р зүйлийг үзнэ үү) Үүнд шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр хангах асуудал ч хамаарна” гэж мэдэгдсэн¹⁷⁴ Африкийн Хүний Эрхийн Комиссын Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Ажлын хэсэг улс орнуудад хандан “тэргүүн шугамд ажиллаж байгаа эрүүл мэндийн бүх ажилтныг халдвараас хамгаалж, хангалттай цалин хөдсгийг цаг хугацаанд нь олгож байх ёстой”¹⁷⁵ Үүний адилаар, Хүний эрхийн Америк хоорондын Комисс, Эдийн засаг, нийгэм, соёл, хүрээлэн буй орчны эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч “Улс орнууд цар тахлын үед эрүүл мэндийн ажилтнуудын бүрэн энх мэнд байдлыг эн тэргүүнд эрхэмлэх ёстой бөгөөд үүнийг үндсэнүүрэг гэж үзэх ёстой” мөн хүмүүнлэгийн тусламжийг сайн дураар хийж байгаа хүмүүсийг хамгаалах, хүлээн зөвшөөрөх талаар тодорхой арга хэмжээ авах, “эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах, сургах, үүнд тусгай хувцас, халдваргүйжүүлэх хэрэгслээр хангах, тэдний хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрхийг зохих ёсоор баталгаажуулж өгөх нь онцгой ач холбогдолтой болохыг цохон тэмдэглэв.”¹⁷⁶

Энэ бүлэгт КОВИД-19-ийн хүрээнд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын хүний эрхийг хамгаалах талаар, тухайлбал эрүүл байх эрх; хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангуулах эрх; үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар цугларах эрх; ялгаварлан гадуурхал болон хүчирхийллээс ангид байх эрх; эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг хангах талаарх улс орнуудын хүлээх үүргийг нарийвчлан тусгасан болно.



¹⁷² ХЭДКГ, КОВИД-19: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний баатруудад хамгаалалт хэрэгтэй байна - НҮБ-ын шинжээч, 2020 оны 3-р сарын 27, <https://www.ohchr.org/en/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=25754&LangID=E>

¹⁷³ Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо, Коронавирусийн өвчний талаарх мэдэгдэл (КОВИД-19) цар тахлын болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай мэдэгдэл, E / C.12 / 2020/1, 2020 оны 4-р сарын 17, <http://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=4slQ6QSmIBEDzFEovLCuW1AVC1nkPsgUedPIF1vfPMKXidSV%2fGyVFSAvr6nizxSlX6zd%bu5KD26NraabijKaWmMnkFhhMb4MahybE51%2foU5sQSh6PCbcepqzI0iCYklyq>

¹⁷⁴ Европын Нийгмийн эрхийн Хороо, Цар тахлын үед эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг тайлбарласан мэдэгдэл, 4-р сарын 21, 2020 он, <https://rm.coe.int/statement-of-interpretation-on-the-right-to-protection-of-health-in-ti/16809e3640>

¹⁷⁵ Африкийн Хүний, Хүний эрхийн Комисс, 2020 оны 6-р сарын 4-ний өдөр Африк дахь эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд КОВИД-19 тахал өвчний нөлөөллийн талаархи хэвлэлийн мэдээ. 6 сарын 4, 2020 он, <https://www.achpr.org/pressrelease/detail?id=510>

¹⁷⁶ Америк хоорондын Комисс Хүний эрхийн, Эдийн засаг, нийгэм, соёл, хүрээлэн буй орчны эрхийн Тусгай илтгэгчийн Газраас КОВИД-19 цар тахлын үеэр хүний эрх, олон нийтийн эрүүл мэндийг цогцоор нь хамгаалахыг улс орнуудаас уриалсан 2020 оны 3-р сарын 20, http://www.oas.org/en/iachr/media_center/PReleases/2020/060.asp

8.1 ЭРҮҮЛ БАЙХ ЭРХ

Олон улсын хүний эрхийн хэд хэдэн гэрээгээр эрүүл байх эрхийг хамгаалсан байдаг.¹⁷⁷ ЭЗНСЭОУП-ын 12-р зүйлд заасны дагуу: “(1) Энэхүү гэрээнд Оролцогч улсууд хүн бүрийн бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийн хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрхийг хүлээн зөвшөөрөх. (2) Энэхүү гэрээнд Оролцогч улсууд энэхүү эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах алхмуудыг авч хэрэгжүүлэх: ... (с) Эпидемик, эндемик, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хянах.” Энэхүү эрхийн бүрэлдэхүүн хэсгүүдийг ЭЗНСЭ-ийн Хорооны Ерөнхий Зөвлөмж №14-д нарийвчлан тусгасан болно. Ерөнхий Зөвлөмжийн 12-р зүйлд “үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” болон “хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн нөхцөл” зэргийг багтаан “Байгалийн болон ажлын байрны эрүүл орчноор хангагдах эрх”-ийг хамгаалсан.¹⁷⁸ Мөн түүнчлэн Ерөнхий Зөвлөмжид “Оролцогч улсууд байгаль орчны болон хөдөлмөрийн эрүүл мэндэд учирч болзошгүй хор хохирлын эсрэг арга хэмжээ болон цар тахалтай адил өөр бусад өвчлөлийн эсрэг арга хэмжээнүүдийг батлах шаардлагатай... Оролцогч улсууд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн эрсдэлийг бууруулах үндэсний бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, үе шаттай шалгах, мөн түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төгс үйлчилгээг үндэсний бодлогоор уялдуулан зохицуулах шаардлагатай” гэж цохон тэмдэглэсэн байна.¹⁷⁹ Энэ нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажлын нөхцөлд хамаарна.

8.2 ХӨДӨЛМӨРИЙН ШУДАРГА, ТААТАЙ НӨХЦӨЛӨӨР ХАНГУУЛАХ НЬ ХҮН БҮРИЙН ЭРХ

ЭЗНСЭОУП-ын 7-р зүйлд заасны дагуу “Энэхүү гэрээнд Оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайлбал: (a) (i) цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт адил тэгш цалин хөлс олгох ... (b) аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцөлийг бүрдүүлэх ... (d) амрах, зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгээр эдлүүлэх эрхүүд хамаарна”. ЭЗНСЭ-ийн Хорооны Ерөнхий Зөвлөмж №23-т энэ эрхийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн болно.¹⁸⁰

- Бүх ажилчид шударга цалин хөлс авах эрхтэй. Ерөнхий Зөвлөмж №23-ийн дагуу “Шударга цалин хөлс гэсэн ойлголт нь тухайн ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд тухайн ажлын нөлөөлөх нөлөөлөл, ажлын онцлогоос хамааралтай үүсэх бэрхшээлүүд, мөн ажилчдын хувийн болон гэр бүлийн амьдралд үзүүлэх нөлөө гэх мэт өргөн цар хүрээг хамарсан объектив шалгуур үзүүлэлтээс хамаардаг тул статистик биш юм”.¹⁸¹
- Мэргэжлээс шалтгаалах осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нь хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлийг бүрдүүлэх эрхийн үндсэн хэсэг юм. Ерөнхий Зөвлөмж №23-т заасны дагуу улс орнууд “хөдөлмөрийн орчин дахь аюулыг багасгах замаар осол аваар, эрүүл мэндэд учрах гэмтэлээс урьдчилан сэргийлэх үндэсний бодлогыг хэрэгжүүлэх ёстой”.¹⁸² Урьдчилан

¹⁷⁷ ЭЗНСЭОУП болон ЭЗНСЭОУП-ын Нэмэлт Протокол; Эмгэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийн устгах тухай олон улсын Конвенц; Арьс өнгөөр Алагчлах Бүх Хэлбэрийн устгах тухай олон улсын Конвенц; Хүүхдийн эрхийн тухай Конвенц.; болон Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний эрхийн тухай Конвенц зэрэг орно.

¹⁷⁸ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж №14: Эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрх, E/C.12/2000/4, 8-р сарын 11, 2000 он, §15

¹⁷⁹ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж №14: Эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрх, E/C.12/2000/4, 8-р сарын 11, 2000 он, §36

¹⁸⁰ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж №23Хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрх, E/C.12/GC/23, 3-р сарын 4, 2016 он

¹⁸¹ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж №23Хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрх, E/C.12/GC/23, 3-р сарын 4, 2016 он, §10

¹⁸² ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж №23Хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрх, E/C.12/GC/23, 3-р сарын 4, 2016 он, §25

сэргийлж болох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртсөн ажилтнууд учирсан хохирлоо арилгуулах эрхтэй бөгөөд “осол, өвчинд нэрвэгдсэн ажилтнууд, тэдний хамааралтай хүмүүс эмчилгээний зардал, орлогын алдагдалдаа зохих нөхөн олговор болон бусад зардал, нөхөн сэргээх үйлчилгээ авах ёстой”.¹⁸³ Ажилтнууд аливаа дарамтаас айхгүйгээр хөдөлмөрийн нөхцлөө хянах боломжтой байх ёстой.¹⁸⁴ Өвчтэй ажилчдад цочмог болон архаг өвчнийг эмчлэх, хамтран ажиллагсдынхаа халдвар авах эрсдэлийг бууруулахад өвчний цалинтай чөлөө олгох нь нэн чухал юм.¹⁸⁵

- Ерөнхий Зөвлөмжийн дагуу өдөр тутмын ажлын цагийг найман цагаар хязгаарлах ёстой¹⁸⁶ ба долоо хоногт ажиллах цагийн тоог мөн хууль тогтоомжоор хязгаарлах ёстой.¹⁸⁷ Ил Хязгаарлалтад үл хамаарах зүйлүүдийг хатуу тогтоож өгөх хэрэгтэй ба үүнийг ажилчид болон тэдний төлөөллийн байгууллагатай зөвлөлдөх шаардлагатай. Хууль тогтоомжоор өдөр тутмын болон долоо хоногийн амралтын хугацааг тодорхойлох ёстой.¹⁸⁸

Эдгээр заалт нь албан бус салбарт ажилладаг эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлд ч хамаарах ёстой.¹⁸⁹ Оролцогч улсууд хувийн хэвшлийн ажил олгогчид гэх мэт гуравдагч этгээдүүд хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангуулах эрхээ эдлэхэд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба олон улсын хөдөлмөрийн эрүүл мэндийн стандартыг хүндэтгэх нь зүйтэй.¹⁹⁰

КОВИД-19 цар тахлын үед ЭЗНСЭ-ийн хорооноос “Ажилтан бүр ажил дээрээ халдвар авах эрсдэлээс хамгаалагдсан байх ёстой. Оролцогч улс, ажил олгогчид халдварын эрсдлийг багасгах нөхцөлийг бүрдүүлэх холбогдох зохицуулалтын арга хэмжээг баталсан байх хэрэгтэй. Ийм арга хэмжээ авах хүртэл ажилтан хөдөлмөрлөх боломжгүй бөгөөд зохих хамгаалалтгүйгээр ажиллахаас татгалзсан тохиолдолд сахилгын болон бусад шийтгэлээс хамгаалагдсан байх ёстой.” гэж цохон тэмдэглэсэн.¹⁹¹

ОУХБ-ын хэд хэдэн конвенцүүдэд хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийг хамгаалан баталгаажуулсан байдаг ба үүний зарим нь эрүүл мэндийн ажилтнуудад тусгайлан зориулагдсан байдаг. Үүнд:

Хөдөлмөрийн Аюулгүй байдал, Эрүүл мэндийн тухай Конвенц, 1981 (No. 155):¹⁹²

Энэхүү конвенц нь ЭЗНСЭ-ийн Хорооны Ерөнхий Зөвлөмж 23-т дурдсантай төстэй хэд хэдэн хамгаалалтыг агуулдаг. Үүнд, Гишүүн орнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл мэнд, хөдөлмөрлөх орчны талаар үндэсний цогц бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, үе шаттай шалгаж байхыг шаарддаг. 13 дугаар зүйлд зааснаар “Амьдрал, эрүүл мэндэд нь гэнэтийн болон ноцтой аюул заналхийлж байна гэж үзэх үндэслэл бүхий ажлын нөхцөл байдлаас болж өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажилтан нь үндэсний нөхцөл байдал, практикийн дагуу зохисгүй үр дагавраас хамгаалагдах ёстой.” Цаашилбал, 16 (3) -д “Ажил олгогч осол эндэгдэл гарахаас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд шаардлагатай тохиолдолд зохих хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах ёстой”.

¹⁸³ ЭЗНСЭ-ийн Хороо, хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангуулах эрхийн талаарх Ерөнхий Зөвлөмж №23, Е/С.12/ГС/23, 3-р сарын 4, 2016 он, §29,

¹⁸⁴ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №23-ын §26,

¹⁸⁵ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №23-ын §30,

¹⁸⁶ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №23-ын §35,

¹⁸⁷ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №23-ын §37,

¹⁸⁸ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №23-ын §38 ба 39,

¹⁸⁹ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №23-ын §5,

¹⁹⁰ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №23-ын §59,

¹⁹¹ ЭЗНСЭ-ийн Хороо, КОВИД-19 тахал өвчлөл ба эдийн засаг, нийгэм ба соёлын эрхийн талаарх мэдэгдэл, Е/С.12/2020/1, 2020 оны 4-р сарын 17, §16, <http://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=4slQ6QSmIBEDzFEovLCuW1AVC1nkPsgUedPIF1vfPMKXidSV%2fGyVFSAvr6nizxSlX6zd%2bu5KD26NraabiKaWmMnkFhhMb4MahybE5l%2foU5sQSh6PCbcepqzI0iCYklyq>

¹⁹² Энэхүү конвенцийг 69 улс соёрхон баталжээ; текстийг эндээс үзнэ үү: https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:11300:0::NO:113 00:P11300_INSTRUMENT_ID:312300

1981 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн зөвлөмж нь эдгээр үүрэгт хамаарах зүйлүүдийг нарийвчлан тусгасан болно. 3-р зүйлд “хувийн хамгаалалтын хэрэгсэл, хамгаалалтын хувцас зохион бүтээх, үйлдвэрлэх, нийлүүлэх, ашиглах, засвар үйлчилгээ, туршилт хийх”, “ажлын нөхцөл байдлаас шалтгаалан бие махбодийн болон сэтгэцийн стрессээс урьдчилан сэргийлэх”, “эрүүл мэндэд хяналт тавих” арга хэмжээ авахыг зөвлөсөн байна.¹⁹³ 10-р зүйлд ажил олгогчдын үүрэг хариуцлагад “ажилтнуудад ямар нэгэн зардал гаралгүйгээр аюулыг урьдчилан сэргийлэх, хянах боломжгүй тохиолдолд шаардлагатай хувийн хамгаалалтын хувцас, багаж хэрэгслийг өгөх” болон “ажлын зохион байгуулалт нь ялангуяа ажлын болон амралтын цагийн хуваарь нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй байхаар зохион байгуулах” зэргийг багтаасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн ослын тэтгэмжийн тухай Конвенц, 1964 (No. 121):¹⁹⁴

Хөдөлмөр Эрхлэлтийн (Үйлдвэрлэлийн) Ослын Тэтгэмжийн тухай Конвенцид Оролцогч улсуудаас “үйлдвэрлэлийн осол”, “мэргэжлээс шалтгаалсан өвчин” гэсэн тодорхойлолтыг гаргаж, ямар өвчнүүдийг хамааруулан авч үзэх жагсаалт гаргахыг шаарддаг. “Ажлын таагүй нөхцөл байдлаас шалтгаалан хөдөлмөрийн чадваргүй болох, орлого нь тасалдах, орлого олох чадвараа бүрмөсөн эсвэл хэсэгчилэн алдах, эсвэл тодорхой чадвараа бүрмөсөн алдах, мөн уг нөхцөл байдлаас шалтгаалан тэжээгч нь нас барсан тохиолдолд” тогтоосон хэмжээний нөхөн төлбөр, эмнэлгийн тусламж, оршуулгын тэтгэмж зэрэг олон төрлийн тэтгэмж авах боломжтой. 1964 оны Хөдөлмөр Эрхлэлтийн (Үйлдвэрлэлийн) Ослын Тэтгэмжийн тухай Зөвлөмжийн 6-р зүйлийн дагуу “ажилчин (а) ядаж тодорхой хугацаанд энэхүү нөхцөл байдалд ажиллаж байсан бол (б) хамгийн сүүлийн хөдөлмөр эрхлэлтийг цуцалснаас хойш тодорхой хугацаанд өвчний шинж тэмдэг илэрсэн бол тухайн өвчин мэргэжлээс гаралтай гэсэн таамаглал байх ёстой”. ДЭМБ-аас ажил олгогчид нь эрүүл мэндийн ажилтнуудын нөхөн төлбөр авах, нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээнд хамрагдах эрхийг хүндэтгэх ёстой ба ажлын байрандаа КОВИД-19-ийн халдвар авсан тохиолдолд “мэргэжлийн нөлөөллөөс үүссэн мэргэжлээс шалтгаалах өвчин гэж авч үзэх ёстой” гэж мэдэгдсэн байна.¹⁹⁵

Сувилахуйн ажилтнуудын тухай Конвенц, 1977 (No. 149):¹⁹⁶

Энэхүү конвенц нь «асрамжийн болон сувилахуйн үйлчилгээ эрхэлдэг бүх хүнд хамааралтай бөгөөд түүнээс гадна «сувилахуйн ажилтнууд нь дор хаяж бусад ажилтны нөхцөлтэй дүйцэхүйц нөхцөлийг, тухайлбал: ажлын цагийн зохицуулалт ба нөхөн олговор (илүү цагаар ажиллуулах, ээлжийн цаг ба ээлжийн ажлын үеийн г.м багтаасан); долоо хоногийн амралт; ээлжийн амралт; сургалтын чөлөө; жирэмсний амралт; өвчний чөлөө; ба нийгмийн хамгаалал зэрэг нөхцөлийг адил эдэлнэ.» гэж заажээ. Түүнчлэн Улс орнуудаас хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар мөрдөгдөж буй хууль, тогтоомжийг асрамжийн ажлын онцлог шинж чанар, түүнийг явуулж буй орчин, нөхцөл байдалд нийцүүлэн сайжруулахад хүчин чармайлт гаргахыг уриалдаг.



¹⁹³ Хөдөлмөрийн Аюулгүй байдал, Эрүүл мэндийн Зөвлөмж, 1981 (No. 164), текстийг эндээс үзнэ үү: https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:R164

¹⁹⁴ Конвенцийг 24 орон соёрхон баталсан; текстийг эндээс үзнэ үү - https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:11300:0::NO:11300:P11300_INSTRUMENT_ID:312266

¹⁹⁵ ДЭБ, Коронавирусийн өвчин (COVID-19) дэгдэлт: Эрүүл мэндийн ажилтнуудын эрх, үүрэг, хариуцлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаархи гол ойлголтуыг багтаасан түр Удирдамж, 2020 оны 3-р сарын 18, [https://www.who.int/publications-detail/coronavirus-disease-\(covid-19\)-outbreak-rights-roles-and-responsibilities-of-health-workers-including-key-considerations-for-occupational-safety-and-health](https://www.who.int/publications-detail/coronavirus-disease-(covid-19)-outbreak-rights-roles-and-responsibilities-of-health-workers-including-key-considerations-for-occupational-safety-and-health)

¹⁹⁶ Конвенцийг 41 орон соёрхон баталсан; эндээс үзнэ үү - https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:11300:0::NO:11300:P11300_INSTRUMENT_ID:312294

8.3 ДОРМЖЛОЛ, ЯЛГАВАРЛАЛ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨХӨӨС ХАМГААЛАХ

Хүний эрхийн талаархи олон улсын гэрээнүүдэд тэгш эрх, үл ялгаварлагдах эрхийг баталгаажуулсан байдаг.¹⁹⁷ Улс орнууд үл ялгаварлагдах эрхийг нэн даруй бусад эрхийн хамтад нь хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд олон улсын эрх зүйгээр баталгаажсан бусад бүх эрхийг хэрэгжүүлэхэд чухал хамаатай. ЭЗНСЭ-ийн Хорооноос Оролцогч улсууд ялгаварлан гадуурхах бодит шалтгаан болсон нөхцөл байдал, хандлагаас урьдчилан сэргийлэх, багасгах, арилгах арга хэмжээг ямарч нөхцөлгүйгээр нэн даруй авах ёстой» гэжээ.¹⁹⁸ ЭЗНСЭ-ийн Хороо Оролцогч улсууд “хувийн салбар дах хувь хүн, аж ахуйн нэгжийг ялгаварлан гадуурхахгүй байхыг баталгаажуулсан хууль тогтоомжийг батлах зэрэг арга хэмжээ авах ёстой” гэдгийг тэмдэглэсэн.¹⁹⁹

8.4 ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

ИУТЭОУП-ын 19-р зүйлд заасны дагуу, хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг эрж хайх, хүлээж авах, түгээх эрх чөлөө багтана”.²⁰⁰ Энэ эрхийг үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, нийгмийн дэг журам болон эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах шаардлагын үүднээс зарим талаар хязгаарлаж болох боловч энэ хязгаарлалт нь заавал хуулиар тогтоогдсон, зайлшгүй шаардлагын үүднээс, хамгийн бага түвшинд, холбогдох хууль ёсны зорилготойгоор, ялгаварлалгүй үйлчлэх ёстой.²⁰¹ ИУТЭОУП-д баталгаажсан эрхүүдийг хязгаарласан үндэслэлээ улс орнууд хариуцах болно.

Өнөөгийн тохиолдолд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд 19-р зүйлд заасан өөрсдийн хөдөлмөрлөх нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдлынхаа талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй байх эрх нь хязгаарлаж болох эрхийн хатуу шалгуурыг хангаж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Эрүүл мэндэд учирч буй аюулын шинж чанар, түвшин, төрийн байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цаг тухайд нь, ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр хангаж байх нь зайлшгүй чухал юм. Мөн түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн Хорооноос «Энэхүү үүрэг нь Оролцогч улсуудыг хувь хүмүүсийг хувийн байгууллагынхны аливаа үйлдлээс хамгаалахын тулд эдгээр гэрээнд заагдсан эрхүүдийг иргэн, аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэх боломжтой болгож, хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг алдагдуулахгүй байхыг баталгаажуулахыг шаардаж байна” гэж цохон тэмдэглэсэн”.²⁰²

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУД НЬ ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД МӨН

Ихэнх тохиолдолд, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын үндсэн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэнд, мэдээллийн эрхийг хамгаалж байдаг тул тэд мөн хүний эрхийг хамгаалагчид юм. НҮБ-ын Хүний эрх Хамгаалагчдын Тунхаглалд хүний эрхийн төлөө ажиллаж байгаа бүх хүний хүртэх ёстой үндсэн хамгаалалтуудыг тусгасан байдаг.²⁰³ Эдгээр хамгаалалт

¹⁹⁷ Үүнд ЭЗНСЭОУП; ИУТЭОУП, Эмэгтэйчүүдийг Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах тухай Конвенц; Арьс өнгөөр Алагчлах Бүх Хэлбэрийг Устгах тухай Конвенц; Хүүхдийн Эрхийн тухай Конвенц; Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн тухай Конвенц

¹⁹⁸ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №20: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн үл ялгаварлал, E/C.12/GC/20, 2009 оны 7-р сарын 2, § 8(b)

¹⁹⁹ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №20: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн үл ялгаварлал, E/C.12/GC/20, 2009 оны 7-р сарын 2, §11

²⁰⁰ § 19, ИУЭОП

²⁰¹ Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пакт дах эрхүүдийг түдгэлзүүлэх, хязгаарлах талаарх Сиракусагийн Зарчмууд, UN Doc. E/CN.4/1984/4 (1984); ЭЗНСЭ-ийн Хорооны Ерөнхий Зөвлөмж № 14, § 29-д зааснаар аливаа хязгаарлалт нь “... пропорциональ байх ёстой, өөрөөр хэлбэл, хамгийн бага түвшинд хязгаарлалтыг батлах ёстой ... «болон» ... тодорхой хугацаатай байх бөгөөд тэдгээрийг хянах шаардлагатай.» Мөн Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №34-ийг үзнэ үү, CCPR/C/GC/34, 2011 оны 9-р сарын 12.

²⁰² Хүний Эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №34, CCPR/C/GC/34, 2011 оны 9-р сарын 12., §7

²⁰³ Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, хөхүүлэн дэмжих, хамгаалах тухай

нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад ч хамаатай байх ёстой. Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаархи Тусгай илтгэгч нь Улс орнуудад “хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг бий болгох үүднээс хууль тогтоомж, бодлогын хүрээг хуульчид болон иргэний нийгмийн байгууллагатай зөвшилцөн хэрэгжүүлэхийг” мөн “хүний эрх хамгаалагчдын эсрэг заналхийлэл, зөрчлийн талаарх гомдлыг цаг алдалгүй, үр дүнтэй шийдвэрлэх механизмыг боловсруулж, хүчирхийлэгчдийн эсрэг зохих сахилгын, иргэний, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, хариуцлагаас мултрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх”-ийг зөвлөж байна”.²⁰⁴

КОВИД-19 халдварт өвчнийг даван туулахын төлөө тэмцэх, засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээнээс хэнийг ч үлдээхгүйн төлөө тэмцэлд хүний эрхийн хамгаалагчид зайлшгүй чухал үүрэгтэй. Хүний эрхийг хамгаалж байгаа эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд КОВИД-19 цар тахлын бүхий л үе шатанд тулгамдаж байгаа асуудлын талаар олон нийтэд мэдээлэх; засгийн газруудыг тодорхой, ил тод байдлаар хүртээмжтэй, үнэн бодит мэдээллээр хангахыг баталгаажуулах болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хохирол учруулсан, хангалтгүй хэрэгжсэн буюу үл нийцсэн тохиолдолд шүгэл үлээхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үүргийг улс орнууд бүрэн хариуцдаг. Тухайлбал, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах, тэднийг хүний эрхийн ажил үйлстэй нь холбоотойгоор буруутгагдахаас урьдчилан сэргийлэх, буруутгагдсан нөхцөлд хүний эрхийн зөрчлийн хэргүүдийг нухацтай авч үзэх, үр дүнтэй шийдвэрлэх; тэднийг аюулгүй, ая тухтай орчинд ажил үүргээ гүйцэтгэх баталгааг бий болгох үүрэгтэй.²⁰⁵

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУД БОЛ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИД МӨН

Зарим нөхцөл байдалд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд түгшүүрийг өдөөх, хүний эрхэд заналхийлж буй буруу үйлдлийг илчлэх, эсвэл ажлын байрандаа олж авсан мэдээ, мэдээллийг олон нийтийн ашиг сонирхлын үүднээс ил болгох, аюулын дохио өгөх зорилгоор шүгэл үлээж байсан. КОВИД-19 цар тахал дэгдсэнээс хойш эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай мэргэжлийн хэд хэдэн ажилтнууд олон нийтэд зайлшгүй хэлэх ёстой гэдгээ ухамсарлан дотоод сүлжээгээрээ буюу бие даасан байгууллагуудад ажлын байран дахь аюултай нөхцөл байдлын талаар, эсвэл КОВИД-19 цар тахлын эсрэг засгийн газрын хариу арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлсэн байна.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн дагуу улс орнууд аливаа буруутай үйл ажиллагааны талаар мэдээлснийхээ төлөө шийтгэгдэж болзошгүй шүгэл үлээгчдийг хамгаалах үүрэгтэй бөгөөд шүгэл үлээгч нь холбогдох мэдээллийг найдвартай, айдасгүйгээр ил тод болгох боломж олгох механизмыг бий болгох үүрэгтэй.²⁰⁶ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хөхүүлэн дэмжих, хамгаалах асуудлаарх Тусгай Илтгэгч хэлэхдээ, улс орнуудын хууль тогтоомжууд нь ... “өөрийн олж мэдсэн мэдээллийг тодорхой үндэслэл шалтгааны үндсэн дээр үнэн гэж итгэж, олон нийтийн тодорхой ашиг сонирхолд аюул, хор хохирол учруулж болзошгүй гэж үзэн мэдээллийг нээлттэй болгосон хэнийг ч болов хамгаалах ёстой... Мэдээллийг ил болгомогч эрх мэдэлтнүүд буруутай эсэхийг шалгаж залруулах ёстой”. Түүнчлэн, Тусгай илтгэгч хэлэхдээ, “буруутгагдахаас хамгаалагдах хариу арга хэмжээг бүх төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх ёстой ... Шүгэл үлээгчдийг хэлмэгдүүлэх болон бусад халдлага, нууц эх сурвалжийг задлах үйлдлүүдийг нарийвчлан шалгаж, эдгээр хүмүүст хариуцлага хүлээлгэх ёстой”.²⁰⁷

хувь хүн, бүлэг, нийгмийн байгууллагын эрх, үүргийн Тунхаглал, А/RES/53/144, 1999 оны 3-р сарын 8, <https://www.ohchr.org/Documents/Issues/Defenders/Declaration/declaration.pdf>

²⁰⁴ Хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын асуудлаарх Тусгай Илтгэгчийн Тайлан, А/HRC/31/55, 2016 оны 2-р сарын 1, https://www.ohchr.org/Documents/Issues/Defenders/A-HRC-31-55_en.pdf

²⁰⁵ Бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, хөхүүлэн дэмжих, хамгаалах тухай хувь хүн, бүлэг, нийгмийн байгууллагын эрх, үүргийн Тунхаглал, А/RES/53/144, 1999 оны 3-р сарын 8, Art. 2.

²⁰⁶ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих асуудлаарх Тусгай Илтгэгчийн Тайлан, А/70/361, 2015 оны 9 сарын 8, https://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/70/361. Тусгай илтгэгчийн бичсэнээр, шүгэл үлээгч гэдэг нь “тухайн үйл явдлыг олж илрүүлэхдээ энэ нь үндэсний болон олон улсын хууль тогтоомжийг зөрчсөн, эрх мэдлээ урвуулан ашигласан, хог хаягдал үүсгэсэн, залилан мэхлэсэн, эсвэл хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон нийгмийн аюулгүй байдалд хор хохирол учруулсан гэх мэт нийтийн эрх ашигт заналхийлсэн буюу хохирол учруулсан үйлдэл гэж үзэн энэхүү үйл явдлын талаарх мэдээллийг үнэн зөвөөр илчилж, олон нийтэд ил гаргасан хүн юм.”

²⁰⁷ Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих асуудлаарх Тусгай Илтгэгчийн Тайлан,

8.5 ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТУСЛАМЖ

Дэлхийн дийлэнх улс орнууд хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орсон байдаг ба олон улстай хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.²⁰⁸ ЭЗНСЭ-ийн Хорооны Ерөнхий Зөвлөмж 14-т “Зарим халдварт өвчин улс орны хил хязгаараас даван амархан тархах боломжтой тул энэ өвчинтэй тэмцэхэд олон улсын хамтын нийгэмлэг хамтын үүрэг хариуцлага хүлээх ёстой” гэдгийг тодорхой заасан байдаг. Эдийн засгийн хувьд хөгжингүй Оролцогч улсууд энэ тохиолдолд ядуу буурай хөгжиж буй орнуудад туслах тусгай үүрэг хариуцлага, сонирхлыг хүлээдэг”.²⁰⁹ Санхүүгийн тусламжаас гадна, Улс орнууд хүний эрхийн нийтлэг зорилго, хамгаалалтад хүрэх зорилгоор хамтран ажиллах, боломжтой бол мэдээллээ хуваалцах үүрэгтэй. ЭЗНСЭ-ийн Хороо “Энэхүү цар тахал нь үндэстэн дамнасан аюул заналхийлэл тулгарахад шинжлэх ухааны олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй чухал болохын тод жишээ юм. Вирус болон бусад эмгэг төрүүлэгчид хил хязгаарт баригдахгүй... Цар тахалтай тэмцэхэд үндэсний хэмжээний тэмцэл хангалтгүй бөгөөд улс орнуудаас олон улсын хамтын ажиллагааг шаарддаг” гэж мэдэгджээ.²¹⁰



A/70/361, 2015 оны 9 сарын 8, https://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/70/361.

²⁰⁸ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №14: Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх, E/C.12/2000/4, 2000 оны 8-р сарын 11, § 38 ба §45.

²⁰⁹ ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №14: Хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрх, E/C.12/2000/4, 2000 оны 8-р сарын 11, §40; ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №19: Нийгмийн халамж авах эрх, E/C.12/GC/19, 2008 оны 2-р сарын 4, § 41.

²¹⁰ Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо, Коронавирусийн өвчний талаарх мэдэгдэл (КОВИД-19) цар тахлын болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай мэдэгдэл, E / C.12 / 2020/1, 2020 оны 4-р сарын 17, <http://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=4slQ6QSmIBEDzFEovLCuW1AVC1nkPsgUedPIF1vfPMKXidSV%2fGyVFSAvr6nizxSlX6zd%2bu5KD26NraabjKaWMnkFhhMb4MahybE5l%2foU5sQSh6PCbcepqzI0iCYklyq>

9. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

« Хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан тохиолдолд өвчний ямар шинж тэмдэг илэрч байгаагаас үл хамааран аливаа өвчтөнийг эмчлэхдээ эмнэлгийн ажилтан бид айхгүй.»

Эмнэлгийн ажилтан, Нигер улс²¹¹

«Бид шаргуу ажиллаж ирсэн... цаашид ч ажиллахад бэлэн байна. Гэвч зохих дэмжлэггүйгээр ажиллахад бэрх байна».

Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, Энэтхэг²¹²

Энэхүү тайланд эрүүл мэндийн болон зайлшгүй ажилтнуудад тулгамдаж байгаа ноцтой асуудлууд, тэдний эрхийг зохих ёсоор бүрэн хангаж чадахгүй байгаа талаар олон жишээ дурдсан. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөлийн хувьд хэд хэдэн орны эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд зохих хувийн хамгаалах хэрэгсэл дутагдалтай, цалин хөлс, нөхөх олговороо зохих ёсоор аваагүй, ажлын хэт ачаалал зэргээс шалтгаалан сэтгэлийн хямрал, стресст өртөх зэрэг бэрхшээлийг даван туулж байна. Зарим оронд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг дэмжихийн оронд төрөөс болон ажил олгогчдын зүгээс тэднийг ажлын нөхцөл байдлын талаар нийтэд мэдээлсэн, эсвэл эрх баригчдаас авч байгаа хариу арга хэмжээг шүүмжилснийх нь төлөө хатуу шийтгэж байна. Түүнчлэн эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг эрхэлж буй ажил үүрэгтэй нь холбоотойгоор нийгмийн гишүүдийн зүгээс гутаан доромжлох, заналхийлэл, халдлагад өртөж байна. Иймэрхүү олон асуудал цар тахал өвчний үед хурцаар тавигдах болсны зэрэгцээгээр эдгээр нь эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн тогтолцоонд олон жилийн турш нөлөөлж ирсэн урт хугацааны бүтцийн асуудлууд болох хөрөнгө оруулалт дутмаг, бэлэн байдал хангалтгүй, дэд бүтэц муу, эрүүл мэндийн тогтолцоонд хүний эрхийн асуудал хангалтгүй тусгагдсан байдал нөлөөлж байна. Ямар ч шалтгаанаас үл хамааран эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг зохих ёсоор хамгаалах цаг болсон ба бүх улс орнууд үүнийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

²¹¹ Нигерийн Эмнести Интернэшнлийн Олон нийтийн Мэдэгдэл, Нигер улс: Эрх баригчид COVID-19-ийн эсрэг тэргүүн эгнээнд тэмцэж байгаа эрүүл мэндийн ажилтнуудаа хамгаалах ёстой, 2020 оны 5 сарын 1, AFR 44/2264/2020, <https://www.amnesty.org/download/Documents/AFR4422642020ENGLISH.pdf>

²¹² Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудтай хийсэн ярилцлага, India, 4-5 сар 2020 он

Энэхүү үүргээ хангалттай биелүүлээгүйгээс үүсэх цаашдын үр дагаврыг хүн бүр үүрэх хэрэгтэй болно.

Энэхүү тайлан гарах үед цар тахал зарим улс оронд намдаж, бусад улс оронд илүү эрчимжиж байсан. Эмнести Интернэшнл нь хэд хэдэн оронд нөхцөл байдлыг тандаж ирсэн ба энэхүү тайланд багтаасан сургамж, зөвлөмж нь бүх нийтэд хамаатай. Энэхүү цаг мөчид тахлын хамгийн хүнд нөхцөл байдалд байгаа улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг хамгаалах доор дурдсан зөвлөмжийг нэн даруй хэрэгжүүлэх ёстой. Цар тахалд хараахан хүндээр нэрвэгдээгүй байгаа улс орнууд цаг хугацаатай өрсөн эрүүл мэндийн тогтолцоогоо болзошгүй аюулд бэлтгэх, цар тахал дэгдсэн тохиолдолд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг бүрэн хамгаалах дэд бүтэцтэй болсон байхад анхаарах хэрэгтэй. Цар тахлын хамгийн аймшигт үзэгдлийг үзсэн улс орнууд өөрсдийгөө болзошгүй “хоёр дахь давалгаанд” бэлтгэхээс гадна эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын санаа зовнин гаргаж ирсэн асуудлуудын мөрөөр буюу тэдний эрх бүрэн хамгаалагдаагүй асуудалд хариуцлага тооцох хэрэгтэй.

Дээрх мэдээлэлд үндэслэн Эмнести Интернэшнл КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг зохих ёсоор хамгаалагдах нөхцөлийг хангахын тулд дараах зөвлөмжийг өгч байна:

- Улс орнууд цар тахлын үед ямар ажилтнуудыг “зайлшгүй шаардлагатай” буюу “гол мэргэжлийн” гэж тооцох; тэдний эрх хэмжээг тодорхой болгох, тухайлбал, шаардлагатай тохиолдолд ямар ч хөл хорио, цагийн хязгаарлалтыг үл харгалзан зорчих эрхтэй гэх мэт тодорхой, үндэслэл бүхий олон нийтийн удирдамжаар хангах ёстой. Үүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх чиглэлээр ажиллаж байгаа бүх хүн, мөн энэ хугацаанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн, зайлшгүй шаардлагатай үйлчилгээ эрхэлдэг салбарын ажилчдыг хамруулах,
- Хувийн салбарын ажил олгогчид зэрэг төрийн бус оролцогчид хүний эрхийг хүндэтгэх, хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Улс орнууд энэ эрхийг үр дүнтэй зохицуулан, хэрэгжүүлэх ёстой бөгөөд үүнийг төрийн болон хувийн ажил олгогчид нэгэн адил дагаж мөрдөхийг хуульчлах ёстой,
- Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хамгаалах, КОВИД-19-ийн эсрэг авах хариу арга хэмжээнд оролцсонтой холбоотой хүртэх урамшууллыг ажлын гэрээний нөхцлөөс (байнгын эсвэл түр зуурын болон албан, албан бус салбарт ажиллаж байгаа эсэх, энэ албан тушаалд хэр удаан ажиллаж байгаа эсэхээс) үл хамааран адилхан олгох ёстой.

ХӨДӨЛМӨРИЙН ШУДАРГА ТААТАЙ НӨХЦӨЛ

а. КОВИД-19-ийн халдвар болон нас баралт

- Цаашид гарах халдвараас үр дүнтэй хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд улс орнууд КОВИД-19 халдвар авсан болон нас барсан эрүүл мэндийн болон бусад зайлшгүй шаардлагатай ажилтнуудын мэдээллийг ажил мэргэжлээр нь нарийвчлан цуглуулж, нийтэлж байх. Энэ мэдээллийг ялгаварлан гадуурхлаас ангид байх үндэслэлээр, аль болох хүйс, гарал угсаа ба үндэстнээр нь ялгаж салгасан байх.

б. Хувийн хамгаалах хэрэгслийн хомс байдал

- Улс орнууд ажил олгогчдыг төрийн, эсвэл хувийн хэвшлийн гэдгээс үл хамааран КОВИД-19 халдварын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтнаа олон улсын стандартад нийцүүлэн зохих хувийн хамгаалах хэрэгслээр хангах үүрэгтэйг баталгаажуулах. Хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) хомсдолтойгоос үүдэн эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд өөрсдөө үнийг нь төлсөн, эсвэл худалдаж авсан бол зардлыг буцаан олгох,
- Улс орнууд ажил олгогчдыг төрийн, эсвэл хувийн хэвшлийн гэдгээс үл хамааран ажлын байрыг ажилтнуудад аюулгүй болгохын тулд хүн хоорондын зай барих дүрэм тогтоох, КОВИД-19-ийн үеийн эрүүл мэндийн эрсдлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн ажлын зааварчилгааг тохируулан батлах зэрэг хэрэгжүүлэх боломжтой бүхий л арга хэмжээг хангаж ажиллахыг баталгаажуулах. Ажил олгогчид ажилтнуудыг ажлын байрандаа ирж буцахыг шаарддаг бол тахалын улмаас ажилтнуудад учирч болох эрсдлээс хамгаалагдах нөхцөлийг хангах,

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

Эмнести Интернэшнл

- Улс орнууд өөрсдийн амь нас, эрүүл мэндэд шууд болон ноцтой эрсдэл учруулах хангалттай үндэслэлтэй гэж үзэж, тухайлбал, ХХХ хангалтгүйгээс үүсэх аливаа сөрөг үр дагавраас өөрсдийгөө хамгаалах боломжгүй гэж үзэн ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн ажилтнуудынхаа эрхийг хамгаалах,
- Улс орнууд ХХХ-ийг илүү тэгш хуваарилахын тулд ХХХ-ийн хэрэгцээ шаардлагыг нарийвчлалтай үнэлж, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтанд ХХХ хүрэлцээтэй эсэх, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ХХХ ямар ялгаатай болох, ямар төрлийн ХХХ хомсдолтой байгаа болон хаана илүү дутагдаж байгаа талаарх мэдээллийг цуглуулж, нийтлэх,
- Хэрэв ХХХ-ийн хомсдол үүсвэл улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууддаа чанартай ХХХ түгээх боломжийг нэмэгдүүлэх бүхий л арга хэмжээг авах ёстойг хүлээн зөвшөөрөх. Үүнд:
 - Одоо байгаа ХХХ-ийг бусад салбарын ажилтнуудад түгээхээс өмнө хомсдолын бэрхшээлтэй тулгарч буй эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад хүргэх ажлыг эн тэргүүнд чухалчлах,
 - ХХХ-ийг хурааж нөөцлөн, зохиомол хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах,
 - Бизнес эрхлэгчдэд урамшуулал, дэмжлэг үзүүлэх замаар ХХХ-ийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих,
- Улс орнууд өөрийн болон бусад улс орны хувьд ХХХ, түүний үндсэн түүхий эд, бүтээгдэхүүний хүртээмж, чанарт анхаарч, худалдааны болон үнийн хөнгөлөлт үзүүлэх.

c. **Ажлын ачаалал ба сэтгэцийн эрүүл мэндийн асуудал**

- Шаардлагатай тохиолдолд улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажлын цаг, чөлөөт цаг, ээлжийн амралт, бусад ажлын нөхцөлийг зөвхөн олон улсын хүний эрхийн эрх зүй, хэм хэмжээнд нийцүүлэн, ажилчид болон тэдний төлөөлөгчидтэй зөвшилцөн өөрчлөх ёстой. Иймд аливаа өөрчлөлт нь түр зуурын, зайлшгүй шаардлагатай, дүйцсэн байх ёстой бөгөөд ажилтныг амрах, нөхөн сэргэх хангалттай боломжоор хангах,
- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудынхаа сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад идэвхтэй арга хэмжээ авах:
 - Ажил олгогч нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, тэр дундаа ажлын ээлжийг зохих ёсоор зохицуулах замаар ажлын байран дахь стрессийг бууруулах арга хэмжээ авахыг уриалж, хөдөлмөрийн эрүүл мэндийн стратеги боловсруулж хэрэгжүүлэхийг баталгаажуулах,
 - Ажилтнууд сэтгэцийн эрүүл мэнд болон сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг хаанаас, хэрхэн авч болох талаар мэддэг байх, улс орнууд болон ажил олгогчид ийм үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх,
- Улс орнууд КОВИД-19-ийн халдвар авсан, эсвэл КОВИД-19-ийн халдварын сэжигтэй гэж үзэн хөл хорионд орсон эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд өвчний чөлөө олгох,
- Улс орнууд эрүүл мэндийн салбар болон бусад шаардлагатай үйлчилгээнүүдийг хангалттай ажиллагсадтай байлгах, шаардлагатай бол КОВИД-19 цар тахлын улмаас нэмэгдэж байгаа ажлын ачааллыг тооцон хангалттай тооны эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг авч ажиллуулах нөхцөлийг хангах ёстой.

d. **Ажил ба нөхөн олговор**

- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад цалин хөлс олгохдоо эрхэлж буй ажил нь тэдний эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх, мэргэжлийн онцлогтой холбоотойгоор тулгардаг саад бэрхшээл, хувийн болон гэр бүлийн амьдралд нөлөөлөх нөлөөлөл зэргийг тооцон тохирсон шударга цалин хөлс авах нөхцөлийг хүний эрхийн олон

улсын эрх зүй болон хэм хэмжээнд нийцүүлэн баталгаажуулах. Цар тахлын нөхцөл байдал нь дээр дурдсан хүчин зүйлсийн аль нэгэнд нөлөөлж байгаа бол, тухайлбал, нөхцөл байдал хүндэрсэн, эсвэл ажилтнуудын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө мэдэгдэхүйц ихэссэн тохиолдлуудад эдгээр нөхцөл байдлыг харгалзан улс орнууд ажилтнуудынхаа цалинг нь нэмэгдүүлэх арга хэмжээ авах; Энэхүү өөрчлөлт нь түр ажилтнуудад ч гэсэн хамаарна.

- Улс орнууд КОВИД-19 цар тахлын улмаас нэмэлт бэрхшээлтэй тулгарч байгаа эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад нэмэлт нөхөн олговор, тэтгэмж олгох арга хэмжээ авсан бол (i) эдгээр арга хэмжээ нь бүх ажилтнуудад ижил нөхцөлд ижил боломжтой байх; (ii) эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтнууд нэмэлт нөхөн олговор, хөнгөлөлтийг цаг тухайд нь шуурхай авах нөхцөлийг хангасан байх ёстой. Ингэхдээ зарим эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын ажлын байрны онцлогоос болоод эрүүл мэндэд муугаар нөлөөлж болзошгүй нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалан илүү их эрсдэлтэй тулгарч болохыг хүлээн зөвшөөрөх,
- Улс орнууд эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбар дахь жендэрийн цалингийн зөрүүг арилгах, цалинтай ажилчдын хөдөлмөрлөх зохистой нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хүчин чармайлтаа үргэлжлүүлэх,
- Улс орнууд КОВИД-19 халдварт өвчнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин гэж хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд эрхэлж буй үйл ажиллагааны үр дүнд КОВИД-19-ийн халдвар авсан ажилтнууд мөнгөн нөхөн олговор, эмнэлгийн болон бусад шаардлагатай тусламж авах эрхтэй байх. Үүнд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтан хамрагдах ёстой. Хэрэв эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд КОВИД-19 халдвар авсны улмаас нас барвал гэр бүл болон бусад хамаарал бүхий хүмүүс тэжээгчээ алдсаны нөхөн олговор болон бусад хэлбэрийн тусламж авах,
- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг КОВИД-19 халдварыг илрүүлэх шинжилгээнд цаг тухайд нь хамруулж байх ба КОВИД-19-ийн шинжилгээнд эн тэргүүнд хамрагдах бүлгүүдийн нэг хэсэг болгон баталгаажуулах ёстой.

ШИЙТГЭЛ

- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтан аливаа шийтгэлээс айхгүйгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх боломжтой байх нөхцөлийг хангах, ажил олгогчид нь эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудаа эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдлийн талаар мэдээлэх боломжийг олгодог тогтолцоог бий болгох,
- Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын өмнө тулгамдаж байгаа аюулгүй байдлын асуудлыг сонсож, зохих ёсоор шийдвэрлэх; Эрүүл мэндийн болон аюулгүй байдалтай холбоотой асуудлаар санаа зовниж, гомдол гаргасан ажилтнуудын эсрэг ямарваа нэг шийтгэл оногдуулах ёсгүй.
- Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд эрүүл мэндийн болон аюулгүй байдалтай холбоотой асуудлаар санаа зовниж, гомдол гаргасныхаа төлөө ажлын байран дээрээ ямарваа нэгэн шийтгэл, сахилгын арга хэмжээгээр шийтгэгдвэл, эсвэл ажлаас халагдсан бол эрх бүхий байгууллагууд зохих ёсоор нягтлан шалгаж, шаардлагатай тохиолдолд зохих нөхөн төлбөрийг олгох, ажилд нь буцаан оруулах зэргээр эрхийг нь сэргээх,
- Цар тахлын үед улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын хүний эрхийг хамгаалахад гүйцэтгэх үүргийг олон нийтийн өмнө хүлээн зөвшөөрч, тэднийг ажил үүргээ аливаа хэлмэгдүүлэлт, айлган сүрдүүлэлт, заналхийллээс ангид гүйцэтгэх аюулгүй, ая тухтай орчинг бүрдүүлэх,
- Улс орнууд хүний эрхийг хамгаалахын төлөө ажилладаг эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай бүх ажилтныг хамгаалах ёстой ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван цугларах, шилжин нүүх, хувийн нууцтай байх эрхэд хязгаарлалт тогтоох бол олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу нийгмийн эрүүл мэндийг хамгаалахын тулд, эсвэл өөр нэг хууль ёсны зорилгын дагуу зайлшгүй авах арга хэмжээний хатуу шаардлагыг хангасан тохиолдолд хэрэгжүүлэх,
- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд нь аливаа хэлмэгдүүлэн шийтгэгдэхээс айхгүйгээр тайван цугларах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэх

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД


КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

Эмнести Интернэшнл

боломжоор хангах ёстой. Үүнд: ажилтнуудын эрхийг зөрчихөөс татгалзах, эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн эерэг арга хэмжээ авах, гуравдагч этгээдийн зөрчлөөс хамгаалах, ажилтнуудтай хамтын хэлэлцээр хийх, ажил хаях эрх зэрэг бүх ажилтнуудын эрхийг хүндэтгэх зэрэг багтана.

ДОРМЖЛОЛ БА ХҮЧИРХИЙЛЭЛ

- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эсрэг гутаан доромжлолыг арилгахын тулд үнэн зөв, нотолгоонд суурилсан дараах мэдээллийг түгээх: Үүнд
 - КОВИД-19 халдварын тухай болон өвчин хэрхэн тархдаг, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх боломжтой талаар хүмүүст мэдээлэх, ингэснээр хүмүүс буруу мэдээлэлд биш нотолгоонд үндэслэсэн арга хэмжээ авах,
- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг нийгмийн гутаан доромжлолд өртөх, үүнээс болж ажил үүргээсээ татгалзах эрсдэлийг багасгах зорилгоор шаардлагатай тохиолдолд, орон байртай болгох зэрэг үйлчилгээнд хамруулах,
- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг ажилдаа ирж, очих аюулгүй тэврээр хангах (жишээлбэл, хорио цээрийн арга хэмжээнээс болоод нийтийн тээврийн хэрэгслээр зорчих боломжгүй тул тэднийг тээврийн хэрэгслээр хангах г.м), энэ нь бүгдэд хүртээмжтэй, боломжийн үнэтэй байх ёстой. Ингэхдээ эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай янз бүрийн чиг үүргийн ажилтнуудын өвөрмөц хэрэгцээ, хувийн нөхцөл байдал, хаана амьдарч байгаа, хэдэн цагт хөдөлдөг гэх мэтийг харгалзан үзэх,
- Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг ажиллуулдаг бүх байгууллагын удирдлагууд ажилтнуудынхаа заналхийлэл, гутаан доромжлолд өртөж болзошгүй эрсдэлд дүн шинжилгээ хийж, эдгээр аюулыг арилгахын тулд зохих арга хэмжээ авахыг баталгаажуулах,
- Улс орнууд хөл хорионы болон хязгаарлалтын цагийн байдалд хяналт тавих үүрэг бүхий аюулгүй байдлын ажилтнууд болон бусад холбогдох хүмүүст эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд ажилдаа ирэх, буцах эрхтэй байх талаар мэдээлэх ёстой ба аюулгүй байдлын ажилтнуудын аливаа дарамт, хүчирхийллийн талаарх гомдлыг нэн даруй шалгах,
- Эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эсрэг үйлдэгдсэн аливаа халдлага, хүчирхийллийг төрийн эрх баригчид нэн даруй, хараат бус, шударгаар хянан шалгаж, гэмт этгээдүүдэд хариуцлага тооцох ёстой. Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг ялгаварлан гадуурхахыг ямар ч нөхцөлгүйгээр хориглох ёстой. Ингэхдээ, улс орнууд, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай зарим ажилтнууд өөрсдийн олон талт байдлаасаа хамааран нэмэлт, эсвэл тодорхой эрсдэлд орж болзошгүйг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд үүний эсрэг төрийн зүгээс хариу арга хэмжээ авах,
- Улс орнууд КОВИД-19 цар тахлын үед эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудад тулгарч буй аливаа хүчирхийллийн осол, ялгаварлан гадуурхалт болон гутаан доромжлолыг баримтжуулах тогтолцоог бий болгох ёстой бөгөөд ийм ослыг шуурхай мэдээлж байхыг ажилтнуудад уриалах.



НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖ

- Халдварт өвчнийг эмчлэхийн зайлшгүй нэг чухал хэсэг бол хариуцлага байх ёстой. Төрийн болон бусад этгээдүүд цар тахлын дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээнд бэлэн байгаа эсэхэд иж бүрэн, үр дүнтэй, хараат бус үнэлгээ хийх. Цар тахлын нөхцөл байдлын хүрээнд төрийн байгууллагууд хүний эрхийг, түүний дотор эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын эрхийг зохих ёсоор хамгаалж чадаагүй гэж үзэх үндэслэл байгаа бол улс орнууд эдгээр гомдол нэхэмжлэлд бүхэлд нь найдвартай, ил тод, хараат бус, шударга мөрдөн байцаалт хийх үр дүнтэй, хүртээмжтэй арга хэрэгслийг ханган хариуцлага хүлээлгэх. Ирээдүйд үүсч болох КОВИД-19 цар тахлын давалгаа, эсвэл өөр бусад олон нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт дахин давтагдахгүй байх нөхцөлийг хангах,

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА

сургамж авах,

- Улс орнууд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын үйл ажиллагаанд нөлөөлж буй бүхий л бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхдээ тэдний оролцоог хангах ёстой бөгөөд эрүүл мэнд, нийгмийн салбарын цаашдын шинэчлэл нь хариуцлагатай, ил тод байх зарчимд суурилсан байх ба хүний эрхийн зарчимд бүрэн нийцэж байх,
- Улс орнууд нийгмийн эрүүл мэндийн салбарт төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэх; Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог зохистой санхүүжүүлэх, боловсон хүчнээр хангах төлөвлөгөө боловсруулах. Үүнд хүн бүр эрүүл байх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах, нийгмийн эрүүл мэндийн нэмэгдсэн зардлыг санхүүжүүлэхэд зайлшгүй шаардагдах нийгмийн эрүүл мэндийн зардлын хэмжээг нарийвчилан үнэлсэн үнэлгээг мөн багтаах,
- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөөц бүхий улс орнууд нь КОВИД-19 цар тахалд үр дүнтэй хариу үзүүлэх чадваргүй байгаа бусад улс орнуудад дэмжлэг үзүүлэх яаралтай арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд ингэхдээ гишүүн орны хувьд олон улсын санхүүгийн байгууллагуудыг аль болох боломжоороо дэмжлэг үзүүлэхэд уриалан дуудах,
- Улс орнууд эрүүл байх эрх, ажил хөдөлмөр эрхлэх эрх, нийгмийн хамгааллын эрх, зохистой амьжиргааны түвшин хангагдах эрх зэргийг дотоодын хууль эрх зүйгээрээ хүлээн зөвшөөрч, хамгаалагдсан байх нөхцөлийг хангах,
- Улс орнууд Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пакт; Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон улсын Пакт; 1981 оны Хөдөлмөрийн Аюулгүй байдал, Эрүүл мэндийн (ахуйн) Конвенц; 1964 оны Хөдөлмөрийн Ослын Тэтгэмжийн тухай Конвенц; болон 1977 оны Сувилахуйн ажилтнуудын Конвенцэд гарын үсэг зурж, соёрхон батлах.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЗАНАЛХИЙЛЭЛ ХҮЧИРХИЙЛЛИЙН ДОР, ДУУГАРАХ ЭРХГҮЙ, НҮЦГЭН ГАРААР КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТЭМЦЭГСЭД

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

Дэлхийн хэмжээнд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнууд КОВИД-19 цар тахлын эсрэг онцгой үүрэг гүйцэтгэсэн. Улс орон болгонд тэд хүмүүст шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэхийн төлөө өөрсдийн эрүүл мэнд, амь насаа эрсдэлд оруулан байж, хүнд нөхцөлд маш бага дэмжлэгтэйгээр ажилласан. Энэхүү тайланд халдварт цар тахлын энэ хугацаанд эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудын өмнө тулгарч байсан бэрхшээлүүдийг 63 улс орон, нутаг дэвсгэрийн мэдээлэлд үндэслэн онцолсон. Эмнести Интернэшнлийн хийсэн дүн шинжилгээгээр КОВИД-19 цар тахлын улмаас хамгийн багадаа 3000 гаруй эрүүл мэндийн ажилтнууд амь насаа алджээ. Энэ тоо үүнээс ч илүү өндөр байх магадлалтай ба бусад олон хүн хувийн хамгаалах хэрэгслийн (ХХХ) хомсдолоос шалтгаалан аюултай орчинд ажилласан байна. Тэд аюулгүй байдлынхаа талаар санаа зовнин, асуудлыг гаргаж тавьсныхаа төлөө эрх баригчид болон ажил олгогчдын зүгээс баривчлах, ажлаас нь халах, зарим тохиолдолд олон нийтийн зүгээс хүчирхийлэл, гутаан доромжлол зэрэгтэй нүүр тулсан. Эмнести Интернэшнл энэ тайлан илтгэлдээ засгийн газруудыг хүний эрхийн үүргээ биелүүлж, эрүүл мэндийн болон зайлшгүй шаардлагатай ажилтнуудыг зохих ёсоор хамгаалах талаар тодорхой зөвлөмж тусгалаа.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ИНДЕХ: POL 40/2572/2020
2020 оны 7 сар
amnesty.org
amnesty.mn

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ





**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ
ДАЯН ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН.**


**НЭГ Л ХҮНИЙ ЭРХ
ЗӨРЧИГДВӨЛ ЭНЭ НЬ БИД
БҮГДЭД ХАМААТАЙ.**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих

 info@amnesty.org
mongolia.amnesty@gmail.com

 +44 (0)20 7413 5500
+976 7000 4708

 www.facebook.com/AmnestyGlobal
[www.facebook.com/Amnesty International](http://www.facebook.com/AmnestyInternational)
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл

 @AmnestyOnline